



# ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

№ 8 (437)

## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

- *Монгол Улсын Их Хурлын тухай*

## МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

- *Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэг батлах тухай*
- *Монгол Улсын Их Хурлын Байнгын хорооны бүрэлдэхүүнийг шинэчлэн батлах тухай*
- *Монгол Улсын Их Хурлын дэд хорооны бүрэлдэхүүний тухай*

Улсын Их Хурлын Тамгын газар

Улаанбаатар хот

2006 он





# ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН АЛБАН МЭДЭЭЛЭЛ  
Долоо хоног тутмыг

Улаанбаатар хот

2006 оны хоёрдугаар сарын 28

№8 (437)

## Гарчиг

### Нэг. МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

108.	Монгол Улсын Их Хурлын тухай (Шинэчилсэн найруулга)	185
109.	Монгол Улсын Их Хурлын тухай хууль хүчингүй болсонд тооцох тухай	203
110.	Монгол Улсын Их Хурлын гишүүний эрх зүйн байдлын тухай хууль хүчингүй болсонд тооцох тухай	203

### Хоёр. МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

111.	Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэг батлах тухай	Дугаар 14	204
112.	Монгол Улсын Их Хурлын Байнгын хорооны бүрэлдэхүүнийг шинэчлэн батлах тухай	Дугаар 15	225
113.	Монгол Улсын Их Хурлын дэд хорооны бүрэлдэхүүний тухай	Дугаар 22	227

## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2006 оны 1 дүгээр сарын 26-ны өдөр

Улаанбаатар хот

### МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТУХАЙ

/Шинэчилсэн найруулга/

#### НЭГДҮГЭЭР БҮЛЭГ

##### Нийтлэг үндэслэл

##### 1 дүгээр зүйл. Хуулийн зорилт

1.1. Энэ хуулийн зорилт нь Монгол Улсын Их Хурлын /цаашид "Улсын Их Хурал" гэх/ бүрэн эрх, түүний зохион байгуулалтын бүтэц, бүрэлдэхүүн, Улсын Их Хурлын гишүүний бүрэн эрх, халдашгүй байдал, түүний бүрэн эрхийн баталгааг тогтоох, Улсын Их Хурлын үйл ажиллагаатай холбогдсон бусад харилцааг зохицуулахад оршино.

##### 2 дугаар зүйл. Улсын Их Хурлын тухай хууль тогтоомж

2.1. Улсын Их Хурлын тухай хууль тогтоомж нь Монгол Улсын Үндсэн хууль /цаашид "Үндсэн

хууль" гэх/, энэ хууль болон бусад хууль тогтоомжоос бүрдэнэ.

##### 3 дугаар зүйл. Улсын Их Хурлын үйл ажиллагааны үндсэн зарчим

3.1. Улсын Их Хурлын үйл ажиллагаа нь Монгол Улсын тусгаар тогтнол, бүрэн эрхт байдлыг хамгаалах, ард түмний хүсэл зориг, хууль ёсны ашиг сонирхол, эв нэгдлийг хангах, хууль, ардчилал, шударга ёс, хүний эрх, эрх чөлөөг дээдлэн хангах зарчимд үндэслэнэ.

##### 4 дүгээр зүйл. Улсын Их Хурлын бүрэн эрх

4.1. Улсын Их Хурал нь Үндсэн хуулийн Хорин тавдугаар зүйлд заасан онцгой болон хуулиар тогтоосон бусад бүрэн эрхийг хэрэгжүүлнэ.

*'Монгол Улсын Үндсэн хууль – Төрийн мэдээлэл' эмхтгэлийн 1992 оны 1 дүгээрт нийтлэгдсэн.*

## ХОЁРДУГААР БҮЛЭГ

### Улсын Их Хурлын бүрэлдэхүүн

#### 5 дугаар зүйл. Улсын Их Хурлын бүрэлдэхүүн

5.1. Улсын Их Хурал нь Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн дагуу сонгогдсон 76 гишүүнээс бүрдэх бөгөөд энэхүү бүрэлдэхүүнийг "нийт гишүүн" гэж ойлгоно.

5.2. Ээлжит сонгуулийн дараа нийт гишүүний дөрөвний гурав буюу 57-оос доошгүй гишүүний бүрэн эрхийг хүлээн зөвшөөрсөн тогтоолыг Улсын Их Хурал баталсан бол Улсын Их Хурлыг бүрэн эрхээ хэрэгжүүлэх бүрэлдэхүүнтэйд тооцно.

5.3. Улсын Их Хурлын тухайн бүрэн эрхийн хугацаанд Улсын Их Хурлын гишүүн нас барсан, хүндэтгэн үзэх шалтгаанаар чөлөөлөгдсөн, эсхүл бүрэн эрхийг нь түдгэлзүүлсэн, эгүүлэн татсаны улмаас орон гарсан боловч нөхөн сонгууль явагдаагүй тохиолдолд Улсын Их Хурлын 57-оос доошгүй гишүүний бүрэн эрх хүчинтэй байвал Улсын Их Хурлыг бүрэн эрхээ хэрэгжүүлэх бүрэлдэхүүнтэйд тооцно.

#### 6 дугаар зүйл. Улсын Их Хурлын гишүүн

6.1. Улсын Их Хурлын гишүүн /цаашид "гишүүн" гэх/ бол төрийн эрх барих дээд байгууллагад сонгогдсон ард түмний элч мөн бөгөөд нийт иргэн, улсын ашиг сонирхлыг эрхэмлэн баримтална.

6.2. Гишүүн "Монгол Улсын Их Хурлын гишүүн би ард түмнийхээ элчийн хувьд нийт иргэн, улсын ашиг сонирхлыг эрхэмлэн, төрийн хуулийг дээдлэн сахиж, гишүүний үүргээ чин шударгаар биелүүлэхээ тангараглая" хэмээн төрийн сүлдэнд тангараг өргөнө.

6.3. Гишүүний бүрэн эрхийн хугацаа 4 жил байна.

6.4. Гишүүний бүрэн эрх нь Төрийн сүлдэнд тангараг өргөснөөр эхэлж, Улсын Их Хурлын дараагийн сонгуулиар шинэ сонгогдсон гишүүд тангараг өргөснөөр дуусгавар болно.

6.5. Нөхөн сонгогдсон гишүүний бүрэн эрхийн хугацаа нь орон гарсан гишүүний бүрэн эрхийн үлдсэн хугацаатай адил байна.

6.6. Дор дурдсан тохиолдолд гишүүний бүрэн эрх энэ хуулийн 6.3-т заасан хугацаанаас өмнө дуусгавар болно:

6.6.1. нас барсан;

6.6.2. Монгол Улсын Ерөнхийлөгчөөр сонгогдсон;

6.6.3. гишүүн өөр ажилд шилжих болон хүндэтгэн үзэх бусад шалтгаанаар чөлөөлөгдөх хүсэлтээ өөрөө гаргасныг Улсын Их Хурал хүлээн авсан;

6.6.4. хүндээр өвчилсний улмаас цаашид бүрэн эрхээ хэрэгжүүлэх боломжгүй болсон тухай эмнэлгийн дүгнэлт гарсан;

6.6.5. Үндсэн хуулийн цэц гишүүнийг эгүүлэн татах үндэслэлтэй гэсэн дүгнэлт гаргасныг Улсын Их Хурал хүлээн авсан;

6.6.6. гишүүн гэмт хэрэг үйлдсэн болох нь шүүхийн хүчин төгөлдөр шийтгэх тогтоолоор батлагдсан.

6.7. Энэ хуулийн 6.6.3, 6.6.4-т заасан тохиолдолд гишүүнийг чөлөөлөх, 6.6.5, 6.6.6-д заасан тохиолдолд эгүүлэн татах тогтоол гаргах бөгөөд 6.6.1, 6.6.2-т заасан тохиолдолд гишүүнийг шууд орон гарсан гэж үзэж энэ тухай Улсын Их Хурлаас шийдвэр гаргахгүй.

6.8. Гишүүнийг чөлөөлөх, эгүүлэн татах асуудлыг Төрийн байгуулалтын байнгын хорооны санал, дүгнэлтийг үндэслэн нэгдсэн хуралдаанаар хэлэлцэж хуралдаанд оролцсон гишүүдийн олонхийн саналаар, нууц санал хураалтаар шийдвэрлэнэ.

6.9. Дор дурдсан тохиолдолд гишүүний бүрэн эрхийг түдгэлзүүлнэ:

6.9.1. гэмт үйлдлийнх нь явцад, эсхүл гэмт хэргийн газарт эд мөрийн баримттай нь баривчилж, улмаар бүрэн эрхийг нь түдгэлзүүлэх тухай саналыг Улсын ерөнхий прокурор Улсын Их Хуралд оруулсан;

6.9.2. гишүүнд холбогдуулан эрүүгийн хэрэг үүсгэсэн бөгөөд Улсын ерөнхий прокурор түүний бүрэн эрхийг түдгэлзүүлэх тухай саналыг Улсын Их Хуралд оруулсан.

6.10. Эрх бүхий байгууллага гишүүнийг энэ хуулийн 6.9.1-д заасны дагуу баривчилсан бол энэ тухай Улсын Их Хурлын даргад 3 цагийн дотор нэн даруй мэдэгдэнэ.

6.11. Улсын Их Хурал чуулганы үеэр энэ хуулийн 6.9.1, 6.9.2-т заасан санал хүлээн авсан бол ажлын 2 өдрийн дотор гишүүний бүрэн эрхийг түдгэлзүүлэх эсэх асуудлыг шийдвэрлэнэ.

6.12. Чуулганы чөлөөт цагт энэ хуулийн 6.9.1, 6.9.2-т заасан санал хүлээн авсан бол 24 цагийн дотор ээлжит бус чуулган заргаж чуулганы хуралдаан эхэлснээс хойш ажлын 2 өдрийн дотор гишүүний бүрэн эрхийг түдгэлзүүлэх эсэх асуудлыг шийдвэрлэнэ.

6.13. Гишүүний бүрэн эрхийг түдгэлзүүлэх эсэх асуудлыг Төрийн байгуулалт, Хууль зүйн байнгын хорооны болон Улсын Их Хурлын гишүүний халдашгүй байдлын дэд хорооны санал, дүгнэлтийг үндэслэн нэгдсэн хуралдаанаар хэлэлцэж хуралдаанд оролцсон гишүүдийн олонхийн саналаар, нууц санал хураалтаар шийдвэрлэнэ.

6.14. Гишүүний бүрэн эрхийг түдгэлзүүлэх шаардлагагүй гэсэн шийдвэрийг Улсын Их Хурал гаргасан бол баривчлагдсан гишүүнийг нэг цагийн дотор суллана.

6.15. Гишүүнийг энэ хуулийн 6.6.3, 6.6.4-т заасан үндэслэлээр чөлөөлөх танилцуулгыг Улсын Их Хурлын дэд дарга, 6.6.5, 6.6.6-д заасан үндэслэлээр эгүүлэн татах, 6.9.1, 6.9.2-т заасан үндэслэлээр бүрэн эрхийг нь түдгэлзүүлэх танилцуулгыг Үндсэн хуулийн цэцийн дарга, Улсын дээд шүүхийн Ерөнхий шүүгч, Улсын ерөнхий прокурор тус тус зохих Байнгын хорооны болон нэгдсэн хуралдаанд хийнэ.

6.16. Байнгын хорооны болон нэгдсэн хуралдаан дээр гишүүнийг чөлөөлөх, эгүүлэн татах, бүрэн эрхийг нь түдгэлзүүлэх асуудлыг хэлэлцэхэд гишүүд асуулт тавьж хариулт авах, үг хэлж байр сууриа илэрхийлэх эрхтэй.

## 7 дугаар зүйл. Гишүүний бүрэн эрх

### 7.1. Гишүүн дараахь бүрэн эрхтэй:

7.1.1. үйл ажиллагаандаа нийт иргэн, улсын ашиг сонирхлыг эрхэмлэн баримтлах;

7.1.2. Байнгын хороонд заавал харьяалагдах;

7.1.3. хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэрийн төсөл санаачлах;

7.1.4. санаачилсан хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэрийн төслийг өөрийн саналаар татаж авах;

7.1.5. нэгдсэн болон өөрийн харьяалагддаг Байнгын, дэд, түр хорооны хуралдаанд таслах эрхтэй оролцох;

7.1.6. Улсын Их Хурлын дарга, дэд дарга, Байнгын, дэд, түр хорооны дарга, Улсын Их Хурлын сонгуульд бусад удирдах албан тушаалд сонгогдох, тэдгээрт өөрийн нэрээ дэвшүүлэх;

7.1.7. Байнгын, дэд, түр хорооны бүрэлдэхүүнд орох, нэг Байнгын хорооны бүрэлдэхүүнээс гарч өөр Байнгын хорооны бүрэлдэхүүнд орох;

7.1.8. Улсын Их Хурал, Байнгын, дэд, түр хорооны ажлын хэсэгт хүсэлтээрээ орж ажиллах;

7.1.9. хэлэлцэж байгаа асуудлын талаар асуулт тавьж хариулт авах, санал, дүгнэлт гаргах, санал хураалгах;

7.1.10. зарчмын зөрүүтэй саналаа нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх, санал хураалгах;

7.1.11. Улсын Их Хурлын шийдвэрээр байгуулагддаг байгууллагын бүтэц, бүрэлдэхүүн, сонгогдох буюу томилогдох албан тушаалтны талаар үг хэлж байр сууриа илэрхийлэх, санал, дүгнэлт гаргах;

7.1.12. Улсын Их Хурлаас сонгогдсон буюу томилогдсон албан тушаалтны илтгэл, сонсгол хэлэлцүүлэх, тэдгээрийг эгүүлэн татах, огцруулах санал гаргах;

7.1.13. Ерөнхий сайд, Засгийн газрын гишүүн, Улсын Их Хуралд ажлаа шууд хариуцан тайлагнадаг бусад байгууллагын даргад асуулга, асуулт тавьж хариуг нь хуульд заасан хугацаанд авах, шаардлагатай гэж үзвэл тухайн асуудлаар Улсын Их Хурлын шийдвэрийн төсөл санаачилж хэлэлцүүлэх;

7.1.14. хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэрийн талаар иргэд, байгууллагаас ирүүлсэн саналыг судлан үзэж, шаардлагатай гэж үзвэл төсөл санаачлах, шаардлагагүй бол энэ тухай хариуг бичгээр өгөх;

7.1.15. иргэд, байгууллагаас ирүүлсэн өргөдөл, гомдлыг судлан шийдвэрлэж хариуг нь шууд өгөх, эсхүл хариуцан шийдвэрлэх эрх, үүрэг бүхий байгууллага, албан тушаалтанд шилжүүлж энэ тухай хариу мэдэгдэх;

7.1.16. Улсын Их Хуралд ажлаа шууд хариуцан тайлагнадаг байгууллагын үйл ажиллагаатай танилцах;

7.1.17. хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэрийн биелэлтийн талаар холбогдох байгууллага, албан тушаалтнаас мэдээлэл шаардаж авах;

7.1.18. бүрэн эрхээ хэрэгжүүлэхдээ аль ч байгууллагад чөлөөтэй нэвтэрч, хэнтэй ч хүлээгдэлгүй уулзах, шаардлагатай асуудлаар тайлбар авах;

7.1.19. онцгой чуулган зарласан бол дуудлага хүлээлгүйгээр нэн даруй хүрэлцэн ирэх;

7.1.20. төр, байгууллага, хувь хүний хуулиар хамгаалсан нууцыг чанд хадгалж задруулахгүй байх бүх арга хэмжээ авах;

7.1.21. өвчтэй, чөлөөтэй байх, өвчтэй хүн асрах, гадаад, дотоодод томилолтоор ажиллахаас бусад тохиолдолд нэгдсэн, Байнгын, дэд, түр хорооны хуралдаанд товлосон хугацаанд хүрэлцэн ирж оролцох;

7.1.22. Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийг сахиж ажиллах;

7.1.23. хууль, гишүүний ёс зүй чанд сахиж;

7.1.24. чуулганы хуралдаанд үг хэлэхдээ бусдын нэр төр, алдар хүндэд халдахгүй байх;

7.1.25. Ерөнхий сайд, Засгийн газрын гишүүнээр томилогдвол хавсран ажиллах;

7.1.26. хөрөнгө, орлогын мэдүүлийг тогтоосон журмын дагуу үнэн зөв гаргах.

7.2. Энэ хуулийн 7.1.15-д заасны дагуу гишүүнээс шилжүүлсэн өргөдөл, гомдлыг хүлээн авсан байгууллага, албан тушаалтан нь хуульд заасан хугацаанд асуудлыг шийдвэрлэж хэрхэн шийдвэрлэсэн тухайгаа бичгээр хариу мэдэгдэх үүрэгтэй.

7.3. Гишүүн энэ хуулийн 7.1.5-д заасан таслах эрхийг дор дурдсан тохиолдолд эдлэхгүй.

7.3.1. өөрийг нь Улсын Их Хурлын дарга, дэд дарга, Байнгын, дэд, түр хорооны дарга, Засгийн газрын гишүүнээр сонгох, томилох санал хураалтын үед.

7.3.2. Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгд зааснаас бусад тохиолдолд өөрийнх нь үл харьяалагддаг Байнгын, дэд, түр хорооны хуралдаан санал хураах үед.

7.3.3. өөрийнх нь бүрэн эрхийг түдгэлзүүлэх, эгүүлэн татах эсэх асуудлаар санал хураах үед.

7.3.4. өөрийг нь гэмт хэрэгт холбогдуулан шалгах зөвшөөрлийг эрх бүхий байгууллагад өгөх асуудлаар санал хураах үед.

7.3.5. өөрийг нь сэжигтнээр албадан саатуулах, цагдан хорих, гэр, албан өрөө, тээврийн хэрэгсэл болон биед нь үзлэг, нэгжлэг хийх, түүнчлэн өөрт нь шүүхийн журмаар захиргааны шийтгэл ногдуулах зөвшөөрлийг эрх бүхий байгууллагад өгөх асуудлаар санал хураах үед.

7.3.6. Засгийн газарт итгэл үзүүлэх, түүнийг огцруулах асуудлаар санал хураах үед Засгийн газрын гишүүнээр томилогдсон Улсын Их Хурлын гишүүн.

**8 дугаар зүйл. Улсын Их Хурал дахь олонхи ба цөөнх**

8.1. Сонгуулийн дүнгээр Улсын Их Хуралд 39 ба түүнээс дээш суудал авсан нам, эвслийн бүлгийг Улсын Их Хурал дахь олонхи (цаашид "олонхи" гэх) гэнэ.

8.2. Сонгуулийн дүнгээр Улсын Их Хуралд 38 ба түүнээс доош суудал авсан нам, эвслийн бүлэг, гишүүнийг цөөнх (цаашид "цөөнх" гэх) гэнэ.

8.3. Улсын Их Хурал дахь олонхи, цөөнхийн авсан суудлыг зөвхөн тухайн нам, эвслээс нэр дэвшин сонгогдсон гишүүдийн тоогоор тодорхойлох бөгөөд үүнд бие даан нэр дэвшиж сонгогдсон гишүүнийг оруулж тооцохгүй.

**9 дүгээр зүйл. Улсын Их Хурлын даргыг сонгох**

9.1. Энэ хуулийн 8.1-д заасан нам, эвсэл Улсын Их Хурлын даргын сонгуульд нэр дэвшүүлнэ.

9.2. Аль ч нам, эвсэл энэ хуулийн 8.1-д заасан суудал аваагүй бол хамгийн олон суудал

авсан нам, эвсэл нь бусад нам, эвсэлтэй зөвшилцөн Улсын Их Хурлын даргад нэр дэвшүүлнэ.

9.3. Энэ хуулийн 9.1, 9.2-т заасны дагуу нэр дэвшигчийг холбогдох Байнгын хороо, түүнчлэн шаардлагатай гэж үзвэл нам, эвслийн бүлгүүд хуралдаанаараа хэлэлцэж санал, дүгнэлт гаргана.

9.4. Энэ хуулийн 9.3-т заасны дагуу гаргасан санал, дүгнэлтийг нэгдсэн хуралдаанаар хэлэлцэж санал хураалтыг илээр явуулна.

9.5. Нэр дэвшигч энэ хуулийн 9.4-т заасны дагуу явуулсан санал хураалтаар хуралдаанд оролцсон гишүүдийн олонхийн дэмжлэг авсан бол түүнийг Улсын Их Хурлын даргаар сонгогдсонд тооцож тогтоол батална.

9.6. Нэр дэвшигч нэгдсэн хуралдаанд оролцсон гишүүдийн олонхийн дэмжлэг авч чадаагүй бол өөр хүний нэрийг дэвшүүлж энэ зүйлд заасны дагуу сонгоно.

9.7. Гишүүд Байнгын хороо, нам, эвслийн бүлгийн болон нэгдсэн хуралдаан дээр нэр дэвшигчид асуулт тавьж хариулт авах, үг хэлж байр сууриа илэрхийлэх эрхтэй.

**10 дугаар зүйл. Улсын Их Хурлын даргын бүрэн эрхийн хугацаа, түүнийг хугацаанаас нь өмнө чөлөөлөх, огцруулах**

10.1. Улсын Их Хурлын даргын бүрэн эрхийн хугацаа дөрвөн жил байна.

10.2. Дор дурдсан тохиолдолд Улсын Их Хурлын даргын бүрэн эрх энэ хуулийн 10.1-д заасан хугацаанаас өмнө дуусгавар болно:

10.2.1. нас барсан;

10.2.2. өөр ажилд шилжих болон бусад шалтгаанаар чөлөөлөгдөх хүсэлтээ өөрөө гаргасныг Улсын Их Хурал хүлээн авсан;

10.2.3. хүндээр өвчлөсний улмаас цаашид үүрэгт ажлаа гүйцэтгэх боломжгүй болсон тухай эмнэлгийн дүгнэлт гарсан;

10.2.4. Үндсэн хуулийн цэц Улсын Их Хурлын даргыг огцруулах үндэслэлтэй гэсэн дүгнэлт гаргасныг Улсын Их Хурал хүлээн авсан;

10.2.5. гэмт хэрэг үйлдсэн болох нь шүүхийн хүчин төгөлдөр шийтгэх тогтоолоор батлагдсан.

10.3. Улсын Их Хурлын даргыг чөлөөлөх, огцруулах асуудлыг Төрийн байгуулалтын байнгын хорооны санал, дүгнэлтийг үндэслэн нэгдсэн хуралдаанаар хэлэлцэж хуралдаанд оролцсон гишүүдийн олонхийн саналаар, нууц санал хураалтаар шийдвэрлэнэ.

10.4. Энэ хуулийн 10.2.2, 10.2.3-т заасан тохиолдолд Улсын Их Хурлын даргыг чөлөөлөх,



10.2.4, 10.2.5-д заасан тохиолдолд огцруулах тухай тогтоол батална.

10.5. Улсын Их Хурлын даргыг чөлөөлөх, огцруулах асуудлыг нам, эвслийн бүлэг хуралдаанаараа хэлэлцэж санал, дүгнэлт гарган нэгдсэн хуралдаанд танилцуулж болно.

10.6. Гишүүд Байнгын хороо, нам, эвслийн бүлгийн болон нэгдсэн хуралдаан дээр Улсын Их Хурлын даргыг чөлөөлөх, огцруулах асуудалтай холбогдууран асуулт тавьж хариулт авах, үг хэлж байр сууриа илэрхийлэх эрхтэй.

10.7. Улсын Их Хурлын даргыг чөлөөлөх, огцруулах асуудлыг хэлэлцэх нэгдсэн хуралдааныг олонхийн буюу хамгийн олон суудал авсан нам, эвслийн бүлгээс нэр дэвшиж сонгогдсон дэд дарга даргална.

### 11 дүгээр зүйл. Улсын Их Хурлын даргын бүрэн эрх

11.1. Улсын Их Хурлын дарга нь гишүүнд хууль тогтоомжоор олгосон бүрэн эрхээс гадна дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

11.1.1. Улсын Их Хурлын үйл ажиллагаанд Үндсэн хууль, бусад хуулийг сахин биелүүлэх ажлыг зохион байгуулах;

11.1.2. ээлжит, ээлжит бус чуулган, хүндэтгэлийн хуралдаан зарлах, бэлтгэлийг хангах;

11.1.3. нам, эвслийн бүлэг, Байнгын хороодын саналыг харгалзан чуулганаар хэлэлцэх асуудлын дараалал тогтоох;

11.1.4. Ерөнхийлөгч, Засгийн газартай Улсын Их Хурлыг төлөөлөн харилцах;

11.1.5. Засгийн газрын үйл ажиллагаанд Улсын Их Хурлаас тавих хяналтыг зохион байгуулах;

11.1.6. Улсын Их Хуралд ажлаа шууд хариуцан тайлагнадаг байгууллагын үйл ажиллагааг уялдуулан зохицуулах, тэдгээрийн үйл ажиллагаанд Улсын Их Хурлаас тавих хяналтыг зохион байгуулах;

11.1.7. Улсын Их Хурлын төсвийн тухайд төсвийн ерөнхийлөн захирагчид хуулиар олгосон бүрэн эрхийг хэрэгжүүлэх;

11.1.8. Улсын Их Хурлыг гадаад, дотоодод төлөөлөх;

11.1.9. Улсын Их Хурлын гадаад харилцааны ажлыг зохион байгуулах;

11.1.10. бүрэн эрхээ хэрэгжүүлэхэд нь гишүүдэд бүх талын дэмжлэг үзүүлэх, тэдгээрийг төрийн дээд шагналд тодорхойлох;

11.1.11. гишүүд болон Улсын Их Хуралд ажлаа шууд хариуцан тайлагнадаг байгууллагын даргад гадаад, дотоод томиллолт олгох журам баталж мөрдүүлэх;

11.1.12. Улсын Их Хурлын Тамгын газрын үйл ажиллагааг чиглүүлэн удирдах;

11.1.13. хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэрийн төсөл боловсруулах үүрэг бүхий Засгийн газрын ажлын хэсэгт гишүүдийг оролцуулах асуудлыг нам, эвслийн бүлэг, Байнгын хорооны саналыг харгалзан шийдвэрлэх;

11.1.14. энэ хуулийн 11.1.5, 11.1.6-д заасан хяналт шалгалтын ажлын хэсгийн бүрэлдэхүүн, шалгалтын удирдамжийг батлах, хэрэгжилтийг зохион байгуулахад бүх талын дэмжлэг үзүүлэх;

11.1.15. хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэрийн төсөл, бодлогын баримт бичиг боловсруулах үүрэг бүхий ажлын хэсэг байгуулах;

11.1.16. хуульд заасан бол Улсын Их Хуралд ажлаа шууд хариуцан тайлагнадаг байгууллагын дарга, дэд даргыг томилох санал гаргаж Байнгын хорооны болон нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх;

11.1.17. хууль санаачлагчаас өргөн мэдүүлсэн хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэрийн төслийг Байнгын хороодод харьяаллаар нь хуваарилах;

11.1.18. Улсын Их Хурлын даргын зөвлөхүүдийг ажилд томилох, чөлөөлөх шийдвэр гаргах;

11.1.19. гишүүдийн ажиллах нөхцөл, ахуй хангамжтай холбоотой асуудлыг зохицуулах;

11.1.20. хуульд заасан бусад бүрэн эрх.

11.2. Улсын Их Хурлын дарга энэ хуулийн 11.1-д заасан эрх хэмжээний асуудлаар захираж гаргана.

11.3. Нам, эвслийн бүлэг, Байнгын хороодын үйл ажиллагаа, Улсын Их Хурлын хяналт шалгалтын ажлыг уялдуулан зохицуулах, ээлжит болон ээлжит бус чуулганаар хэлэлцэх асуудлын дараалал тогтоох, тухайн долоо хоногт чуулганы хуралдаанаар хэлэлцэх асуудлын тов, дарааллыг батлах, Улсын Их Хурлын төсвийн төслийн талаар санал оруулах, Улсын Их Хурлын дотоод үйл ажиллагаатай холбогдолтой бусад асуудлыг зөвшилцөх чиг үүрэг бүхий Зөвлөл /цаашид "Зөвлөл" гэх/ Улсын Их Хурлын даргын дэргэд ажиллана.

11.4. Энэ хуулийн 11.3-т заасан Зөвлөлийн бүрэлдэхүүнд Улсын Их Хурлын дэд дарга, нам, эвслийн бүлгийн ахлагч, Улсын Их Хуралд суудал бүхий намын дарга - Улсын Их Хурлын гишүүн, Байнгын, түр хороодын дарга орно.

11.5. Зөвлөлийн бүрэлдэхүүн, ажиллах журмыг Улсын Их Хурлын дарга батална.

11.6. Зөвлөлөөс баталсан чуулганы хуралдааны тов, хэлэлцэх асуудлын чиглэлийг нам,

эвслийн бүлэг, Байнгын, дэд, түр хороод, ажлын хэсэг дагаж мөрдөх үүрэгтэй.

## 12 дугаар зүйл. Улсын Их Хурлын дэд дарга, түүний чиг үүрэг

12.1. Улсын Их Хурлын тухайн сонгуулийн дунд бий болсон нам, эвслийн бүлэг тус бүрээс Улсын Их Хурлын дэд даргыг сонгоно.

12.2. Улсын Их Хурлын дэд даргыг энэ хуулийн 9.3-9.5-д заасан журмын дагуу сонгож, 10.2.2, 10.2.3-т заасан үндэслэлээр чөлөөлж, 10.2.4, 10.2.5-д заасан үндэслэлээр огцруулна.

12.3. Энэ хуулийн 26.4-т зааснаар нам, эвслийн бүлэг тарсан бол тухайн бүлгээс сонгогдсон дэд даргыг чөлөөлж Улсын Их Хурал тогтоол батална.

12.4. Улсын Их Хурлын дэд дарга дараахь чиг үүргийг хэрэгжүүлнэ:

12.4.1. Байнгын, дэд, түр хороо, нам, эвслийн бүлгийн үйл ажиллагааг уялдуулан зохицуулах;

12.4.2. Байнгын хорооны болон нэгдсэн хуралдааны ирц бүрдүүлэх ажлыг зохион байгуулах;

12.4.3. Улсын Их Хурлын үйл ажиллагааны дэг, гишүүний ёс зүйн хэм хэмжээний хэрэгжилтэд хяналт тавих;

12.4.4. Улсын Их Хурлын даргаас даалгасан бусад чиг үүрэг;

12.4.5. хууль тогтоомжид заасан бусад чиг үүрэг.

12.5. Улсын Их Хурлын даргын түр эзгүйд түүний даалгаснаар дэд дарга үүргийг нь хэрэгжүүлнэ.

## ГУРАВДУГААР БҮЛЭГ

### Улсын Их Хурлын зохион байгуулалтын бүтэц

#### 13 дугаар зүйл. Улсын Их Хурлын зохион байгуулалтын үндсэн хэлбэр

13.1. Улсын Их Хурал бүрэн эрхээ чуулган, Байнгын болон дэд, түр хороо, намын бүлэг, зохион байгуулалтын бусад хэлбэрээр хэрэгжүүлнэ.

13.2. Улсын Их Хурлын үйл ажиллагааны зохион байгуулалтын үндсэн хэлбэр нь чуулган байдаг.

13.3. Чуулган нь нэгдсэн хуралдаан, Байнгын хороодын дагнасан буюу хамтарсан, түүнчлэн нам, эвслийн бүлгийн хуралдаанаас тус тус бүрдэнэ.

13.4. Хуульд өөрөөр заагаагүй бол энэ хуулийн 13.3-т заасан хуралдаанд тус бүрийнх нь бүрэлдэхүүнд хамрагддаг нийт гишүүний олонхи нь хүрэлцэн ирсэн бол хүчинтэйд тооцно.

13.5. Энэ хуулийн 13.4-т заасан ирцийг ээлжит, ээлжит бус, онцгой чуулганы нээлт, энэ хуулийн 13.3-т заасан хуралдаан эхлэхэд болон санал хураахад заавал бүрдүүлсэн байвал зохино.

13.6. Нэгдсэн хуралдааныг чуулганы хугацаанд долоо хоног бүрийн Пүрэв, Баасан гариг, шаардлагатай бол нам, эвслийн бүлгийн хуралдах хуваарьт өдрөөс бусад ажлын өдрүүдэд зохион байгуулж болно.

#### 14 дүгээр зүйл. Анхдугаар чуулган

14.1. Анхдугаар чуулганыг ээлжит сонгуулийн санал хураалт явуулсан өдрөөс хойш 30 хоногийн дотор Ерөнхийлөгч зарлигаар товлон зарлаж хуралдуулна.

14.2. Ерөнхийлөгч энэ хуулийн 14.1-д заасны дагуу зарлиг гаргахдаа анхдугаар чуулган нээх өдрийг Улсын Их Хурал суудал авсан натуудтай зөвшилцсөн байна.

14.3. Анхдугаар чуулганаар дараахь асуудлыг хэлэлцэн шийдвэрлэнэ:

14.3.1. шинээр сонгогдсон гишүүдийн бүрэн эрхийг хүлээн зөвшөөрөх;

14.3.2. Улсын Их Хурлын дарга, дэд даргыг сонгох;

14.3.3. Байнгын болон дэд хороодын бүрэлдэхүүнийг баталж тэдгээрийн дарга нарыг сонгох;

14.3.4. Ерөнхий сайдыг томилох;

14.3.5. Засгийн газрын бүтэц, бүрэлдэхүүний тухай хууль хэлэлцэн батлах;

14.3.6. Засгийн газрын гишүүдийг томилох.

14.4. Анхдугаар чуулганаар зохион байгуулалтын бусад асуудлыг хэлэлцэн шийдвэрлэж болно.

#### 15 дугаар зүйл. Ээлжит чуулган

15.1. Ээлжит чуулган хагас жил тутам нэг удаа 50-иас доошгүй ажлын өдөр хуралдах бөгөөд намрын чуулганыг 10 дугаар сарын 1-ний, хаврын чуулганыг 4 дүгээр сарын 5-ны өдөр, хэрэв дээрх өдрүүд амралт, баяр ёслолын өдөртэй давхцвал ажлын дараагийн өдөр тус тус нээнэ.

15.2. Ээлжит чуулганаар хэлэлцэх асуудлыг Улсын Их Хурал урьдчилан хэлэлцэж тогтоол гаргах бөгөөд ээлжит чуулган эхлэхээс 7-оос доошгүй хоногийн өмнө Улсын Их Хурлын дарга



ээлжит чуулганаар хэлэлцэх асуудлын дарааллыг тогтоож захирамж гаргана.

15.3. Ээлжит чуулганыг нээж Улсын Их Хурлын дарга үг хэлнэ.

## 16 дугаар зүйл. Ээлжит бус чуулган

16.1. Ээлжит чуулганы чөлөөт цагт ээлжит бус чуулган зарлан хуралдуулж болно.

16.2. Ээлжит бус чуулганыг нийт гишүүний гуравны нэгээс дээшхийн шаардсанаар, эсхүл Ерөнхийлөгч, Улсын Их Хурлын даргын санаачилгаар хуралдуулна.

16.3. Ерөнхийлөгч болон Улсын Их Хурлын гишүүд нь ээлжит бус чуулган хуралдуулах санал, хэлэлцэх асуудлыг Улсын Их Хурлын даргад өргөн мэдүүлнэ.

16.4. Улсын Их Хурлын дарга ээлжит бус чуулганы хэлэлцэх асуудал, хуралдах өдөр, цагийг товлон захирамж гаргана.

16.5. Ээлжит бус чуулганаар зөвхөн Улсын Их Хурлын даргын захирамжид заасан болон түүнтэй шууд холбоотой асуудлыг хэлэлцэнэ.

## 17 дугаар зүйл. Онцгой чуулган

17.1. Ээлжит чуулганы чөлөөт цагт Ерөнхийлөгч онц болон дайны байдал зарлавал түүнээс хойш 72 цагийн дотор Улсын Их Хурлын онцгой чуулган хуралдах бөгөөд гишүүд зар хүлээлгүйгээр хуралдаанд хүрэлцэн ирнэ.

17.2. Онц болон дайны байдал зарласан Ерөнхийлөгчийн зарлигийг онцгой чуулганаар хэлэлцэж зарлиг гарсан өдрөөс хойш 7 хоногийн дотор батлах буюу хүчингүй болгоно.

17.3. Онцгой чуулган Ерөнхийлөгчийн зарлигийг баталсан бол уг зарлигийг хэрэгжүүлэхтэй холбоотой бусад асуудлыг онцгой чуулганаар хэлэлцэж шийдвэрлэнэ.

17.4. Улсын Их Хурлын ээлжит болон ээлжит бус чуулган хуралдаж байх үед онц болон дайны байдал зарлах онцгой нөхцөл үүсвэл тухайн чуулганаар хэлэлцэх аливаа асуудлын дарааллыг үл харгалзан онц болон дайны байдал зарлах тухай асуудлыг эхний ээлжинд хэлэлцэн шийдвэрлэнэ.

## 18 дугаар зүйл. Улсын Их Хурлын хүндэтгэлийн хуралдаан

18.1. Монгол Улсын түүх, тусгаар тогтнол, бүрэн эрхт байдалтай салшгүй холбоотой түүхэн ой, үйл явдлыг тэмдэглэх, түүнчлэн гадаад улсын

өндөр дээд зочин нэгдсэн хуралдаанд үг хэлэх бол хүндэтгэлийн хуралдаан зарлан хуралдуулж болно.

18.2. Улсын Их Хурлын дарга хүндэтгэлийн хуралдаан хуралдуулах тухай захирамж гаргана.

## 19 дүгээр зүйл. Байнгын хороо

19.1. Байнгын хороо нь хууль санаачлагчаас өргөн мэдүүлсэн хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэрийн төслийг урьдчилан хэлэлцэж санал, дүгнэлт гарган нэгдсэн хуралдаанд хэлэлцүүлэх, эрхлэх асуудлын хүрээнд төрийн бодлого, Улсын Их Хурлын үйл ажиллагааг боловсронгуй болгох санал боловсруулах, Улсын Их Хурлын хяналтыг хэрэгжүүлэх чиг үүрэгтэйгээр ажиллана.

19.2. Байнгын хороо тус тусын эрхлэх асуудлын хүрээнд дараахь нийтлэг бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

19.2.1. Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэрийн төслийн талаар санал, дүгнэлт гаргах;

19.2.2. нэгдсэн хуралдаанаар хэлэлцэх тодорхой асуудлаар санал, дүгнэлт гаргах;

19.2.3. Улсын Их Хурлын хянан шалгах чиг үүрэгтэй холбогдсон асуудлаар санал, дүгнэлт гаргах;

19.2.4. Улсын Их Хурлын даалгаснаар, эсхүл өөрийн санаачилгаар Монгол Улсын Засгийн газар /цаашид "Засгийн газар" гэх/-т санал оруулах, хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэр биелүүлэхийг шаардах;

19.2.5. хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэрийн биелэлт, Улсын Их Хуралд ажлаа шууд хариуцан тайлагнадаг байгууллагын үйл ажиллагаанд тавих хяналтыг хэрэгжүүлэх;

19.2.6. Засгийн газар, түүний гишүүн, Улсын Их Хурлаас байгуулдаг бусад байгууллага, тэдгээрийн удирдлагын тайлан, мэдээллийг сонсож хэлэлцэх, тэднийг томилох, сонгох, чөлөөлөх, огцруулах тухай санал, дүгнэлт гаргах;

19.2.7. Чуулганаар хэлэлцэх асуудлаар болон хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэрийн биелэлтийн талаар судалгаа, тайлан, мэдээ, санал, дүгнэлт зэрэг баримт материалыг холбогдох байгууллага, албан тушаалтнаас гаргуулан авах, тэдний мэдээллийг сонсох;

19.2.8. Улсын Их Хурлын хяналтыг хэрэгжүүлэх зорилгоор дагнасан болон холимог бүрэлдэхүүнтэй шалгалтын ажлын хэсэг байгуулж ажиллуулах;

19.2.9. хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэрийн төслийн талаар санал, дүгнэлт гаргахад туслалцаа авах, мэргэжлийн байгууллага болон олон нийтээс санал авах зорилгоор шинжлэх,

мэргэжилтнээс бүрдсэн ажлын хэсэг байгуулж ажиллуулах;

19.2.10. Улсын Их Хурлын бүрэн эрхэд хамаарах асуудлаар гишүүд болон Байнгын хороонд ирүүлсэн өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн байдлыг хуралдаанаараа хэлэлцэх;

19.2.11. Улсын Их Хуралд ажлаа шууд хариуцан тайлагнадаг байгууллагын гаргасан эрх зүйн актыг хянаж, хууль зөрчсөн шийдвэрийг хүчингүй болгуулах арга хэмжээ авах.

19.3. Байнгын хороог төрийн бодлогын салбар, чиглэлээр гишүүдийн бүрэлдэхүүнтэйгээр байгуулах бөгөөд дараахь Байнгын хороодтой байна:

19.3.1. Аюулгүй байдал, гадаад бодлогын;

19.3.2. Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн;

19.3.3. Нийгмийн бодлого, боловсрол, соёл, шинжлэх ухааны;

19.3.4. Төрийн байгуулалтын;

19.3.5. Төсвийн;

19.3.6. Хууль зүйн;

19.3.7. Эдийн засгийн.

**20 дугаар зүйл. Байнгын хороодын эрхлэх асуудлын хүрээ**

Байнгын хороод бүрэн эрхээ дараахь эрхлэх асуудлын хүрээнд хэрэгжүүлнэ.

**20.1. Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороо:**

20.1.1. Монгол Улсын үндэсний аюулгүй байдал;

20.1.2. Монгол Улсын батлан хамгаалах, зэвсэгт хүчин;

20.1.3. төрийн нууцын хадгалалт, хамгаалалт;

20.1.4. гадаад бодлого;

20.1.5. гадаад улс, олон улсын байгууллагад суух бүрэн эрхт төлөөлөгчийн газрын тэргүүнийг томилох асуудал;

20.1.6. Монгол Улсын олон улсын гэрээ, Монгол Улс олон улсын байгууллагад элсэх тухай асуудал.

**20.2. Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хороо:**

20.2.1. газар тариалан, үрийн аж ахуй, хүнсний үйлдвэрлэлийн бодлого;

20.2.2. хүнс, хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний хяналт, тэдгээрийн аюулгүй байдал;

20.2.3. хөдөөгийн хөгжлийн бодлого;

20.2.4. хөдөөг хөгжүүлэх бодлоготой холбоотойгоор хэрэгжих гадаад орны

болон олон улсын байгууллагын зээл тусламжийн асуудал;

20.2.5. мал аж ахуйн бодлого;

20.2.6. малын даатгал болон малын удмын сан, эрүүл мэндийг хамгаалах;

20.2.7. газар, түүний хэвлий, ой, ус, амьтан, ургамал, агаар мандал болон байгалийн бусад байлаг;

20.2.8. улсын тусгай хамгаалалттай газар, бэлчээр, тариалангийн газар;

20.2.9. геологи, уул уурхайн холбогдолтой эрэл, хайгуул, ашиглалтын ажилд тавих байгаль орчны хяналт;

20.2.10. агаарын бохирдол, хорт бодис, байгаль орчны асуудал;

20.2.11. цацрагийн хамгаалалт, аюулгүй байдлын болон цаг уур, орчны хяналтын асуудал;

20.2.12. усны бодлого, нөөц усны бохирдол;

20.2.13. хог хаягдал, дахин боловсруулалт;

20.2.14. байгаль орчны бодлого;

20.2.15. байгаль орчны судалгаа, хөгжил;

20.2.16. ан агнуур.

**20.3. Нийгмийн бодлого, боловсрол, соёл, шинжлэх ухааны байнгын хороо:**

20.3.1. хүн амын бодлого;

20.3.2. хүн амын эрүүл мэнд;

20.3.3. нийгмийн хамгааллын бодлого;

20.3.4. нийтийн биеийн тамир, спортын талаархи бодлого;

20.3.5. хөдөлмөр эрхлэлт, хөдөлмөрийн харилцаа, хөдөлмөр хамгаалалт;

20.3.6. боловсрол;

20.3.7. соёл, урлаг;

20.3.8. шинжлэх ухаан;

20.3.9. ард түмний түүх, соёл, окуны өвийг хамгаалах, сэргээх бодлого.

20.3.10. монгол хэл, бичиг, үндэстний цөөнхийн хэл, бичиг, соёл, урлаг, ёс заншлын талаар төрөөс баримтлах бодлого.

**20.4. Төрийн байгуулалтын байнгын хороо:**

20.4.1. төрийн эрх барих дээд болон гүйцэтгэх дээд байгууллага, Ерөнхийлөгчийн асуудал;

20.4.2. Улсын Их Хурал, Ерөнхийлөгч, аймаг, нийслэл, сум дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгууль;

20.4.3. Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлага, зохион байгуулалт, үйл ажиллагаа, хилийн цах;

20.4.4. төрийн алба.

дуулал; 20.4.5. төрийн бэлгэ тэмдэг, төрийн  
 20.4.6. ард нийтийн санал асуулга;  
 20.4.7. төр, сүм хийдийн харилцаа;  
 20.4.8. хэвлэл мэдээллийн хараат  
 бус байдал; 20.4.9. төрийн байгууллага, улс  
 төрийн нам; 20.4.10. гишүүний бүрэн эрхийн  
 асуудал; 20.4.11. гишүүний ёс зүй;  
 20.4.12. гишүүний хөдөлмөр, ахуйн  
 асуудал; 20.4.13. Улсын Их Хурал, гишүүний  
 төсвийн төлөвлөлт, гүйцэтгэлийн хяналт;  
 20.4.14. гишүүний хөрөнгө, орлогын  
 мэдүүлэг; 20.4.15. чуулганы хуралдааны  
 дэгийн асуудал.

### 20.5. Төсвийн байнгын хороо:

20.5.1. улсын нэгдсэн төсөв, түүний  
 гүйцэтгэл, хяналт;  
 20.5.2. төрийн санхүү, зээлийн  
 болон татварын бодлого;  
 20.5.3. аудитын асуудал;  
 20.5.4. гадаад улс, олон улсын  
 санхүүгийн байгууллагатай байгуулсан зээлийн  
 гэрээ, хэлцэл;  
 20.5.5. Улсын Их Хурлын төсөв.

### 20.6. Хууль зүйн байнгын хороо:

20.6.1. эрх зүйн бодлого;  
 20.6.2. хүний эрх, эрх чөлөө, түүний  
 баталгаа; 20.6.3. гэмт хэрэгтэй тэмцэх,  
 урьдчилан сэргийлэх бодлого;  
 20.6.4. Улсын хил хамгаалалтын  
 бодлого; 20.6.5. хууль зүйн хариуцлага  
 хүлээлгэх эрх зүйн үндэс, ялын бодлого;  
 20.6.6. шүүх, прокурор, хэрэг  
 бүртгэх, мөрдөн байцаах, шүүхийн шийдвэр  
 гүйцэтгэх байгууллага;  
 20.6.7. нийтийн болон хувийн  
 өмчийн эрх зүйн үндэс;  
 20.6.8. эрүү, иргэн, захиргааны  
 байцаан шийтгэх ажиллагаа;  
 20.6.9. өршөөл үзүүлэх асуудал;  
 20.6.10. патент, зохиогчийн эрх,  
 барааны тэмдэг; 20.6.11. цагаачлал, иргэний  
 харьяалал; 20.6.12. архив;  
 20.6.13. эрх зүйн туслалцаа;  
 20.6.14. өмгөөлөл;  
 20.6.15. үл хөдлөх эд хөрөнгө  
 өмчлөх эрхийн бүртгэл.

### 20.7. Эдийн засгийн байнгын хороо:

20.7.1. эдийн засаг, нийгмийн  
 хөгжлийн үндсэн чиглэл;  
 20.7.2. эдийн засгийн дотоод,  
 гадаад бодлого;  
 20.7.3. бүсчилсэн хөгжил;  
 20.7.4. төрийн мөнгөний бодлого,  
 банк, Монголбанкны үйл ажиллагаа;  
 20.7.5. үнэт цаас, даатгалын  
 бодлого; 20.7.6. төрийн өмчийн удирдлага,  
 зохицуулалт, хувьчлалын бодлого;  
 20.7.7. гадаадын хөрөнгө оруулалт,  
 зээл, тусламжийн нэгдсэн бодлого;  
 20.7.8. газрын кадастр, бүртгэл;  
 20.7.9. ашигт малтмалын суурь  
 судалгаа, эрэл хайгуул, ашиглалтын бодлого;  
 20.7.10. газрын тосны асуудал;  
 20.7.11. үйлдвэрлэл, үйлчилгээ,  
 хөрөнгө оруулалтыг дэмжих бодлого;  
 20.7.12. шударга бус өрсөлдөөнийг  
 хязгаарлах бодлого;  
 20.7.13. төрөөс аж ахуй эрхлэлтийг  
 дэмжих бодлого;  
 20.7.14. стандартчилал, хэмжил  
 зүй, чанарын баталгаажуулалт;  
 20.7.15. албан ёсны статистикийн  
 үйл ажиллагааны зохицуулалт;  
 20.7.16. үйлдвэрлэлийн  
 бүтээмжийн өсөлт;  
 20.7.17. барилга, хот байгуулалт;  
 20.7.18. тūлш, эрчим хүч;  
 20.7.19. зам тээвэр, шуудан;  
 20.7.20. орон сууц, нийтийн аж ахуй;  
 20.7.21. аялал жуулчлалын  
 хөгжлийн стратеги;  
 20.7.22. аялал жуулчлалын дэд  
 бүтцийн хөгжил;  
 20.7.23. мэдээлэл, технологийн  
 хөгжил; 20.7.24. харилцаа холбоо;  
 20.7.25. техник, технологийн  
 шинэчлэл.

20.8. Байнгын хороо хууль тогтоомжид  
 нийцсэн дүрэмтэй байх бөгөөд түүнийг  
 хуралдаанаараа батална.

20.9. Байнгын хороо тогтоосон журмаар  
 үйлдсэн тэмдэг, хэвлэмэл хуудас хэрэглэнэ.

20.10. Байнгын хорооны үйл ажиллагааны  
 зардлыг Зөвлөлөөс баталсан хуваарийн дагуу  
 Улсын Их Хурлын төсөвт тусгана.

20.11. Улсын Их Хурлын төсвийн Ерөнхий  
 менежер нь Байнгын хорооны даргын саналаар  
 Байнгын хорооны зардлыг зориулалтын дагуу  
 зарцуулна.

20.12. Байнгын хороо ажлын албатай байна.

## 21 дүгээр зүйл. Байнгын хорооны ажлын зохион байгуулалт

21.1. Байнгын хорооны ажлын зохион байгуулалтын үндсэн хэлбэр нь хуралдаан байна.

21.2. Байнгын хорооны нийт гишүүний олонхи нь хүрэлцэн ирсэн бол хуралдааныг хүчинтэйд тооцно.

21.3. Байнгын хорооны хуралдааныг чуулганы чөлөө цагт зохион байгуулж болно.

21.4. Байнгын хороо эрх хэмжээнийхээ асуудлыг хуралдаанаар хэлэлцэж хуульд өөрөөр заагаагүй бол хуралдаанд оролцсон гишүүдийн олонхийн саналаар шийдвэрлэнэ.

21.5. Ажлын хэсэг байгуулах, түүнчлэн бодлогын баримт бичиг боловсруулах, хуулийн хэрэгжилтийг хангаж зөрчлийг арилгах асуудлаар Засгийн газар, холбогдох бусад байгууллагад чиглэл өгөх шаардлагатай бол Байнгын хороо эрхлэх асуудлын хүрээнд тогтоол гаргаж болно.

21.6. Хууль, дагаж мөрдөж байгаа журамд өөрөөр заагаагүй бол ээлжит ба ээлжит бус чуулганы хугацаанд Байнгын хорооны хуралдааныг долоо хоног бүрийн Мягмар, Лхагва гаригт зохион байгуулна.

21.7. Байнгын хорооны хуралдааны явцыг хуралдааны тэмдэглэлд нэг бүрчлэн тэмдэглэнэ.

## 22 дугаар зүйл. Байнгын хорооны бүрэлдэхүүн

22.1. Байнгын хороо 17-21 гишүүний бүрэлдэхүүнтэй байх бөгөөд гишүүн нэгэн зэрэг хоёроос дээшгүй Байнгын хороонд харьяалагдан ажиллаж болно.

22.2. Гишүүн Засгийн газрын гишүүнээр томилогдсон бол нэг Байнгын хороонд харьяалагдана.

22.3. Байнгын хороог Улсын Их Хурлаас нэг жилийн хугацаагаар сонгосон дарга тэргүүлнэ.

22.4. Байнгын хорооны даргыг тухайн хорооны гишүүдээс сонгох бөгөөд түүнийг улируулан сонгож болно.

22.5. Байнгын хорооны дарга хорооныхоо өдөр тутмын ажлыг удирдаж хуралдааныг даргална.

22.6. Байнгын хорооны дарга 7-оос дээш хоног түр эзгүй байх тохиолдолд түүний саналыг харгалзан Улсын Их Хурлын даргын захирамжаар үүргийг нь аль нэг гишүүнээр орлуулж гүйцэтгүүлнэ.

## 23 дугаар зүйл. Байнгын хорооны даргын чиг үүрэг

23.1. Байнгын хорооны дарга дараахь чиг үүргийг хэрэгжүүлнэ:

23.1.1. Байнгын хорооны хуралдааны бэлтгэлийг хангаж зохион байгуулах;

23.1.2. Байнгын хорооны хуралдааныг удирдах;

23.1.3. Байнгын хорооны нэрийн өмнөөс бусад байгууллагатай харилцах;

23.1.4. Байнгын хорооны ажлын алба болон тодорхой төсөл боловсруулахаар Байнгын хорооноос байгуулсан ажлын хэсгийн үйл ажиллагааг уялдуулан зохицуулах;

23.1.5. Байнгын хорооны ажлыг Улсын Их Хурлын өмнө хариуцан тайлагнах.

## 24 дүгээр зүйл. Дэд хороо

24.1. Байнгын хорооны бүрэлдэхүүнд дор дурдсан дэд хороо байгуулж болно:

24.1.1. Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороонд Тусгай хяналтын;

24.1.2. Нийгмийн бодлого, боловсрол, соёл, шинжлэх ухааны байнгын хороонд Мянганы хөгжлийн зорилтууд болон ядуурлыг бууруулах асуудлыг;

24.1.3. Төрийн байгуулалтын байнгын хороонд Ёс зүйн, Нутгийн удирдлагын, Улсын Их Хурлын гишүүний халдашгүй байдлын;

24.1.4. Төсвийн байнгын хороонд Төсвийн зарлагын хяналтын;

24.1.5. Хууль зүйн байнгын хороонд Хүний эрхийн;

24.1.6. Эдийн засгийн байнгын хороонд Жижиг, дунд үйлдвэрлэлийн хөгжлийн.

24.2. Улсын Их Хурал шаардлагатай гэж үзвэл бусад дэд хороог байгуулж болно.

24.3. Дэд хороод нь харьяалах Байнгын хорооны эрхлэх асуудлын тодорхой хэсгийг дагнан хариуцаж бодлогын баримт бичиг, асуудал боловсруулах буюу санал, дүгнэлт гаргаж, түүнийгээ харьяалах Байнгын хороонд, шаардлагатай бол Байнгын хороогоор уламжлан Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх, түүнчлэн хариуцсан асуудлын хүрээнд хянан шалгах чиг үүргийг хэрэгжүүлэх эрхтэй бөгөөд дараахь асуудлыг эрхэлнэ:

24.3.1. Тусгай хяналтын дэд хороо нь төрийн нууцын хадгалалт, хамгаалалт, тагнуул болон гүйцэтгэх ажлын талаархи хууль тогтоомжийн биелэлт, улсын хил хамгаалалт, төрийн тусгай хамгаалалтын асуудлыг;

24.3.2. Ёс зүйн дэд хороо нь гишүүний ёс зүй, хөрөнгө, орлогын мэдүүлэг, чуулганы хуралдааны дэгийг сахиулах асуудлыг;



24.3.3. Нутгийн удирдлагын дэд хороо нутгийн өөрөө удирдах ёс, нутгийн удирдлагын байгууллагын төлөвшил, хөгжил, удирдлага, зохион байгуулалт, эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох асуудлыг;

24.3.4. Улсын Их Хурлын гишүүний халдашгүй байдлын дэд хороо нь Улсын Их Хурал, түүний гишүүний бүрэн эрхтэй холбогдсон асуудлыг;

24.3.5. Төсвийн зарлагын хяналтын дэд хороо нь улсын болон орон нутгийн төсвийн орлого, зарлага, төсвийн хяналтын асуудлыг;

24.3.6. Хүний эрхийн дэд хороо нь хүний эрх, эрх чөлөөний баталгаа, өршөөл, цагаачлал, иргэний харьяаллын асуудлыг;

24.3.7. Жижиг, дунд үйлдвэрлэлийн хөгжлийн дэд хороо нь жижиг, дунд үйлдвэрлэлийн хөгжил, хөрөнгө оруулалт, эзлэл, тусламжийн бодлого, зохицуулалтын асуудлыг;

24.3.8. Мянганы хөгжлийн зорилтууд болон ядуурлыг бууруулах асуудлын дэд хороо нь Монгол Улсын мянганы хөгжлийн зорилтуудыг хууль тогтоомжид тусган хэрэгжүүлэх асуудлыг.

24.4. Ёс зүйн, Төсвийн зарлагын хяналтын, Тусгай хяналтын, Улсын Их Хурлын гишүүний халдашгүй байдлын дэд хороод өөрсдийн эрхлэх асуудлаар гаргасан санал, дүгнэлтээ нэгдсэн хуралдаанд бие даан оруулж болно.

24.5. Дэд хороо нь тухайн эрхэлсэн асуудлаараа шалгалт, судалгаа хийх, холбогдох мэдээлэл авах, зохих албан тушаалтан, иргэд, байгууллагаас тайлбар авах, өөрийн байгуулсан дагнасан буюу хамтарсан ажлын хэсгээр хяналт шалгалт хийлгэх, эрхэлсэн асуудлаараа тогтоол гаргах, Улсын Их Хурлын шийдвэрийн төсөл боловсруулж харьяалах Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцүүлэх эрхтэй.

24.6. Улсын Их Хурлын гишүүний халдашгүй байдлын дэд хорооноос бусад дэд хорооны бүрэлдэхүүнд зөвхөн харьяалах Байнгын хорооны гишүүд орох бөгөөд дэд хорооны бүрэлдэхүүний тоо нь тухайн Байнгын хорооны гишүүдийн хоёрны нэгээс илүүгүй байна.

24.7. Улсын Их Хурлын гишүүний халдашгүй байдлын дэд хороо нь Улсын Их Хуралд хамгийн олон удаа сонгогдсон дөрвөн гишүүнээс бүрдэх бөгөөд тэрбээр Улсын Их Хурлыг хугацаанаас нь өмнө гараах, гишүүний бүрэн эрхийг түдгэлзүүлэх, эгүүлэн татах талаар энэ хуульд заасан эрх бүхий байгууллага, албан тушаалтнаас Улсын Их Хуралд ирүүлсэн саналыг судалж санал нэгдсэн дүгнэлт гарган зохих Байнгын хорооны болон нэгдсэн хуралдаанд оруулна.

24.8. Дэд хорооны бүрэлдэхүүнд орсон гишүүн харьяалагдах Байнгын хорооны

бүрэлдэхүүнээс гарвал тухайн дэд хорооны бүрэлдэхүүнээс чөлөөлөгдсөнд тооцно.

24.9. Дэд хорооны даргыг харьяалах Байнгын хорооны хуралдаанаар гишүүдийн олонхийн саналар сонгох бөгөөд Төсвийн зарлагын хяналтын болон Ёс зүйн дэд хорооны даргыг цөөнхийн бүлгийн гишүүдээс, хэрэв цөөнхийн бүлэг байгуулах гишүүдийн тоо хүрэхээргүй бол цөөнхийн гишүүдээс сонгоно.

24.10. Дэд хорооны даргын бүрэн эрхийн хугацаа нэг жил байх ба түүнийг улируулан сонгож болно.

24.11. Дэд хорооны үйл ажиллагааны үндсэн хэлбэр нь хуралдаан байх бөгөөд түүнд дэд хорооны гишүүдийн олонхи нь хүрэлцэн ирсэн бол хүчинтэйд тооцно.

24.12. Дэд хороо асуудлыг хуралдаанаар хэлэлцэж оролцсон гишүүдийн олонхийн саналаар шийдвэр гаргана.

24.13. Нэг нам, эвсэл олонхийн суудал аваагүй тохиолдолд Зөвлөл нам, эвслийн бүлгийн зөвшилцлийн үндсэн дээр Байнгын хороо, дэд хорооны даргын суудлыг хуваарилна.

## 25 дугаар зүйл. Түр хороо

25.1. Тодорхой асуудлыг шалган судалж санал боловсруулах, дүнг нэгдсэн хуралдаанд танилцуулах үүрэг бүхий түр хороог Улсын Их Хурлын тогтоолоор байгуулан ажиллуулж болно.

25.2. Түр хороо зөвхөн гишүүдээс бүрдэх бөгөөд түүний бүрэлдэхүүн, ажиллах хугацааг тухай бүр тогтооно.

25.3. Түр хороо хариуцуулсан ажлын гүйцэтгэлийг хангахдаа Байнгын хороотой адил эрх эдэлнэ.

25.4. Түр хороо хариуцуулсан ажлын гүйцэтгэлийг хангаж, ажлынхаа дүнг нэгдсэн хуралдаанд танилцуулан зохих шийдвэр гаргуулмагц түүнийг Улсын Их Хурал татан буулгана.

## 26 дугаар зүйл. Улсын Их Хурал дахь нам /эвсэл/-ын бүлэг

26.1. Улсын Их Хурлын сонгуулийн дүнгээр Улсын Их Хуралд 8-аас доошгүй суудал авсан нам, эвсэл бүлэг /цаашид "бүлэг" гэх/ байгуулж болно.

26.2. Бүлэгт зөвхөн тухайн нам, эвслээс нэр нь албан ёсоор нэр дэвшиж сонгогдсон гишүүд орно.

26.3. Сонгуульд эвсэл байгуулж оролцсон намууд Улсын Их Хуралд 8-аас доошгүй суудал авсан бол эвслийн нэг бүлэг байгуулна.

26.4. Улсын Их Хуралд 8-аас дээш суудал авсан нам татан буугдсан, эвсэл тарсан бол бүлгийг татан буугдсанд тооцох ба түүний бүрэлдэхүүнд байсан гишүүд дахин бүлэг байгуулахыг хориглоно.

26.5. Нам, эвсэл бүлэг байгуулсан тухай шийдвэр, бүлгийн гишүүдийн нэрсийн жагсаалтыг анхдугаар чуулганаар Улсын Их Хурлын даргыг сонсноос хойш 24 цагийн дотор Улсын Их Хурлын даргад өргөн мэдүүлнэ.

26.6. Бүлэг ахлагчаа гишүүдийнхээ дотроос сонгож, энэ тухайгаа Улсын Их Хурлын даргад албан ёсоор мэдээлнэ.

26.7. Бүлэг байгуулсан тухай шийдвэр, бүлгийн гишүүдийн нэрсийн жагсаалтыг Улсын Их Хурлын дарга нэгдсэн хуралдаан дээр албан ёсоор мэдээлнэ.

26.8. Шинээр нөхөн сонгогдсон гишүүн аль нэг бүлэгт нэгдвэл тухайн бүлгийн ахлагч Улсын Их Хурлын даргад, Улсын Их Хурлын дарга нэгдсэн хуралдаанд тус тус албан ёсоор мэдээлнэ.

26.9. Бие даан нэр дэвшиж сонгогдсон болон ээлжит сонгуулиар 8-аас доош суудал авсан өөр нам, эвслийн төлөөлөл бүхий гишүүд нийлж нэг бүлэг байгуулахыг хориглоно.

26.10. Энэ хуулийн 26.9-д заасан гишүүд аль нэг бүлэгт нэгдэж болох бөгөөд энэ тухай шийдвэрийг энэ хуулийн 26.8-д заасны дагуу мэдээлнэ.

26.11. Гишүүд нэг бүлгээс гарч нөгөө бүлэгт нэгдэн орж болох боловч ийнхүү бүлгээс гарсан гишүүд нэгдэж бие даан бүлэг байгуулахыг хориглоно.

26.12. Энэ хуулийн 26.11-д заасны дагуу гишүүн аль нэг бүлгээс гарсан, нөгөө бүлэгт нэгдэн орсон бол тухайн бүлгийн ахлагч Улсын Их Хурлын даргад, Улсын Их Хурлын дарга нэгдсэн хуралдаанд тус тус албан ёсоор мэдээлнэ.

## 27 дугаар зүйл. Бүлгийн эрх, үүрэг

27.1. Бүлэг дараахь эрх, үүргийг хэрэгжүүлнэ:

27.1.1. хэлэлцэж байгаа хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэрийн төсөл, төрийн гадаад, дотоод бодлогын асуудлаар бодлого, байр сууриа тодорхойлж санал, дүгнэлт гарган зохих Байнгын хорооны, эсхүл нэгдсэн хуралдаанаар шууд хэлэлцүүлэх;

27.1.2. ээлжит чуулганаар хэлэлцэх асуудал, түүний дарааллын талаар Улсын Их Хурал болон Улсын Их Хурлын даргад саналаа илэрхийлэх;

27.1.3. нэгдсэн хуралдаанаар хэлэлцэх асуудлын төлөвлөгөөнд өөрчлөлт оруулах санал гаргах;

27.1.4. нэгдсэн болон Байнгын хорооны хуралдааны үед завсарлага авах;

27.1.5. Байнгын, дэд, түр хорооны бүрэлдэхүүний талаар Улсын Их Хурлын даргатай зөвшилцөх;

27.1.6. Улсын Их Хурлын үйл ажиллагааг боловсронгуй болгох саналаа Улсын Их Хурал, Байнгын хороонд оруулах;

27.1.7. бүлгийн төсвийг захиран зарцуулах, гүйцэтгэлийг үнэн зөв мэдээлэх;

27.1.8. нэгдсэн болон Байнгын хорооны үйл ажиллагаанд өөрийн бүлгийн гишүүдийг оролцуулах, хуралдааны ирцийг хангах, хуралдааны дэгийг чанд сахиулах;

27.1.9. хэлэлцэж байгаа асуудалтай холбогдуулан ажлын хэсэг байгуулж ажиллуулах;

27.1.10. бүлгийн ажлын албаны ажилтыг ажилд томилох, чөлөөлөх.

27.2. Бүлэг хоёр гишүүнд нэг ажилтан нэгдөхөөр тооцсон ажлын албатай байх ба гүйцэтгэх үүргийг нь бүлгийн дүрмээр тодорхойлно.

27.3. Бүлгийг ажиллах нөхцөл бололцоогоор хангах асуудлыг Улсын Их Хурлын Тамгын газар хармуцах ба ажлын албаны цалин, унаа, албан томилголт, холбоо, бичиг хэргийн зардлыг Улсын Их Хурлын төсөвт тусгаж санхүүжүүлнэ.

27.4. Бүлэг Улсын Их Хурлын бүтцийн хувьд эрхлэх ажлаа намын дээд, төв, гүйцэтгэх байгууллагын өмнө шууд хармуцахгүй.

27.5. Бүлгийн төсвийн зарцуулалтад Төсвийн зарлагын хяналтын дэд хороо хяналт тавина.

## 28 дугаар зүйл. Бүлгийн үйл ажиллагаа дуусгавар болох

28.1. Дор дурдсан тохиолдолд бүлгийн үйл ажиллагаа дуусгавар болно:

28.1.1. бүлэг байгуулсан нам татан буугдсан, эсхүл эвсэл тарсан;

28.1.2. энэ хуулийн 6.6-д заасан үндэслэлээр орон гарч нөхөн сонгууль явуулсан боловч тухайн нам, эвсэл суудал авч чадаагүйгээс бүлгийн гишүүдийн тоо энэ хуулийн 26.1-д заасан тооны доод хязгаарт хүрэхгүй болсон;

28.1.3. гишүүн бүлгээс гарч үлдсэн гишүүдийнх нь тоо энэ хуулийн 26.1-д заасан доод хязгаарт хүрэхгүй болсон.

28.1.4. бүлэг өөрөө тарах шийдвэр гаргасан.

28.2. Улсын Их Хуралд бүлэгтэй намууд эсхүл нам, эвсэл нэгдсэн бол бүлгүүд нэгдэж шинэ бүлэг байгуулж болно.

28.3. Эвслийн бүлэг тарсны дараа түүний бүрэлдэхүүнд байсан нам Улсын Их Хуралд 8-аас доошгүй суудалтай бол тухайн намаас сонгогдсон гишүүд Улсын Их Хуралд хамтарсан үйл ажиллагаа явуулж болох бөгөөд ингэхдээ энэ хуулийн 27.1.1-27.1.6, 27.1.8-д заасан эрх, үүргийг хэрэгжүүлнэ.

## **29 дүгээр зүйл. Чуулганы хуралдааны нийтлэг журам**

29.1. Хаалттай хэлэлцэхээр хуульд заасан болон төрийн нууцтай холбоотой асуудлыг хаалттай хуралдаанаар хэлэлцэнэ.

29.2. Хэлэлцэх асуудлын шинж байдал, гишүүдийн саналыг харгалзан энэ хуулийн 29.1-д зааснаас бусад асуудлыг хаалттай хуралдаанаар хэлэлцэж болно.

29.3. Энэ хуулийн 29.1, 29.2-т зааснаас бусад тохиолдолд нэгдсэн, Байнгын, дэд, түр хорооны хуралдааныг нээлттэй хийнэ.

29.4. Нам, эвслийн бүлгийн хуралдааны журмыг тэдгээрийн дүрмээр зохицуулна.

29.5. Ерөнхийлөгч нэгдсэн хуралдаанд таалаараа оролцож төрийн гадаад, дотоод бодлогын асуудлаар үг хэлэх, мэдээлэл хийх эрхтэй.

29.6. Засгийн газраас санаачилсан хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэрийн төслийг хэлэлцэхэд Ерөнхий сайд, Засгийн газрын бусад гишүүд чуулганы хуралдаанд оролцож, гишүүдийн асуултад хариулах, тайлбар хийх, Засгийн газрын байр суурийг илэрхийлнэ.

29.7. Засгийн газраас санаачилсан хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэрийн төслийг чуулганы хуралдаанаар хэлэлцэх үед уг асуудлыг хариуцсан Засгийн газрын гишүүн түр эзгүй байгаа бол түүнийг албан ёсоор орлож байгаа Засгийн газрын гишүүн асуудлыг хариуцан хэлэлцүүлнэ.

29.8. Үндсэн хуулийн цэцийн дарга, Улсын дээд шүүхийн Ерөнхий шүүгч, Улсын ерөнхий прокурор, Улсын Их Хуралд ажлаа шууд хариуцан тайлагнадаг байгууллагын дарга нар зөвхөн өөрсдийнх нь хариуцсан ажилтай холбогдолтой асуудлыг хэлэлцэхэд чуулганы хуралдаанд оролцож гишүүдийн асуултад хариулах, тайлбар хийх, байр сууриа илэрхийлнэ.

29.9. Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгд өөрөөр заагаагүй бол нэгдсэн хуралдаанаар хэлэлцэх хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэрийн төслийг зохих Байнгын хороо урьдчилан хэлэлцэж санал, дүгнэлт гаргана.

29.10. Нэгдсэн, Байнгын, дэд, түр хорооны хуралдаанд Тамгын газрын ажилтнууд байлцаж хуралдааны бэлтгэл хангах, үйл явцын тэмдэглэл хөтлөх, гарсан шийдвэрийн танилцуулга, томъёоллын эх бэлтгэх зэргээр чуулганы ажиллагаанд дэмжлэг үзүүлнэ.

29.11. Нам, эвслийн бүлэг энэ хуулийн 29.9-д заасан аливаа төслийг хуралдаанаараа хэлэлцэх эрхтэй боловч ийнхүү хэлэлцээгүй нь асуудлыг Байнгын хорооны болон нэгдсэн хуралдаанаар хэлэлцэхэд саад болохгүй.

29.12. Иргэд, гадаад, дотоодын зочид төлөөлөгчид чуулганы ажиллагаатай танилцах, хэвлэл мэдээллийн байгууллага мэдээлэл, сурвалжлага хийх эрхтэй бөгөөд энэ талаар мөрдөх журмыг Улсын Их Хурлын дарга батална.

29.13. Ажлын зайлшгүй шаардлага гарвал Улсын Их Хурлын дарга Зөвлөлийн саналыг харгалзан чуулганыг 7-14 хоногийн хугацаагаар түр завсарлуулах эрхтэй.

## **ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ**

### **Улсын Их Хурлын бүрэн эрхийн хугацаа**

#### **30 дугаар зүйл. Улсын Их Хурлын бүрэн эрхийн хугацаа**

30.1. Улсын Их Хурлын бүрэн эрхийн хугацаа 4 жил байх бөгөөд энэхүү хугацаа нь Улсын Их Хурлын ээлжит сонгуулиар сонгогдсон гишүүд тангараг өргөснөөр эхэлж, дараагийн сонгуулиар сонгогдсон гишүүд тангараг өргөснөөр дуусгавар болно.

30.2. Үндсэн хуулийн Хорин хоёрдугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасан онцгой нөхцөл үүссэний улмаас ээлжит сонгууль явуулах боломжгүй болсон бол мөнхүү нөхцөл арилж шинээр сонгогдсон гишүүд тангараг өргөтөл өмнөх Улсын Их Хурал бүрэн эрхээ хэрэгжүүлнэ.

30.3. Улсын Их Хурлын ээлжит сонгууль зарласны дараа энэ хуулийн 30.2-т заасан онцгой нөхцөл үүсвэл Улсын Их Хурал ээлжит сонгууль зарласан шийдвэрээ цуцалж сонгуулийн үйл ажиллагааг зогсооно.

30.4. Энэ хуулийн 30.2, 30.3-т заасан нөхцөл байдал үүссэнийг Улсын Их Хурал нээлттэй чуулганаар хэлэлцэж Ерөнхийлөгчтэй санал

тохиролцсоны үндсэн дээр ил санал хураалтаар тогтоол гаргаж шийдвэрлэнэ.

30.5. Энэ хуулийн 30.2-т заасан онцгой нөхцөл арилсны дараа Улсын Их Хурал ажлын 7 хоногт багтаан ээлжит сонгуулийг товлон зарлана.

30.6. Энэ хуулийн 30.5-д заасан хугацаанд Улсын Их Хурлын сонгуулийг товлон зарлаагүй бол дараагийн өдрийг Улсын Их Хурлын сонгууль товлон зарласан өдөрт тооцож, Сонгуулийн ерөнхий хороо ээлжит сонгуулийг зохион байгуулна.

30.7. Энэ зүйлийн 30.4-т заасныг баримтлаагүй бол уг асуудлаар шийдвэр гаргаагүй гэж үзнэ.

### **31 дүгээр зүйл. Улсын Их Хурлын бүрэн эрх хугацаанаас өмнө дуусгавар болох**

31.1. Дор дурдсан тохиолдолд Улсын Их Хурлын бүрэн эрх энэ хуулийн 30.1-д заасан хугацаанаас өмнө дуусгавар болно:

31.1.1. Улсын Их Хурлын нийт гишүүний гуравны хоёроос доошгүй нь Улсын Их Хурал бүрэн эрхээ хэрэгжүүлэх боломжгүй гэж үзэж хугацаанаас нь өмнө тараах тогтоолын төсөл өргөн мэдүүлснийг Улсын Их Хурал хэлэлцэж ёсоор болгосон;

31.1.2. Ерөнхийлөгч Улсын Их Хурлын даргатай зөвшилцөн санал нэгдэж Улсын Их Хурал бүрэн эрхээ хэрэгжүүлэх боломжгүй гэж үзэж хугацаанаас нь өмнө тараах тогтоолын төсөл өргөн мэдүүлснийг Улсын Их Хурал хэлэлцэж ёсоор болгосон;

31.1.3. Ерөнхий сайдыг томилох саналыг өргөн мэдүүлснээс хойш дөчин тав хоногийн дотор Улсын Их Хурал хэлэлцэн шийдвэрлэж чадаагүйгээс Улсын Их Хурлын нийт гишүүний гуравны хоёроос доошгүй нь Улсын Их Хурал өөрөө тарах тухай тогтоолын төсөл өргөн мэдүүлснийг Улсын Их Хурал хэлэлцэж ёсоор болгосон;

31.1.4. энэ хуулийн 31.1.3-т заасан үндэслэлээр Монгол Улсын Ерөнхийлөгч Улсын Их Хурлыг тараах зарлиг гаргасан.

31.2. Энэ хуулийн 31.1.1- 31.1.3-т заасан тогтоолын төслийг Улсын Их Хурлын нийт гишүүний гуравны хоёроос доошгүй нь дэмжсэн бол Улсын Их Хурал тарах тухай шийдвэр гаргана.

31.3. Энэ хуулийн 31.1.1-31.1.3-т заасан тогтоолын төслийг Улсын Их Хурлын ээлжит болон ээлжит бус чуулганы үеэр өргөн мэдүүлсэн бол ажлын 7 хоногийн дотор, чуулганы чөлөөт цагт өргөн мэдүүлсэн бол ээлжит бус чуулганы ажлын 3 хоногт багтаан зарлаж, тухайн асуудлыг хэлэлцэж эхэлснээс хойш ажлын 7 хоногт багтаан шийдвэрлэнэ.

31.4. Улсын Их Хурал өөрөө тарах бол тогтоол, Ерөнхийлөгч Улсын Их Хурлыг тараах бол зарлиг гаргах бөгөөд эдгээр шийдвэр эцсийнх байна.

31.5. Энэ хуулийн 31.1.1-31.1.3-т зааснаар Улсын Их Хурал өөрөө тарах тухай шийдвэр гаргасан бол мөн өдөр Улсын Их Хурлын сонгууль товлон зарлах тухай тогтоолыг хамтад нь батална.

31.6. Ерөнхийлөгч энэ хуулийн 31.1.4-т зааснаар Улсын Их Хурлыг хугацаанаас нь өмнө тараах зарлиг гаргасан бол Улсын Их Хурал уг зарлиг гарснаас хойш 7 хоногийн дотор Улсын Их Хурлын сонгуулийг товлон зарлана.

31.7. Энэ хуулийн 31.5, 31.6-д заасан хугацаанд Улсын Их Хурлын сонгуулийг товлон зарлаагүй бол дараагийн өдрийг Улсын Их Хурлын сонгууль товлон зарласан өдөрт тооцож Сонгуулийн ерөнхий хороо ээлжит сонгуулийг зохион байгуулна.

31.8. Улсын Их Хурлыг хугацаанаас нь өмнө тараах тухай энэ хуулийн 31.1.1- 31.1.3-т заасан тогтоолын төслийг Төрийн байгуулалт, Хууль зүйн байнгын хороод, Улсын Их Хурлын гишүүний халдашгүй байдлын дэд хороо, нам, эвслийн бүлэг урьдчилан хэлэлцэж санал, дүгнэлт гаргана.

31.9. Нэгдсэн хуралдаан Улсын Их Хурлыг тараах тухай тогтоолын төсөл санаачлагчийн илтгэл, Байнгын болон дэд хороо, нам, эвслийн бүлгийн санал, дүгнэлтийг хэлэлцэж ил санал хураалт явуулна.

31.10. Нэгдсэн, Байнгын болон дэд хороо, нам, эвслийн бүлгийн хуралдаан дээр гишүүд төсөл санаачлагчид асуулт тавьж хариулт авах, түүнчлэн үг хэлж байр сууриа илэрхийлэх эрхтэй.

31.11. Улсын Их Хурлыг хугацаанаас нь өмнө тараах асуудлаар Ерөнхийлөгч нэгдсэн хуралдаан дээр үг хэлж байр сууриа илэрхийлж болно.

### **ТАВДУГААР БҮЛЭГ**

#### **Улсын Их Хурал бүрэн эрхээ хэрэгжүүлэх**

### **32 дугаар зүйл. Улсын Их Хурал хууль тогтоох бүрэн эрхээ хэрэгжүүлэх**

32.1. Улсын Их Хурал хууль тогтоох бүрэн эрхээ гагцхүү чуулганаар хэрэгжүүлэх бөгөөд нэгдсэн болон Байнгын хороодын хуралдааныг бэлтгэн явуулах, хуралдаанаар хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэрийн төсөл, тодорхой бусад асуудал хэлэлцэх, санал хураах, батлах, шийдвэр гаргахдаа Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийг баримтална.





32.2. Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийг Улсын Их Хурлын тогтоолоор батална.

### **33 дугаар зүйл. Улсын Их Хурал хянан шалгах бүрэн эрхээ хэрэгжүүлэх**

33.1. Улсын Их Хурал хянан шалгах бүрэн эрхээ дараахь хэлбэрээр хэрэгжүүлнэ:

33.1.1. Засгийн газар болон Улсын Их Хуралд ажлаа шууд хариуцан тайлагнадаг бусад байгууллагын тайлан, мэдээлэл, илтгэл сонсох;

33.1.2. Ерөнхий сайд, Засгийн газрын гишүүн, Улсын Их Хуралд ажлаа шууд хариуцан тайлагнадаг бусад байгууллагын даргад асуулга тавих, түүний хариуг чуулганаар хэлэлцүүлэх;

33.1.3. энэ хуулийн 33.1.2-т заасан албан тушаалтанд асуулт тавьж хариулт авах;

33.1.4. энэ хуулийн 33.1.1-д заасан байгууллага хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэрийг хэрхэн хэрэгжүүлж байгааг хянан шалгаж дүнг Байнгын хорооны, шаардлагатай гэж үзвэл нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх;

33.1.5. Ерөнхий сайд, Засгийн газрын гишүүн, Улсын Их Хурлаас томилогдсон, түүнд ажлаа шууд хариуцан тайлагнадаг байгууллагын дарга, гишүүнтэй холбогдсон ажил хэрэг, ёс зүйн зөрчлийг шалгаж санал, дүгнэлт гаргах.

33.2. Хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэрийн хэрэгжилтийг хэрхэн зохион байгуулж ямар үр дүнд хүрсэн талаар гишүүнээс энэ хуулийн 33.1.2-т заасан албан тушаалтанд бичгээр хандсаныг "асуулга" гэнэ.

33.3. Асуулга хүлээж авсан албан тушаалтан 30 хоногийн дотор хариуг гишүүнд бичгээр өгнө.

33.4. Асуулга тавьсан гишүүн өөрөө хүсвэл түүний хариуг нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлж болно.

33.5. Нэгдсэн хуралдаан асуулгын хариуг хэлэлцсэний үндсэн дээр Улсын Их Хурлаас тодорхой шийдвэр гаргах шаардлагатай гэж үзвэл асуудал хариуцсан Байнгын хороонд энэ талаар чиглэл өгч болно.

33.6. Асуудал хариуцсан Байнгын хороо энэ хуулийн 33.5-д зааснаар нэгдсэн хуралдаанаас өгсөн чиглэлийн дагуу хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэрийн төсөл болон төрийн бодлоготой холбоотой бусад санал боловсруулж санал, дүгнэлтээ нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлж тодорхой шийдвэр гаргуулж болно.

33.7. Төр, нийгмийн ашиг сонирхлыг хөндсөн тодорхой нэг асуудлаар гишүүн энэ хуулийн 33.1.2-т заасан албан тушаалтанд бичгээр хандсаныг "асуулт" гэнэ.

33.8. Асуултыг хүлээн авсан албан тушаалтан хариуг 14 хоногийн дотор гишүүнд бичгээр өгнө.

33.9. Гишүүн шаардлагатай гэж үзвэл асуултын хариуг Байнгын хорооны хуралдаанд танилцуулж, тодорхой арга хэмжээ авах хүсэлтийг шийдвэрийн төслийн хамтаар Байнгын хорооны даргад уламжилж болно.

33.10. Байнгын хороо энэ хуулийн 33.9-д зааснаар гишүүнээс гаргасан хүсэлт, шийдвэрийн төслийг хуралдаанаараа хэлэлцэж санал, дүгнэлтээ нэгдсэн хуралдаанд танилцуулж болно.

33.11. Улсын Их Хурлын дарга, түүнчлэн Байнгын, дэд, түр хороо өөрийн эрхлэх асуудлын хүрээнд хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэрийн хэрэгжилтийг шалгаж санал, дүгнэлт гаргах, шийдвэрийн төсөл боловсруулах үүрэг бүхий ажлын хэсгийг гишүүд, мэргэжилтнүүдийн оролцоотойгоор байгуулан ажиллуулж болно.

33.12. Энэ хуулийн 33.11-д дурдсан ажлын хэсгийн хяналт шалгалтын ажлын хүрээ нь энэ хуулийн 33.1.1-д заасан байгууллагаар хязгаарлагдана.

33.13. Хувийн хэвшлийн, түүнчлэн төрийн болон төрийн өмчийн оролцоотой аж ахуйн нэгжид энэ хуулийн 33.11-д дурдсан ажлын хэсэг хяналт шалгалт явуулахыг хориглоно.

33.14. Энэ хуулийн 33.13-т дурдсан аж ахуйн нэгжид хууль тогтоомжийн хэрэгжилтийг шалгах шаардлага гарвал шалгалтыг төрийн хяналт шалгалтын эрх бүхий байгууллагаар гүйцэтгүүлж дүнг Байнгын хороо, нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлж болно.

33.15. Энэ хуулийн 33.1.5-д дурдсан зөрчлийг шалгах ажлын хэсэг байгуулах эсэх асуудлыг Зөвлөлөөр хэлэлцэж байгуулах нь зүйтэй гэж үзвэл удирдамжийг Улсын Их Хурлын дарга батална.

33.16. Энэ хуулийн 33.1.5-д дурдсан асуудлаар Байнгын, дэд, түр хороо ажлын хэсэг байгуулахыг хориглоно.

## **ЗУРГАДУГААР БҮЛЭГ**

**Гишүүний бүрэн эрхийн баталгаа, төсөв, хавсран гүйцэтгэж болох ажил, албан тушаал, үйл ажиллагаанд нь хориглох зүйл**

### **34 дүгээр зүйл. Гишүүний бүрэн эрхийн баталгаа**

34.1. Гишүүнийг бүрэн эрхээ хэрэгжүүлэхэд нь төрийн байгууллага, тэдгээрийн

албан тушаалтан бүх талын дэмжлэг туслалцаа үзүүлэх үүрэгтэй.

34.2. Гишүүн бүрэн эрхээ хэрэгжүүлэхэд нь Улсын Их Хурлын Тамгын газраас мэргэжил, арга зүйн туслалцаа үзүүлж, техник, зохион байгуулалтын бүх талын нөхцөлөөр хангана.

34.3. Гишүүн бусдыг гэмт хэрэгт холбогдуулан доромжлох, гүтгэхээс бусад тохиолдолд бүрэн эрхийнхээ хүрээнд хэлсэн үг, дэвшүүлсэн санал, өөрийн санаачилсан хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэрийн төсөл, Улсын Их Хурлаар хэлэлцүүлэхээр оруулсан асуудлын төлөө бүрэн эрхийнхээ хугацаанд болон түүний дараа хуулийн хариуцлага хүлээхгүй.

34.4. Гишүүн гадаадад зорчих, байх хугацаандаа дипломат эрх, ямба, дархан эрх эдэлнэ.

34.5. Гишүүн бүрэн эрхийнхээ хугацаанд үнэмлэх, энгэрийн тэмдэг, албаны хэвлэмэл хуудас, "Монгол Улсын Их Хурлын гишүүн" гэсэн тэмдэг, нэрийн хуудас хэрэглэх бөгөөд тэдгээрийн загвар, хэрэглэх журмыг Улсын Их Хурлын даргын захирамжаар батална.

34.6. Гишүүний харилцуур утас болон бусад тусгай хэрэглээний холбооны хэрэгсэл төрийн хамгаалалтад байх бөгөөд бүрэн эрхээ хэрэгжүүлэх, үйл ажиллагаагаа явуулахтай холбогдсон шуудан, захидал харилцааны болон мэдээллийн нууцыг задруулахыг хориглоно.

34.7. Энэ хуулийн 6.9.1-д зааснаас бусад тохиолдолд гишүүнийг албадан саатуулах, цагдан хорих, түүнд шүүхийн журмаар захиргааны шийтгэл оногдуулах, гэр, албан өрөө, тээврийн хэрэгсэл, биед нь үзлэг, ноглалг хийхийг хориглоно.

34.8. Гишүүний бүрэн эрх эдлэхээс өмнөх хугацаанд хууль зөрчсөн үйлдэлд нь холбогдуулан баривчилсан, эрүүгийн хэрэг үүсгэсэн бол энэ хуулийн 6.9.1, 6.9.2-т заасны дагуу бүрэн эрхийг нь түдгэлзүүлнэ.

34.9. Гишүүнээр ажилласан хугацааг нь мэргэжлээрээ ажилласан хугацаанд оруулан тооцно.

34.10. Гишүүний бүрэн эрх дуусгавар болсон бол түүнийг урьд эрхэлж байсан ажил, албан тушаалд нь эгүүлэн ажиллуулах, тийм боломжгүй бол ажил эрхлэх хүртэлх 12 сарын хугацаанд гишүүний цалин, нэмэгдэлтэй тэнцэх нэг удаагийн, бага цалинтай ажилд орсон бол цалингийн зөрүүтэй тэнцэх хэмжээний тэтгэмж, гишүүнээр сонгогдохоосоо өмнө оршин сууж байсан газартаа шилжвэл өөрийнх нь болон гэр бүлийн хөдөлмөрийн чадваргүй гишүүний замын зардал, ачаа, тээсийн хөлсийг авто тээврийн тарифаар тооцож олгоно.

34.11. Гишүүний хууль зөрчсөний улмаас эгүүлэн татсан бол түүнд энэ хуулийн 34.10-т заасан тэтгэмж бусад хангамж олгохыг хориглоно.

34.12. Онцгой чуулган зарласан тохиолдолд гишүүнийг чуулганд хүрэлцэн ирэх боломжийг Ерөнхийлөгч хангаж шаардлагатай бол төрийн тусгай хамгаалалтад авна.

34.13. Гишүүний бүрэн эрхийн хугацаанд түүний амь насна даатгалыг төр хариуцаж даатгалын хураамжийг улсын төсвөөс санхүүжүүлнэ.

34.14. Гишүүн албан үүргээ гүйцэтгэж яваад эрүүл мэнд нь хохирсон тохиолдолд дараахь баталгаагаар хангагдана:

34.14.1. хөдөлмөрийн чадвараа түр алдсан бол эмнэлгийн чөлөөтэй байсан хугацааны тэтгэмж, авч байсан цалингийн зөрүүг олгох;

34.14.2. тахир дутуу болсон тохиолдолд хууль тогтоомжид заасны дагуу тахир дутуугийн тэтгэвэр авч байсан цалингийн зөрүүг олгох;

34.14.3. хиймэл эрхтэн хийлгэх бол түүний зардал, түүнчлэн гишүүнд тусламж, үйлчилгээ үзүүлэх ажилтны хөлс олгох;

34.14.4. гишүүн магадлан итгэмжлэл бүхий эмнэлгийн байгууллагын шийдвэрээр гадаадад эмчлүүлэх зайлшгүй шаардлага гарсан бол зардлынх нь 70-аас доошгүй хувийг төр хариуцах.

34.15. Энэ хуулийн 34.14.2, 34.14.3-т заасан цалингийн зөрүү, хөлсийг гишүүний бүрэн эрхийн хугацаатай адил хугацаагаар олгоно.

34.16. Гишүүн албан үүргээ гүйцэтгэж яваад амь насна алдсан тохиолдолд нь 24 сарын, өвчний улмаас нас барсан бол 18 сарын цалинтай нь тэнцэх хэмжээний нэг удаагийн буцалтгүй тусламж ар гэрт нь олгоно.

34.17. Эмнэлгийн мэргэжилтэн албан үүргээ гүйцэтгэх явцдаа мэдсэн гишүүний эрүүл мэндийн нууцыг задруулахгүй байх үүрэгтэй.

34.18. Аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг дарга, түүний Тамгын газар өөрийн төсөвтөө тусгах үндсэн дээр гишүүн, түүний бие төлөөлөгч-туслахыг албан өрөө, тавилга, техник хэрэгсэлээр хангаж шаардлагатай бусад дэмжлэг туслалцаа үзүүлнэ.

## 35 дугаар зүйл. Гишүүний төсөв, цалин, бусад хангамж

35.1. Гишүүний цалин, нэмэгдэл, унаа, албан томилолт, бичиг хэрэг, холбооны зардлыг Улсын Их Хурлын жилийн төсөвт тусгаж санхүүжүүлнэ.

35.2. Энэ хуулийн 35.1-д заасан зардлын хэмжээг гишүүн тус бүрээр тооцож төсөвт тусгах бөгөөд ингэхдээ тойргийн онцлогийг харгалзаж Улсын Их Хурлаас харилцан адилгүй тогтоож болно.

35.3. Гишүүний сонгогдсон тойрогтоо ажиллахтай холбогдсон зардлын хэмжээг Улсын Их Хурал тогтоох бөгөөд Улс төрийн намын тухай хуулийн дагуу хуваарилагдах хөрөнгийг энэхүү зардалд үл тооцно.

35.4. Гишүүний цалин, түүний туслах, бие төлөөлөгч-туслахын зардал, бүрэн эрхээ хэрэгжүүлэхэд зайлшгүй шаардлагатай бусад хангамжийг Улсын Их Хурал тогтооно.

35.5. Гишүүн үйл ажиллагааныхаа талаар тойргийнхоо сонгогчдод мэдээлэх, сурталчлах зардал болон хэвлэл захиалгын зарим төлбөрийг улсын төсвөөс санхүүжүүлнэ.

35.6. Гишүүний төсвийг Улсын Их Хурлаас баталсан журмын дагуу Тамгын газар тухайн гишүүний зөвшөөрөлтэйгээр зарцуулах бөгөөд зарцуулалтад Төрийн байгуулалтын байнгын хороо хяналт тавина.

35.7. Гишүүн төсвийнхөө цалингийн сангаас бусад зардлыг хооронд нь шилжүүлэн зарцуулж болно.

35.8. Гишүүн төсвийнхөө зарцуулалтын мэдээг Тамгын газраас хүссэн цагтаа авах эрхтэй.

35.9. Гишүүн Засгийн газрын гишүүнээр томилогдвол Засгийн газрын гишүүний цалин хангамжийг авах бөгөөд Улсын Их Хурлын гишүүний төсөвт туссан бусад зардлыг захиран зарцуулах эрхтэй.

35.10. Гишүүний бүрэн эрхийг түдгэлзүүлсэн бол түүний төсвийн зардлын санхүүжилтийг зогсоох бөгөөд сэргээсэн бол түдгэлзүүлсэн өдрөөс эхлэн тооцож гишүүн, түүний туслах, бие төлөөлөгч-туслахын санхүүжилтийг нөхөн олгоно.

### **36 дугаар зүйл. Гишүүн хавсран гүйцэтгэж болох ажил, албан тушаал**

36.1. Гишүүн бүрэн эрхийнхээ хугацаанд дор дурдсан ажил, албан тушаал хавсран гүйцэтгэх эрхтэй:

36.1.1. Ерөнхий сайд, Засгийн газрын гишүүн;

36.1.2. улс төрийн намын сонгуульт албан тушаал;

36.1.3. төрийн бус байгууллагын сонгуульт албан тушаал;

36.1.4. багшлах болон эрдэм шинжилгээний ажил.

36.2. Сонгогдохоосоо өмнө энэ хуулийн 36.1-д зааснаас бусад ажил, албан тушаал эрхэлж

байсан бол гишүүн тангараг өргөхөөсөө өмнө чөлөөлөгдөх шийдвэр гаргуулсан байна.

36.3. Гишүүн Засгийн газрын гишүүнээр томилогдсон бол түүний чуулганы ажиллагаанд оролцох журмыг Ерөнхий сайдын саналыг харгалзан Улсын Их Хурлын дарга захирамжаар батална.

### **37 дугаар зүйл. Гишүүнд хориглох үйл ажиллагаа**

37.1. Гишүүнд дараахь үйл ажиллагаа явуулахыг хориглоно:

37.1.1. ногдсон төсвийг хэтрүүлэх, зориулалтын бусаар зарцуулах;

37.1.2. бүрэн эрхээ хэрэгжүүлэхтэй холбогдуулж бусдаас шан харамж авах;

37.1.3. гишүүний нэр хүнд, бүрэн эрхийг хувийн ашиг сонирхлын үүднээс ашиглах;

37.1.4. гишүүний нэр хүнд, эрх мэдлийг ашиглан үнэт цаас, эд хөрөнгө олох давуу эрх эдлэх, бусдад давуу байдал олгох үйл ажиллагаа явуулах;

37.1.5. Улсын Их Хурлын даргын зөвшөөрөлгүйгээр Засгийн газар, түүний байгууллага, түүнчлэн гадаад, дотоодын аж ахуйн нэгж, байгууллага, иргэний зардлаар гадаадад зорчих;

37.1.6. бүрэн эрхээ хэрэгжүүлэхтэй нь холбогдуулан олгосон санхүүгийн эх үүсвэр, холбоо, мэдээлэл, тээврийн хэрэгсэл, төрийн өмчийн бусад эд зүйлийг ашиг хонжоо олох зорилгоор, эсхүл сонгуулийн компанид ажилд ашиглах;

37.1.7. хууль бус шийдвэр гаргуулахаар бусдад нөлөөлөх;

37.1.8. гишүүний бүрэн эрхэд үл хамаарах асуудлаар бусад байгууллагын үйл ажиллагаанд оролцох, шахалт үзүүлэх;

37.1.9. аливаа байгууллага, иргэнээс нэг сарын цалингийн хэмжээнээс дээш төгрөгийн үнэтэй бэлгийн зүйлсийг хувиараа авах;

37.1.10. бүрэн эрхийнхээ хугацаанд аж ахуй эрхлэх, аж ахуй эрхлэгчдийн холбоонд элсэх, аж ахуйн нэгжийн төлөөлөх болон хяналтын зөвлөлд сонгогдох.

## **ДОЛДУГААР БҮЛЭГ**

### **Бусад зүйл**

### **38 дугаар зүйл. Улсын Их Хурлын ажлын нөхцөл**

38.1. Улсын Их Хурал "Төрийн ордон"-д байрлана.

38.2. Улсын Их Хурал нь гишүүд, Байнгын, дэд түр хорооны үйл ажиллагаанд мэргэжил, арга зүй, техник, зохион байгуулалтын туслалцаа үзүүлэх, ажиллах нөхцөлөөр хангах үүрэг бүхий Тамгын газартай байна.

38.3. Улсын Их Хурал аж ахуй, санхүүгийн хувьд бие даасан байх бөгөөд төсвийг нь Зөвлөлийн саналыг харгалзан Улсын Их Хурал батална.

38.4. Улсын Их Хурлын төсвийн зарцуулалтад Төсвийн зарлагын хяналтын дэд хороо хяналт тавина.

38.5. Улсын Их Хурлын Тамгын газрын үйл ажиллагааны тайланг Тамгын газрын Ерөнхий нарийн бичгийн дарга Төрийн байгуулалтын байнгын хороонд жил бүр танилцуулах бөгөөд шаардлагатай гэж үзвэл Төрийн байгуулалтын байнгын хороо дүнг нэгдсэн хуралдаанд хэлэлцүүлэхээр оруулж болно.

### 39 дүгээр зүйл. Улсын Их Хурлын Тамгын газар, түүний эрхлэх ажил

39.1. Улсын Их Хурлын Тамгын газар /цаашид "Тамгын газар" гэх/ нь дараахь ажлыг эрхлэн гүйцэтгэнэ:

39.1.1. Улсын Их Хурал, Байнгын, дэд, түр хороод, ажлын хэсэг, гишүүдэд мэргэжил, арга зүйн зөвлөгөө өгөх, туслалцаа үзүүлэх;

39.1.2. Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх төслийг хянаж, зохих журмын дагуу өргөн мэдүүлэх бэлтгэлийг хангах;

39.1.3. хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэрийн төсөл өргөн мэдүүлэх, хэлэлцүүлэх, батлах үйл ажиллагааны зохион байгуулалтын бэлтгэлийг хангах;

39.1.4. Улсын Их Хурал, түүний Тамгын газар Улсын Их Хурал дахь нам, эвслийн бүлгийн аж ахуй, санхүүг хөтлөн явуулах, төсвийг хууль тогтоомжийн дагуу зарцуулах;

39.1.5. гишүүдээс хууль санаачлах эрхээ хэрэгжүүлэхэд нь мэргэжил, арга зүйн туслалцаа үзүүлэх;

39.1.6. нэгдсэн, Байнгын, дэд, түр хороод, нам, эвслийн бүлгийн хуралдааны техникийн бэлтгэлийг хангах;

39.1.7. батлагдсан хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэрийн эцсийн найруулга хийх, хэлбэржүүлэн гаргах, нийтлэх, мэдээлэх;

39.1.8. чуулганы явцыг дэс дараалан албан ёсоор тэмдэглэн хөтөлж, уг тэмдэглэлийг ашиглах, хадгалах ажлыг эрхлэн явуулах;

39.1.9. Улсын Их Хурал, түүний Тамгын газрын бичиг хэрэг, албан хэрэг хөтлөлт, архивын үйл ажиллагааг эрхэлж чуулганаар хэлэлцэх асуудалтай холбоотой баримт бичгийг олшруулан тараах ажлыг зохион байгуулах;

39.1.10. Улсын Их Хурлаас олон нийттэй харилцах ажиллагааг зохион байгуулах;

39.1.11. гишүүдэд иргэд, байгууллагаас ирүүлсэн өргөдөл, санал, гомдлын шийдвэрлэлтийн байдлыг нэгтгэн дүгнэж Улсын Их Хурлын дарга, гишүүдэд мэдээлэх;

39.1.12. Улсын Их Хурал, Тамгын газрын гадаад харилцааны асуудлыг хариуцан шаардлагатай баримт бичиг бэлтгэх, Улсын Их Хурлын шугамаар гадаад оронд айлчлах болон гадаадаас ирэх зочин, төлөөлөгчдийг хүлээн авах бэлтгэл хангах, тэдгээрт үйлчлэх;

39.1.13. хянан шалгах чиг үүргээ хэрэгжүүлэхэд нь Байнгын, дэд, түр хороо, ажлын хэсэгт арга зүйн туслалцаа үзүүлэх;

39.1.14. чуулганаар хэлэлцэх хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэрийн төслийн талаар болон гишүүдийн хүссэнээр тодорхой хуулийн хэрэгжилтээр мэдээллийн эх үүсвэрийг бүрдүүлэх;

39.1.15. Монгол Улсын хууль тогтоомжийн мэдээллийн сан бүрдүүлж гишүүдэд үйлчлэх;

39.1.16. хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэрээр даалгасан бусад үүргийг биелүүлэх.

39.2. Тамгын газар нь хуулийн этгээд мөн бөгөөд түүний дүрмийг Улсын Их Хурал батална.

### 40 дүгээр зүйл. Тамгын газрын Ерөнхий нарийн бичгийн дарга

40.1. Тамгын газрыг хуульч мэргэжил бүхий Ерөнхий нарийн бичгийн дарга удирдах бөгөөд түүнийг Улсын Их Хурлын даргын санал болгосны дагуу Улсын Их Хурал томилж, чөлөөлнө.

40.2. Ерөнхий нарийн бичгийн дарга намын харьяалалгүй байх бөгөөд уг албан тушаалд томилогдсон өдрөөс эхлэн намын гишүүнчлэлээс гарсанд тооцно.

40.3. Ерөнхий нарийн бичгийн дарга эрхлэх асуудлаараа захирамж гаргана.

### 41 дүгээр зүйл. Ерөнхий нарийн бичгийн даргын эрхлэх ажил

41.1. Ерөнхий нарийн бичгийн дарга дараахь ажлыг эрхлэн гүйцэтгэнэ:

41.1.1. Тамгын газрын өдөр тутмын ажлыг удирдан зохион байгуулах;

41.1.2. нэгдсэн хуралдаан даргалагчид хууль, дэгийн асуудлаар зөвлөх;

41.1.3. нэгдсэн, Байнгын, дэд, түр хороо, ажлын хэсгийн хуралдааны тэмдэглэл, гаргасан шийдвэрийг эрх зүйн хувьд хэлбэржүүлэх;

41.1.4. Тамгын газрын ажилтан, гишүүний туслах, бие төлөөлөгч-туслахыг томилох, чөлөөлөх;

41.1.5. Улсын Их Хурлаас олон нийттэй харилцах ажлыг зохион байгуулах;

41.1.6. Улсын Их Хурлын төсвийн төслийг бэлтгэх, батлагдсан төсвийг зарцуулах;

41.1.7. Тамгын газрын захиргаа, санхүүгийн хяналтыг хэрэгжүүлэх.

41.2. Ерөнхий нарийн бичгийн дарга нь Улсын Их Хурлын төсвийн ерөнхий менежерийн хувьд холбогдох Байнгын хорооны даргын саналыг харгалзан Байнгын хорооны ажлын албаны ажилтныг томилж, чөлөөлнө.

**42 дугаар зүйл. Улсын Их Хурлын даргын ажлын хэсэг**

42.1. Улсын Их Хурлын дарга бүрэн эрхээ хэрэгжүүлэхэд нь зөвлөгөө өгөх, туслалцаа үзүүлэх үүрэг бүхий зөвлөх, ажлын хэсэгтэй байна.

42.2. Улсын Их Хурлын даргын ажлын хэсгийн орон тооны хязгаар, зардлын төсвийг Улсын Их Хурал тогтооно.

42.3. Улсын Их Хурлын даргын зөвлөх, ажлын хэсгийн ажилтан Улсын Их Хурлын даргад ажлаа шууд хариуцаж Тамгын газарт харьяалагдана.

**43 дугаар зүйл. Улсын Их Хурлын шийдвэр**

43.1. Улсын Их Хурал хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэр гаргах бөгөөд бусад шийдвэр нь тогтоолын хэлбэртэй байна.

43.2. Улсын Их Хурлын тухайн шийдвэрт өөрөөр заагаагүй бол уг шийдвэр албан ёсоор нийтлэгдсэнээс хойш 10 хоногийн дараа хүчин төгөлдөр болно.

43.3. Тухайн хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэрийг хүчин төгөлдөр дагаж мөрдөж эхлэх тусгайлан заасан хугацаа Ерөнхийлөгчийн хориг

тавьсан хугацаатай давхцавал хоригийг хэрхэх тухай асуудлыг Улсын Их Хурал хянан хэлэлцэж дуусах хүртэл уг хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэр бүхэлдээ буюу түүний зарим хэсгийн үйлчлэл түр зогсоно.

43.4. Хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэрийг хэвлэл, мэдээллийн хэрэгслээр нийтэд мэдээлэхдээ "Төрийн мэдээлэл" эмхтгэлд нийтэлсэн албан ёсны эхийг баримтлах бөгөөд дамжуулан нийтэлснийг албан ёсны бус гэж үзнэ.

43.5. "Төрийн мэдээлэл" эмхтгэлд хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэр, Ерөнхийлөгчийн зарлиг, Засгийн газрын тогтоол, Үндсэн хуулийн цэцгийн шийдвэр, хуулийн талаархи Улсын дээд шүүхийн албан ёсны тайлбар, яам, агентлагаас гаргасан нийтээр дагаж мөрдөх эрх зүйн хэм хэмжээ тогтоосон актыг бүрэн эхээр нь нийтэлнэ.

43.6. "Төрийн мэдээлэл" эмхтгэлийг хэвлэн нийтлэх ажлыг Тамгын газар хариуцаж долоо хоног тутам гаргана.

**44 дүгээр зүйл. Улсын Их Хурлын тамга, тэмдэг, хэвлэмэл хуудас**

44.1. Улсын Их Хурал нь тогтоосон журмаар үйлдсэн тамга, тэмдэг, хэвлэмэл хуудас хэрэглэнэ.

**45 дугаар зүйл. Хүчин төгөлдөр болох**

45.1. Энэ хуулийг 2006 оны 1 дүгээр сарын 26-ны өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН  
ИХ ХУРЛЫН ДАРГА Ц.НЯМДОРЖ**

**МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ**

2006 оны 1 дүгээр сарын 26-ны өдөр

Улаанбаатар хот

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТУХАЙ ХУУЛЬ  
ХҮЧИНГҮЙ БОЛСОНД ТООЦОХ ТУХАЙ**

**1 дүгээр зүйл.** Улсын Их Хурлаас 2001 оны 6 дугаар сарын 21-ний өдөр баталсан Монгол Улсын Их Хурлын тухай хуулийг хүчингүй болсонд тооцугай.

**2 дугаар зүйл.** Энэ хуулийг Улсын Их Хурлаас 2006 оны 1 дүгээр сарын 26-ны өдөр

баталсан Монгол Улсын Их Хурлын тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН  
ИХ ХУРЛЫН ДАРГА Ц.НЯМДОРЖ**

**МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ**

2006 оны 1 дүгээр сарын 26-ны өдөр

Улаанбаатар хот

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮНИЙ ЭРХ ЗҮЙН  
БАЙДЛЫН ТУХАЙ ХУУЛЬ ХҮЧИНГҮЙ БОЛСОНД  
ТООЦОХ ТУХАЙ**

**1 дүгээр зүйл.** Улсын Их Хурлаас 1997 оны 2 дугаар сарын 6-ны өдөр баталсан Монгол Улсын Их Хурлын гишүүний эрх зүйн байдлын тухай хуулийг хүчингүй болсонд тооцугай.

**2 дугаар зүйл.** Энэ хуулийг Улсын Их Хурлаас 2006 оны 1 дүгээр сарын 26-ны өдөр

баталсан Монгол Улсын Их Хурлын тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН  
ИХ ХУРЛЫН ДАРГА Ц.НЯМДОРЖ**

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ**

2006 оны 1 дүгээр сарын 27-ны өдөр

Дугаар 14

Улаанбаатар хот

**Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэг батлах тухай**

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.2-т заасныг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1. Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийг хавсралтаар баталсугай.

2. Энэ тогтоол гарсантай холбогдуулан Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны

дэг батлах тухай Улсын Их Хурлын 2001 оны 6 дугаар сарын 21-ний өдрийн 61 дүгээр тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.

3. Энэ тогтоолыг 2006 оны 01 дүгээр сарын 27-ны өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА Ц.НЯМДОРЖ**

*Улсын Их Хурлын 2006 оны 14 дүгээр тогтоолын хавсралт*

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ЧУУЛГАНЫ ХУРАЛДААНЫ ДЭГ****НЭГДҮГЭЭР БҮЛЭГ****Нийтлэг асуудал****1. Нийтлэг зарчим**

1.1. Улсын Их Хурлын нэгдсэн, Байнгын, дэд, түр хороодын хуралдаан /цаашид "хуралдаан" гэх/-ыг зохион байгуулахад Монгол Улсын Үндсэн хууль, Улсын Их Хурлын тухай хууль болон энэхүү дэгийг баримтална.

1.2. Хуралдаан хууль дээдлэх, асуудлыг чөлөөтэй хэлэлцэж цөөнхийн саналыг хүндэтгэн сонсож, олонхийн саналаар шийдвэрлэх зарчмыг удирдлага болгоно.

1.3. Улсын Их Хурлын гишүүн /цаашид "гишүүн" гэх/ хуралдааныг товлон зарласан цагт хүрэлцэн ирэх үүрэгтэй.

**Хоёр. Хуралдааны тов, ирц**

2.1. Нэгдсэн хуралдааныг долоо хоногийн Пүрэв, Баасан гаригт өглөө 10.00 цагаас, үдээс хойш 15.00 цагаас эхэлнэ.

2.2. Ажлын зайлшгүй шаардлага гарвал Улсын Их Хурлын даргын дэргэдэх Зөвлөл /цаашид "Зөвлөл" гэх/-ийн саналыг харгалзан Улсын Их Хурлын дарга нэгдсэн хуралдааныг долоо хоногийн нам, эвслийн бүлгийн хуралдах хуваарьт өдрөөс бусад өдөр зарлан хуралдуулна.

2.3. Энэ дэгд өөрөөр заагаагүй бол нам, эвслийн бүлгийн хуралдааныг долоо хоногийн Даваа гаригт, Байнгын, дэд, түр хороодын хуралдааныг Мянгар, Лхагва гаригт тус тус зохион байгуулна.

2.4. Тухайн долоо хоногт нэгдсэн, Байнгын, дэд, түр хороод, ажлын хэсгийн хуралдаанаар

хэлэлцэх асуудлын товыг Зөвлөлийн саналыг үндэслэн Улсын Их Хурлын дарга тогтооно.

2.5. Бүлэг энэ дэгийн 2.4-т заасан товыг харгалзан тухайн долоо хоногт хуралдаанаараа хэлэлцэх асуудлаа өөрсдөө тогтооно.

2.6. Улсын Их Хурлын дарга нэгдсэн хуралдааныг Байнгын хороо, нам, эвслийн бүлгийн саналаар түр завсарлуулах буюу хугацааг нь сунгаж болно.

2.7. Гишүүн хүндэтгэх шалтгаанаар хуралдаанд ирэх боломжгүй бол хуралдаан даргалагчид урьдчилан мэдэгдэж чөлөө авна.

2.8. Гишүүн өвчтэй байсан буюу өвчтэй хүн асарсан, гадаад, дотоод томилолтоор явсан, түүнчлэн хурал, семинарт зайлшгүй оролцох шаардлагатай байсан бол хүндэтгэх шалтгаантай гэж үзэх бөгөөд эдгээр шалтгаан байхгүй бол хуралдаан тасалсанд тооцно.

2.9 Үндсэн хуулийн тодорхой заалтыг илтэд зөрчсөн асуудал хэлэлцсэн, эсхүл Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулахыг эсэргүүцэхээс бусад шалтгаанаар гишүүн, нам, эвслийн бүлэг хуралдаанд оролцохгүй байх буюу түүнийг орхиж гарахыг хориглоно.

2.10. Энэ дэгийн 2.9-д зааснаас бусад шалтгаанаар гишүүн хуралдаанд оролцоогүй буюу орхиж гарсан бол түүнийг хуралдаанд оролцож эсрэг санал өгсөнд тооцож санал хураалт явуулна.

**Гурав. Хуралдаан явуулах хэлбэр**

3.1. Улсын Их Хурлын тухай хуулийн 29-1-д заасан асуудлыг нууцын горимоор хаалттай хуралдаанаар хэлэлцэнэ.

3.2. Улсын Их Хурлын тухай хуулийн 29.2-т заасны дагуу хуралдаанд оролцсон гишүүдийн олонхийн саналаар асуудлыг хаалттай хуралдаанаар хэлэлцэж болно.

3.3. Энэ дэгийн 3.1, 3.2-т зааснаас бусад тохиолдолд хуралдааныг нээлттэй зохион байгуулна.

3.4. Нам, эвслийн бүлэг энэ дэгийн 3.1-3.3-т заасныг харгалзан хуралдааныхаа дэгийг өөрсдөө тогтооно.

## Дөрөв. Хаалттай хуралдааны дэг

4.1. Энэ дэгийн 3.1-д заасан хаалттай хуралдаанд Ерөнхийлөгч, Ерөнхий сайд, тухайн асуудал хариуцсан Засгийн газрын гишүүн болон холбогдох төрийн бусад байгууллагын дарга, Улсын Их Хурлын Тамгын газрын Ерөнхий нарийн бичгийн дарга /цаашид "Тамгын газрын Ерөнхий нарийн бичгийн дарга" гэх/, мөн газрын нууцын асуудал хариуцсан ажилтан, түүнчлэн тухайн асуудлыг боловсруулахад оролцсон ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг оролцуулж болно.

4.2. Шаардлагатай бол энэ дэгийн 4.1-д зааснаас бусад хүнийг хаалттай хуралдаанд оролцуулж болох бөгөөд тэднээр нууц задруулахгүй байх баталгаар урьдчилан гаргуулна.

4.3. Хаалттай хуралдаанд дуу, дүрс бичлэг хийх, гар утас авч орох, утсаар ярихыг хориглоно.

4.4. Хаалттай хуралдааны талаар зөвхөн нууцын дэвтэрт тэмдэглэл хийнэ.

4.5 Энэ зүйлд заасан журам мөн дэгийн 3.2-т заасан хуралдааныг зохион байгуулахад үл хамарна.

## Тав. Нээлттэй хуралдааны дэг

5.1. Нээлттэй хуралдаанд хэлэлцэж байгаа асуудлыг боловсруулахад оролцсон ажлын хэсгийн бүрэлдэхүүн, түүнчлэн хэвлэл мэдээллийн байгууллагын төлөөлөгчид оролцож болно.

5.2. Нээлттэй хуралдааны явцыг энэ дэгд заасны дагуу дуу, дүрс бичлэг, мэдээллийн бусад техник хэрэгсэл ашиглан бэхжүүлнэ.

## Зургаа. Хуралдаанд үг хэлэх, санал, дүгнэлт гаргах, асуулт асуух журам

6.1. Гишүүн хуралдаанд үг хэлж байр суури илэрхийлэх, санал, дүгнэлт гаргах, тайлбар хийх /цаашид "үг хэлэх" гэх/, асуулт асуухдаа дэгийг чанд сахиж дараахь журмыг баримтална:

6.1.1. үг хэлэх, асуулт асуухдаа урьдчилан мэдэгдэн дараалалд орж хуралдаан даргалагчаас зөвшөөрөл авах;

6.1.2. тогтоосон хугацаанд өөрөө үг хэлэх, асуулт асуух, энэхүү эрхээ бусад гишүүдэд шилжүүлэхгүй байх;

6.1.3. хуралдаан даргалагч зөвшөөрөл өгөөгүй байхад үг хэлэх, асуулт асуух, энэхүү эрхээ эдлэхдээ бүдүүлэг үг хэллэг хэрэглэх, бусдыг доромжлох, нэр төрийг нь гутаах, басамжлах, яриал нь таслах, өмнөөс нь үг хэлэх, өөрийн саналыг дэмжүүлэх буюу бусдын саналыг үгүйсгэх зорилгоор шахалт үзүүлэх, хүч хэрэглэх зэрэг гишүүний ёс зүйд үл нийцэх үйлдэл гаргахгүй байх;

6.1.4. Засгийн газрын бүтэц, бүрэлдэхүүн, Ерөнхий сайд, Засгийн газрын гишүүдийг томилох, чөлөөлөх, огцруулах, Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр, улсын төсөв зэрэг асуудлыг хэлэлцэхэд гишүүн нам, эвслийн бүлэг дээр тогтсон бодлого, зарчмыг удирдлага болгох;

6.1.5. энэ дэгийн 6.1.4-т зааснаас бусад хууль, Улсын Их Хурлын шийдвэрийн төсөл, тодорхой асуудал хэлэлцэхэд гишүүн өөрийн байр сууринаас хандаж үг хэлэх, санал хураалтад оролцох;

6.1.6. үг хэлэх хугацаа 5 минутаас илүүгүй байх;

6.1.7. асуулт асуух хугацаа 4 минутаас илүүгүй, нэмэлт асуулт асуух хугацаа 1 минутаас илүүгүй байх.

6.2. Гишүүний асуултад хариулах хугацаа 4 минутаас илүүгүй, нэмэлт хариулт, тайлбар өгөх хугацаа 1 минутаас илүүгүй байна.

6.3. Тодорхой асуудлыг хэлэлцэхэд энэ дэгийн 6.1.6, 6.1.7, 6.2-т зааснаас өөрөөр заасан бол тусгайлан заасан хугацааг баримтална.

6.4. Нэгдсэн хуралдаан даргалагч нам, эвслийн бүлгийн саналыг харгалзан гишүүдийн үг хэлэх хугацааг нэгтгэн нэг гишүүнд 30 хүртэл минут үг хэлэх эрх олгож болох бөгөөд нам, эвслийн бүлэг энэ тухай хуралдаан даргалагчид урьдчилан мэдэгдсэн байна.

6.5. Хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэрийн төсөл боловсруулах ажлын хэсгийн бүрэлдэхүүнд орсон, түүнчлэн чуулганаар хэлэлцэж байгаа асуудалтай холбогдон уригдаж ирсэн хүмүүс хуралдаан даргалагчийн зөвшөөрснөөр тайлбар хийж асуултанд хариулж болно.

6.6. Нэгдсэн хуралдаан дээр төсөл хэлэлцэхэд зөвхөн тухайн асуудал хариуцсан Засгийн газрын гишүүн, эсхүл дэд сайд нь гишүүдийн асуултад хариулах буюу тайлбар хийнэ.

## Долоо. Хуралдаанд танилцуулга хийх

7.1. Хуралдаанд хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэрийн төслийн талаар хууль санаачлагч танилцуулга хийнэ.

7.2. Улсын Их Хурлын зохион байгуулалт, үйл ажиллагаатай холбоотой шийдвэрийн төслийн танилцуулгыг тухайн асуудал хариуцсан Байнгын хорооноос томилогдсон гишүүн хийж болно.

7.3. Ерөнхийлөгчийн санаачилсан хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэрийн төслийн танилцуулгыг Ерөнхийлөгч өөрөө, эсхүл түүний томилсноор Тамгын газрын дарга буюу зөвлөх нь хийнэ.

7.4. Засгийн газраас санаачилсан хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэрийн төслийн танилцуулгыг Ерөнхий сайд, эсхүл тухайн асуудал хариуцсан Засгийн газрын гишүүн, үг гишүүн түр эзгүй байгаа бол түүнийг хууль ёсоор орлож байгаа гишүүн хийнэ.

7.5. Улсын Их Хуралд ажлаа шууд хариуцан тайлагнадаг байгууллагын үйл ажиллагаатай холбогдсон танилцуулгыг тухайн байгууллагын дарга, түүний түр эзгүйд орлогч нь хийнэ.

## Найм. Хуралдаан даргалагчийн эрх, үүрэг

8.1. Хуралдааныг зохион байгуулах талаар хуралдаан даргалагч дараахь эрх, үүргийг хэрэгжүүлнэ:

8.1.1. хуралдааны товгыг тогтоон зарлаж бэлтгэлийг хангах;

8.1.2. хуралдааныг товчлосон цагт эхлүүлж дэгийн дагуу зохион байгуулж, зөрчигдөөл таслан зогсоох;

8.1.3. саналаа ирүүлсэн дарааллыг баримтлан гишүүдэд асуулт асуух, үг хэлэх зөвшөөрөл өгөх;

8.1.4. гишүүдээс гаргасан горимын саналаар санал хураалт явуулах;

8.1.5. энэ дэгийн 6.5-д заасан хүмүүст гишүүдийн асуултад хариулах, тайлбар хийх зөвшөөрөл өгөх;

8.1.6. санал хураалт явуулж дүнг мэдээлэх;

8.1.7. хуралдааны шийдвэрийг хэлбэржүүлэх, ёсчлох ажлыг зохион байгуулах;

8.1.8. ирц хүрэлцэхгүй байвал хүндэтгэх шалтгаантай гишүүнд чөлөө өгөх;

8.1.9. хууль тогтоомжид заасан бусад эрх, үүрэг.

8.2. Асуудлыг хэлэлцэх журам, дарааллын талаар гишүүнээс гаргасан саналыг горимынх гэх бөгөөд түүгээр нэг удаа санал хураана.

## ХОЁРДУГААР БҮЛЭГ

### Анхдугаар чуулган

#### Ес. Анхдугаар чуулганы нээлт

9.1. Анхдугаар чуулганаар Улсын Их Хурлын тухай хуулийн 14.3-т заасан асуудлыг хэлэлцэх бөгөөд нээлтийн ажиллагааг дараахь журмаар зохион байгуулна:

9.1.1. Ерөнхийлөгч чуулганы хуралдааныг даргалж түүнийг нээж үг хэлэх;

9.1.2. Улсын Их Хурлын ээлжит сонгуулийн дүнд, сонгогдсон гишүүдийн бүрэн эрхийг хүлээн зөвшөөрөх тухай илтгэлийг Сонгуулийн ерөнхий хорооны дарга тавих бөгөөд илтгэлтэй холбогдуулан асуулт асуух;

9.1.3. Сонгуулийн ерөнхий хорооны дарга илтгэл тавьсны дараа насаар хамгийн ахмад гишүүн гишүүний тангараг уншиж бусад гишүүд нь давтан хэлж тангараг өргөх;

9.1.4. тангараг өргөснийхөө дараа гишүүд цагаан толгойн үсгийн дарааллаар Төрийн сүлдэнд мэхийн ёсолж тангарагийн хуудсанд гарын үсэг зурах;

9.1.5. тангараг өргөх ёслол үйлдэж дуусмагц гишүүдийн бүрэн эрхийг хүлээн зөвшөөрөх тухай тогтоол батлах.

9.2. Энэ дэгийн 9.1.5-д заасан тогтоол батлагдсан үеэс эхлэн Улсын Их Хурлын даргыг сонгох хүртэл чуулганы хуралдааныг насаар хамгийн ахмад гишүүн зохион байгуулж даргална.

9.3. Анхдугаар чуулганы нээлтийн хуралдаанд оролцож амжаагүй гишүүн өөрийн оролцсон анхны өдрийн хуралдаанд тангараг өргөнө.

9.4. Нөхөн сонгогдсон гишүүний бүрэн эрхийг хүлээн зөвшөөрөх тухай асуудлыг энэ дэгийн 9.1-д заасан журмаар хэлэлцэнэ.

#### Арав. Улсын Их Хурлын дарга, дэд даргыг сонгох

10.1. Анхдугаар чуулганы нээлтийн ажиллагаа дууссаны дараа Улсын Их Хурлын тухай хуулийн 9, 12 дугаар зүйлд заасан журмыг баримтлан Улсын Их Хурлын дарга, дэд даргыг сонгоно.

#### Арван нэг. Улсын Их Хуралд нам, эвслийн бүлэг байгуулагдсаныг зарлах

11.1. Улсын Их Хурлын даргыг сонгосноос хойш 24 цагийн дотор Улсын Их Хурлын тухай хуулийн 26.1-д заасан суудал авсан нам, эвсэл бүлэг байгуулсан тухай шийдвэр, бүлгийн



гишүүдийн нэрсийн жагсаалтыг Улсын Их Хурлын даргад өргөн мэдүүлнэ.

11.2. Улсын Их Хурлын дарга бүлэг байгуулах тухай шийдвэр, түүний бүрэлдэхүүнд орсон гишүүдийн нэрсийг нэгдсэн хуралдаанд уншин танилцуулах бөгөөд энэ асуудлаар аливаа хэлэлцүүлэг явуулахгүй.

## Арван хоёр. Байнгын болон дэд хороо байгуулах

12.1. Улсын Их Хурал дахь нам, эвслийн бүлгийн бүрэлдэхүүнийг зарласны дараа Байнгын болон дэд хороодын бүрэлдэхүүнийг дараахь журмаар батална:

12.1.1. гишүүд Байнгын хороонд харьяалагдах саналаа нам, эвслийн бүлэгт, бүлэгт харьяалагдаагүй гишүүд Улсын Их Хурлын даргад ирүүлэх;

12.1.2. нам, эвслийн бүлэг нь Байнгын хорооны тоо, олонхи, цөөнхийн харьцаа зэргийг харгалзан гишүүдийг Байнгын хороодод хуваарилах саналаа Улсын Их Хурлын даргад ирүүлэх;

12.1.3. Улсын Их Хурлын дарга нам, эвслийн бүлэг болон тэдгээрт харьяалагдаагүй гишүүдээс ирүүлсэн саналыг нэгтгэсэн эцсийн хувилбарыг нэгдсэн хуралдаанд танилцуулах.

12.2. Нэгдсэн хуралдаан Улсын Их Хурлын даргаас энэ дэгийн 12.1.3-т заасны дагуу оруулсан саналыг хэлэлцэж Байнгын хорооны бүрэлдэхүүнийг тогтоолоор батална.

12.3. Гишүүн Байнгын хорооны харьяаллаа өөрчлөх хүсэлт гаргавал энэ дэгийн 12.1, 12.2-т заасны дагуу шийдвэрлэнэ.

12.4. Дэд хорооны бүрэлдэхүүний тухай асуудлыг харьяалах Байнгын хорооны хуралдаанаар урьдчилан хэлэлцэх бөгөөд нэгдсэн хуралдаан Байнгын хороодын гаргасан санал, дүгнэлтийг үндэслэн дэд хорооны бүрэлдэхүүний тухай тогтоол батална.

## Арван гурав. Байнгын болон дэд хорооны даргыг сонгох

13.1. Байнгын хороо бүрэлдэхүүнд нь орсон гишүүдийн дотроос олонхийн саналаар Байнгын хорооны даргад нэр дэвшүүлнэ.

13.2. Нэгдсэн хуралдаан Байнгын хорооны санал, дүгнэлтийг үндэслэн хүн тус бүрээр ил санал хураалт явуулж, олонхийн санал авсан нэр дэвшигчийг Байнгын хорооны даргаар сонгох тухай тогтоол батална.

13.3. Нэр дэвшигч нэгдсэн хуралдаанд оролцсон гишүүдийн олонхийн санал авч чадаагүй бол өөр гишүүний нэрийг энэ дэгийн 13.1, 13.2-т заасны дагуу дэвшүүлж Байнгын хорооны даргыг сонгоно.

13.4. Байнгын хорооны болон нэгдсэн хуралдаан дээр гишүүд нэр дэвшигчээс асуулт асууж, үг хэлж болно.

13.5. Дэд хорооны даргыг харьяалах Байнгын хорооны хуралдаанаар ил санал хураалт явуулж олонхийн саналаар сонгож Байнгын хороо тогтоол гаргана.

## ГУРАВДУГААР БҮЛЭГ

### Хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэрийн төслийг хэлэлцэх үе шат, журам

#### Арван дөрөв. Хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэрийн төсөл хэлэлцэх үе шат

14.1. Хууль санаачлагчаас өргөн мэдүүлсэн хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэрийн төсөл /цаашид "төсөл" гэх/-ийг дараахь үе шаттайгаар хэлэлцэнэ:

14.1.1. Улсын Их Хурлын тухай хуулийн 20 дугаар зүйлд заасан харьяаллын дагуу холбогдох Байнгын хороо /цаашид "холбогдох Байнгын хороо" гэх/, шаардлагатай гэж үзвэл нам, эвслийн бүлэг төслийг урьдчилан хэлэлцэж чуулганаар хэлэлцэх эсэх тухай санал, дүгнэлт гаргаж нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх;

14.1.2. нэгдсэн хуралдаанаар хэлэлцэх нь зүйтэй гэж үзсэн төслийг анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр холбогдох Байнгын хороонд шилжүүлэх;

14.1.3. холбогдох Байнгын хороо, шаардлагатай гэж үзвэл нам, эвслийн бүлэг төслийг урьдчилан хэлэлцэн санал, дүгнэлт гаргаж нэгдсэн хуралдааны анхны хэлэлцүүлэгт оруулах;

14.1.4. нэгдсэн хуралдаанаар анхны хэлэлцүүлэг явуулж төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр холбогдох Байнгын хороонд шилжүүлэх;

14.1.5. холбогдох Байнгын хороо нэгдсэн хуралдааны анхны хэлэлцүүлгээр олонхийн дэмжлэг авсан саналуудыг төсөлд нэмж тусган танилцуулгын хамтаар нэгдсэн хуралдааны эцсийн хэлэлцүүлэгт оруулах;

14.1.6. нэгдсэн хуралдаан эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн тухай Байнгын хорооны танилцуулгыг хэлэлцэж төслийг эцэслэн батлах.

14.2. Энэ дэгийн 14.1.6-д заасны дагуу батлагдсан шийдвэрийг энэ дэгийн 52.1.1, 52.1.2-т заасны дагуу хянан үзэж эцсийн найруулга хийж нэгдсэн хуралдаанд танилцуулна.

14.3. Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүд төслийг анхны хэлэлцүүлгээр батлах боломжтой гэсэн санал, дүгнэлтийг санал нэгтгэйгээр гаргасан бөгөөд нэгдсэн хуралдаанд оролцсон гишүүдийн олонхи уг горимын саналыг дэмжсэн бол төслийг анхны хэлэлцүүлгээр баталж болно.

14.4. Нэг асуудлаар хоёр болон түүнээс дээш төсөл өргөн мэдүүлсэн бөгөөд хууль санаачлагчид нь зөвшөөрсөн бол Байнгын хороо тэдгээрийг нэгтгэн нэг төсөл болгож Байнгын хорооны санал, дүгнэлтийн хамтаар, хэрэв ийнхүү нэгтгэхийг зөвшөөрөөгүй бол тус тусад нь санал, дүгнэлт гаргаж нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлнэ.

14.5. Төслийн зохицуулах харилцааны ач холбогдол, хамрах хүрээг харгалзан Улсын Их Хурлын дарга, Байнгын хороо, нам, эвслийн бүлэг төслийг чуулганаар хэлэлцүүлэх бэлтгэл хангах, санал, дүгнэлтийн төсөл боловсруулах үүрэг бүхий ажлын хэсгийг гишүүд, мэргэжилтнүүдийн оролцоотойгоор байгуулж болно.

14.6. Энэ дэгийн 14.5-д заасан ажлын хэсэг дор дурдсан эрх, үүрэгтэйгээр ажиллана:

14.6.1. хууль санаачлагч болон шаардлагатай бусад байгууллага, албан тушаалтнаас нэмэлт мэдээлэл, судалгаа гаргуулан авч дүн шинжилгээ хийж;

14.6.2. шаардлагатай гэж үзвэл хэлэлцэж байгаа асуудлаар нарийн мэргэшсэн шинжээчдийг ажилдаа татан оролцуулах;

14.6.3. тухайн асуудлаар гаргах санал, дүгнэлтийн төсөл боловсруулж Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцүүлэх.

14.7. Ажлын хэсэг энэ дэгийн 14.6.3-т заасан төслийг хуралдаанаар хэлэлцэж олонхийн дэмжлэг авсан саналыг Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцүүлэх бөгөөд Байнгын хороо нь хуралдаанаар гарсан бусад саналыг нэгтгэн хэлэлцэж эцсийн санал, дүгнэлтийг гаргана.

14.8. Байнгын хороо, нам, эвслийн бүлэг энэ дэгийн 14.1.1-д заасны дагуу төслийг хэлэлцээд тухайн асуудлаар хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэр гаргах шаардлагагүй, эсхүл өргөн мэдүүлсэн төсөл нь боловсруулалтын шаардлага хангаагүй буюу хэрэгжих боломжгүй гэж үзвэл төслийг хууль санаачлагчид нь буцаах тогтоолын төсөл боловсруулж нэгдсэн хуралдаанд оруулах бөгөөд уг тогтоолд буцаах үндэслэлийг тусгасан байна.

14.9. Нэгдсэн хуралдаан хууль санаачлагчийн илтгэл, энэ дэгийн 14.8-д заасан санал, дүгнэлт, тогтоолын төслийг ердийн журмаар хэлэлцэж ил санал хураалт явуулах бөгөөд Байнгын хороо, нам, эвслийн бүлгийн санал, дүгнэлт зөрвөл холбогдох Байнгын хорооны саналаар эхэлж санал хураалт явуулна.

14.10. Энэ дэгийн 14.8-д заасны дагуу Байнгын хорооноос оруулсан санал, дүгнэлт, тогтоолын төсөл олонхийн дэмжлэг авбал төслийг хууль санаачлагчид нь буцаах тухай тогтоол батална.

## Арван тав. Хууль санаачлагч төслөө татан авах

15.1. Хууль санаачлагч нь хэлэлцүүлгийн аль ч шатанд төслөө татан авч болно.

15.2. Хэд хэдэн гишүүд хамтарч хууль санаачилсан тохиолдолд олонхийн саналаар төслөө татан авч болно.

15.3. Энэ дэгийн 15.1, 15.2-т заасны дагуу төслөө татан авах тохиолдолд тухайн төсөл нь хэлэлцүүлгийн аль шатанд байгаагаас үл хамааран хууль санаачлагч төслөө татан авах тухай албан бичгийг Улсын Их Хуралд ирүүлэх бөгөөд Улсын Их Хурлын дарга нэгдсэн хуралдаанд энэ тухай танилцуулснаар төслөө татан авсанд тооцно.

## Арван зургаа. Байнгын хорооны хуралдаанаар төслийг хэлэлцэх эсэх асуудлыг хэлэлцэх

16.1. Өргөн мэдүүлсэн төслийг Улсын Их Хурлын дарга холбогдох Байнгын хороонд шилжүүлэх бөгөөд уг хороо төслийг хэлэлцүүлэх бэлтгэл хангах, санал, дүгнэлт гаргах, нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх бүх ажлыг хариуцна.

16.2. Энэ дэгийн 16.1-д заасны дагуу хуваарилсан төсөл, түүнд хавсаргасан баримт бичгийг уг төслийг Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцэж эхлэхээс 7-оос доошгүй хоногийн өмнө холбогдох Байнгын хороо нийт гишүүдэд хувилж хүргүүлнэ.

16.3. Байнгын хорооны хуралдаанаар өргөн мэдүүлсэн төслийн талаар ил санал хураалт явуулж хуралдаанд оролцсон гишүүдийн олонхийн саналаар уг төслийг нэгдсэн хуралдаанаар хэлэлцэх эсэх талаар санал, дүгнэлт гаргаж түүнийг илтгэх гишүүнийг томилно.

16.4. Байнгын хорооны хуралдаанаар төслийг хэлэлцэх эсэх асуудлаар хэлэлцүүлэг явуулах үед гишүүд хууль санаачлагчаас асуулт асууж, үг хэлж болох бөгөөд энэхүү санал нь олонхийн дэмжлэг аваагүй бол гишүүн нэгдсэн хуралдаанд зарчмын зөрүүтэй саналаа тайлбарлан үг хэлж санал хураалгах хүсэлтээ Байнгын хорооны санал, дүгнэлтэд тусгуулж болно.

16.5. Хэрэв уг төслийг баталснаар тухайн санхүүгийн жилийн улсын төсвийн орлогын хэмжээ буурах, зарлагын хэмжээ нэмэгдэхээр байвал энэ тухай Засгийн газрын санал, дүгнэлтийг заавал сонсоно.

## Арван долоо. Нэгдсэн хуралдаанаар төслийг хэлэлцэх эсэх асуудлыг хэлэлцэх

17.1. Нэгдсэн хуралдаанаар тухайн чуулганы хэлэлцэх асуудлын төлөвлөгөөнд

тусгагдсан, Улсын Их Хурлын даргын захирамжийн дараалалд орсон төслийг хэлэлцэнэ.

17.2. Энэ дэгийн 17.1-д заасан төлөвлөгөө, дараалалд ороогүй боловч тухайн ээлжит чуулганы явцад өргөн мэдүүлсэн төслийг холбогдох болон Төрийн байгуулалтын байнгын хороо хэлэлцэх нь зүйтэй гэсэн санал, дүгнэлт гаргасан бол нэгдсэн хуралдаанаар хэлэлцэж болно.

17.3. Нэгдсэн хуралдаанаар төслийг хэлэлцэх эсэх тухай хэлэлцүүлгийг дараахь журмаар явуулна:

17.3.1. хууль санаачлагч 15 минутад багтаан төслийн талаар илтгэл тавих;

17.3.2. Байнгын хороо, нам, эвслийн бүлэг 10 минутад багтаан санал, дүгнэлтээ танилцуулах;

17.3.3. энэ дэгийн 17.3.1, 17.3.2-т заасан илтгэл, танилцуулгатай холбогдуулан гишүүд асуулт асуух;

17.3.4. төслийн талаар Байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг дэмжсэн 3 хүртэл, эсрэг байр суурьтай 3 хүртэл гишүүн үг хэлэх;

17.3.5. төслийг хэлэлцэх эсэх асуудлаар санал хураалт явуулах;

17.3.6. энэ дэгийн 17.3.5-д заасан санал хураалтад оролцсон гишүүдийн олонхи төслийг хэлэлцэх нь зүйтэй гэж үзсэн бол төслийг анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр холбогдох Байнгын хороонд шилжүүлэх;

17.3.7. энэ дэгийн 17.3.5-д заасан санал хураалтад оролцсон гишүүдийн олонхи төслийг хэлэлцэхийг дэмжээгүй, эсхүл энэ дэгийн 14.8-д заасан үндэслэлээр төслийг хэлэлцэх шаардлагагүй гэж үзсэн бол хууль санаачлагчид нь буцаах тухай тогтоол батлах.

17.4. Энэ дэгийн 17.3.3-т заасны дагуу гишүүн асуулт асуух, түүнд хариулах, нэмэлт тайлбар хийх, түүнчлэн 17.3.4-т заасны дагуу үг хэлэх хугацааг мөхнүү дэгийн 6.1.6, 6.1.7, 6.2-т заасныг баримтлан хуралдаан даргалагч зохицуулна.

17.5. Энэ дэгийн 17.3.6-д заасны дагуу төслийг Байнгын хороонд шилжүүлэхдээ санал хураалт явуулахгүй.

## **Арван найм. Байнгын хорооны хуралдаанаар төслийн анхны хэлэлцүүлэг явуулах**

18.1. Энэ дэгийн 17.3.6-д заасны дагуу анхны хэлэлцүүлэгт шилжүүлсэн төслийг холбогдох Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцэж санал, дүгнэлт гаргана.

18.2. Тухайн асуудал хуваарилдаагүй Байнгын хороо /цаашид "бусад Байнгын хороо" гэх/

, түүнчлэн нам, эвслийн бүлэг төслийг хуралдаанаараа хэлэлцэж санал, дүгнэлт гаргасан бол түүнийгээ санал хураалгах томъёололтойгоо энэ дэгийн 16.1-д заасан холбогдох Байнгын хороонд өгнө.

18.3. Нэг төсөл буюу асуудлыг хэд хэдэн Байнгын хороо хэлэлцэж санал, дүгнэлт гаргахаар хууль тогтоомжид заасан бол тэдгээр нь хуралдаанаа тус тусдаа зохион байгуулж санал, дүгнэлтээ бие даан гаргаж санал хураалгах томъёололтойгоо энэ дэгийн 16.1-д заасан холбогдох Байнгын хороонд өгнө.

18.4. Зөвлөлийн шийдвэрээр энэ дэгийн 18.3-т заасан төслийг Байнгын хороогын хамтарсан хуралдаанаар хэлэлцэж болно.

18.5. Энэ дэгийн 18.2, 18.3-т заасны дагуу санал, дүгнэлт гаргасан бусад Байнгын хороо, нам, эвслийн бүлэг тухайн асуудлыг холбогдох Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцэхэд тэдгээрийг төлөөлөх гишүүнийг томилж, энэ тухайгаа санал, дүгнэлтээ урьдчилан тэмдэглэнэ.

18.6. Холбогдох Байнгын хороо энэ дэгийн 18.2, 18.3-т заасны дагуу бусад Байнгын хороо, нам, эвслийн бүлгээс ирүүлсэн саналын томъёоллыг нэг бүрчлэн хэлэлцэн санал хураалт явуулж олонхийн санал авсан, аваагүйгээр нь бүлэглэн нэгдсэн хуралдаанд танилцуулж санал хураалгана.

18.7. Төслийг холбогдох Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцэх үед түүнд харьяалагдсан гишүүд таслах эрхтэй оролцоно.

18.8. Тухайн Байнгын хороонд харьяалагддаггүй гишүүн хэлэлцэж байгаа асуудлаар бичгээр урьдчилан томъёолсон санал гаргасан бол зөвхөн өөрийнх нь томъёолсон саналыг хураахад таслах эрхтэй оролцоно.

18.9. Энэ дэгийн 18.8-д заасан саналыг гишүүд хамтран томъёолох, гаргахыг хориглох бөгөөд ийм санал гаргасан бол энэхүү саналаар санал хураалт явуулахыг хориглоно.

18.10. Энэ дэгийн 18.2, 18.3-т заасны дагуу бусад Байнгын хороо, нам, эвслийн бүлгээс бичгээр томъёолсон санал ирүүлсэн бол энэ дэгийн 18.5-д заасан гишүүн үндэслэлийг нь санал тус бүрээр 5 минутаас илүүгүй хугацаанд холбогдох Байнгын хороонд тайлбарлан санал хураалгах бөгөөд тэгэхдээ энэ дэгийн 18.8-д заасан таслах эрх эдэлнэ.

18.11. Байнгын хороо төслийн анхны хэлэлцүүлэг явуулах үед гишүүд хууль санаачлагчаас асуулт асууж, саналаа урьдчилан бичгээр томъёолж хуралдаан даргалагчид өгсний



үндсэн дээр түүнийхээ үндэслэлийг тайлбарлан 5 минутаас илүүгүй хугацаанд үг хэлж санал хураалгах, санал нь олонхийн дэмжлэг аваагүй бол нэгдсэн хуралдаанд зарчмын зөрүүтэй саналаа тайлбарлан үг хэлж санал хураалгах хүсэлтээ Байнгын хорооны санал, дүгнэлтэд тусгуулж болно.

18.12. Тухайн Байнгын хороонд харьяалагддаг болон үл харьяалагддаг гишүүн хэлэлцэж байгаа аливаа асуудлаар бичгээр санал ирүүлж болох бөгөөд ийнхүү санал гаргасан гишүүн хуралдаанд өөрөө оролцоогүй ч гэсэн гаргасан саналыг нь хэлэлцэж санал хураалт явуулна.

18.13. Байнгын хороо гишүүн, нам эвслийн бүлгээс гаргасан саналын томъёоллоор санал хураалт явуулах бөгөөд энэ тохиолдолд төслийн томъёолол хажуугийн саналд тооцогдоно.

18.14. Энэ дэгийн 18.13-т заасан саналын нэг томъёоллоор 3 хүртэл удаа санал хурааж 2 удаа олонхийн дэмжлэг авсан саналыг Байнгын хорооны санал, дүгнэлт гэж тооцон нэгдсэн хуралдаанд оруулах бөгөөд цөөнх болсон гишүүн Байнгын хорооны санал, дүгнэлтэд тэмдэглүүлж нэгдсэн хуралдаанд үг хэлж саналаа тайлбарлан санал хураалгаж болно.

18.15. Төр, нийгмийн анхаарал, ашиг сонирхлыг хөндсөн төслийг нэгдсэн хуралдаан хэлэлцэх нь зүйтэй гэж шийдвэрлэсний дараа анхны хэлэлцүүлэг явуулахаас өмнө уг төслийг өдөр тутмын хэвлэлд нийтлүүлж олон нийтээс санал авах ажлыг дараахь журмаар холбогдох Байнгын хороо зохион байгуулж болно:

18.15.1. төслийг өдөр тутмын хэвлэлд нийтлэхдээ санал ирүүлэх хугацаа, түүнийг хүлээн авах Байнгын хорооны нэрийг заасан байх;

18.15.2. олон нийтээс ирүүлсэн саналыг судалж үзсэний үндсэн дээр холбогдох Байнгын хороо шаардлагатай гэж үзвэл төсөлд санал өгсөн иргэн буюу хуулийн этгээдийн төлөөлөгчийг Байнгын хорооны хуралдаанд урьж ирүүлэн саналынх нь талаар асуулт асуух;

18.16. Байнгын хороо төслийн талаар эрдэмтэд, шинжээчид, сонирхлын бүлэг, мэргэжлийн байгууллагын санал сонсох, мэдээлэл авах зорилгоор дараахь журмаар нээлттэй хуралдааныг зохион байгуулж болно:

18.16.1. Байнгын хорооны дарга нээлттэй хуралдаанаар хэлэлцүүлэх төслийн сэдэв, өдөр, цагийг нэг сарын өмнө Улсын Их Хурлын даргатай зөвшилцөн товлож олон нийтэд зарлах;

18.16.2. нээлттэй хуралдаанд оролцох хүмүүсээс санал, мэдээллийг нь урьдчилан авч 3-аас доошгүй хоногийн өмнө Байнгын хорооны гишүүдэд тараах;

18.16.3. нээлттэй хуралдаанд оролцогчдоос санал, мэдээлэлтэй нь холбогдуулж гишүүд асуулт асуух.

18.17. Энэ дэгийн 18.15-д заасан санал авахтай холбогдсон зардлыг Улсын Их Хурлын жил бүрийн төсөвт тусгана.

18.18. Хуулийн төслийг хэвлэлд нийтлүүлж санал авах, түүнийг нэгтгэн судлах болон нээлттэй хуралдаанаар хэлэлцүүлэх үйл ажиллагааны зохион байгуулалтын асуудлыг Байнгын хороо, Тамгын газар хариуцна.

## **Арван ес. Байнгын хороо төслийн талаар санал, дүгнэлт гаргах хүрээ хязгаар**

19.1. Шинэ болон шинэчилсэн найруулгын төслийг хэлэлцэхдээ Байнгын хороо шинэ бүлэг, зүйл, хэсэг, заалт нэмэх, эсхүл өргөн мэдүүлсэн төслөөс холбогдох бүлэг, зүйл, хэсэг, заалтыг хасах, бүтээх, найруулга, үг хэллэгийг өөрчлөх, засварлах тухай санал, дүгнэлт гаргана.

19.2. Нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг хэлэлцэхдээ хууль санаачлагчийн төсөлд тусгагдаагүй хууль болон хуулийн зүйл, хэсэг, заалтад өөрчлөлт оруулах тухай санал, дүгнэлт гаргахыг хориглоно.

19.3. Энэ дэгийн 19.1-д зааснаар Байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг хууль санаачлагч эс зөвшөөрвөл төслөө татаж авна.

## **Хорь. Нэгдсэн хуралдаанаар төслийн анхны хэлэлцүүлэг явуулах**

20.1. Нэгдсэн хуралдаанаар зөвхөн холбогдох Байнгын хороо урьдчилан хэлэлцэж санал, дүгнэлт гаргасан төслийг хэлэлцэнэ.

20.2. Байнгын хороо, нам, эвслийн бүлэг санал, дүгнэлтээ танилцуулах хугацаа 10 минут, санал, дүгнэлттэй холбогдуулан гишүүн асуулт асуух, түүнд хариулах хугацаа тус бүр 5 минутаас илүүгүй байх бөгөөд гишүүд хуралдаан даргалагчийн зөвшөөрснөөр нэмэлт асуулт асууж болно.

20.3. Нэгдсэн хуралдаан энэ дэгийн 20.2-т заасан хэлэлцүүлэг явуулсны дараа Байнгын хорооноос санал хураалгахаар бэлтгэсэн томъёолол тус бүрээр дараахь журмаар санал хураалт явуулна:

20.3.1. төслийн талаар Байнгын хороо, гишүүд, нам, эвслийн бүлгээс гаргасан зарчмын зөрүүтэй саналыг дэмжсэн 3 хүртэл, эсрэг байр суурьтай 3 хүртэл гишүүн тус бүр 5 минутаас

илүүгүй хугацаанд үг хэлсний дараа санал хураалт явуулах;

20.3.2. хуралдаан даргалагч зарчмын зөрүүтэй санал тус бүрээр Байнгын хорооны саналаар санал хураалт явуулж, гишүүдийн олонхийн саналаар шийдвэрлэх;

20.3.3. гишүүн "зөвшөөрсөн" буюу "татгалзсан" саналын аль нэгийг өгөх;

20.3.4. ил санал хураалтыг гар өргөж, эсхүл цахим тоолуураар, нууц санал хураалтыг санал хураах хуудсаар, эсхүл цахим тоолуураар явуулах.

20.4. Нэгдсэн хуралдаанаар энэ дэгийн 20.3.3-т заасны дагуу санал хураалт явуулж дууссаны дараа хуралдаан даргалагч төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр холбогдох Байнгын хороонд шилжүүлэх тухай зарлах ба энэ талаар санал хураалт явуулахгүй.

20.5. Байнгын хороо энэ дэгийн 14.8-д заасан үндэслэлээр төслийг хэлэлцэх боломжгүй гэсэн санал, дүгнэлт гаргасныг нэгдсэн хуралдаанд оролцсон гишүүдийн олонхи дэмжсэн бол төслийг хууль санаачлагчид буцаах тухай тогтоол батална.

20.6. Улсын Их Хурлын Тамгын газар хэлэлцэж байгаа асуудлын онцлогийг харгалзан төсөл, тодорхой асуудлыг нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх "Хуралдаан удирдах дараалал"-ыг бэлтгэн хуралдаан даргалагчид өгөх бөгөөд хуралдаан даргалагч уг дарааллын дагуу нэгдсэн хуралдааны үйл ажиллагааг зохион байгуулна.

20.7. Төслийг энэ дэгийн 20.4-т зааснаар эцсийн хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр шийдвэрлэсэн бол нэгдсэн хуралдааны эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэх хугацааг төслийн хэмжээ, цар хүрээг харгалзан хуралдаан даргалагч тогтооно.

20.8. Төслийн талаар гарсан зарчмын зөрүүтэй санал гэдгийг:

20.8.1. Байнгын хорооноос санал нэгтгэй буюу олонхийн саналаар оруулахаар шийдвэрлэсэн төсөлд тусгагдаагүй санал;

20.8.2. Байнгын хорооны хуралдаанаар дэмжигдээгүй гишүүний санал;

20.8.3. нам, эвслийн бүлгээс зарчмын гэж үзэж санал, дүгнэлтдээ тусгасан саналыг ойлгоно.

20.9. Гишүүн зөвхөн хэлэлцэж байгаа асуудалтай холбоотой горимын санал гаргах хүсэлт тавьж болох бөгөөд хуралдаан даргалагч горимын саналыг сонсож түүгээр санал хураалгана.

**Хорин нэг. Байнгын хороо төслийг нэгдсэн хуралдааны эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэх**

21.1. Энэ дэгийн 20.4-т зааснаар шилжүүлсэн төслийг холбогдох Байнгын хороо дараах журмаар нэгдсэн хуралдааны эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэнэ:

21.1.1. нэгдсэн хуралдааны анхны хэлэлцүүлгээр олонхийн дэмжлэг авсан саналыг төсөлд нэмж тусган эцсийн хувилбарын төсөл болон эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн тухай танилцуулга бэлтгэх;

21.1.2. энэ дэгийн 21.1.1-д заасан төсөл, танилцуулгыг Байнгын хорооны гишүүдэд урьдчилан тараан танилцуулсны үндсэн дээр хуралдаанаар хэлэлцэх.

21.2. Байнгын хороо энэ дэгийн 21.1.2-т заасан эцсийн хэлэлцүүлэг явуулахдаа зөвхөн дараахь тохиолдолд санал хураалт явуулж болно:

21.2.1. нэгдсэн хуралдаанаар анхны хэлэлцүүлэг явуулах үед төслийн зарим зүйл, заалтыг гүйцээн боловсруулах чиглэл өгсөн;

21.2.2. нэгдсэн хуралдааны эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэх явцад төслийн зарим зүйл, заалт хоорондоо, эсхүл мөрдөж байгаа хууль тогтоомжтой зөрчилдсөн нөхцөл байдал тогтоогдсон бөгөөд Хууль зүйн байнгын хороо ийм санал, дүгнэлтийг дэмжсэн бол;

21.2.3. нэгдсэн хуралдааны анхны хэлэлцүүлгээр дэмжигдсэн боловч уг асуудлаар Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн гуравны хоёроос доошгүй нь дахин санал хураалгах шаардлагатай гэж үзсэн.

21.3. Энэ дэгийн 21.2-т зааснаас бусад үндэслэлээр нэгдсэн хуралдааны анхны хэлэлцүүлгээр дэмжигдсэн саналыг өөрчлөх буюу хүчингүй болгох санал, дүгнэлт гаргахыг хориглоно.

21.4. Энэ дэгийн 21.1.2, 21.2-т заасны дагуу хэлэлцэж эцэслэсэн төслийг танилцуулж, хураалгах саналын томъёоллын хамтаар олшруулж нийт гишүүдэд тараана.

21.5. Төслийн анхны хэлэлцүүлгээр дэмжигдсэн зарчмын зөрүүтэй санал нь бусад хуулийн заалттай зөрчилдвөл Байнгын хороо эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэхдээ холбогдох бусад хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах хуулийн төслийг хамтад нь хэлэлцүүлж болно.

21.6. Энэ дэгийн 21.5-д заасан төсөл нь бусад Байнгын хорооны эрхлэх асуудалд хамааралтай бол тухайн Байнгын хороо заавал хэлэлцэж гаргасан санал, дүгнэлтээ холбогдох



Байнгын хорооны танилцуулгад туслуулах, эсхүл нэгдсэн хуралдаанд танилцуулна.

21.7. Төслийг Байнгын хорооны болон нэгдсэн хуралдааны эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэх ажлыг хууль санаачлагч, холбогдох Байнгын хороо болон Улсын Их Хурлын Тамгын газрын ажилтнуудаас бүрдсэн ажлын хэсэг хариуцан гүйцэтгэнэ.

### **Хорин хоёр. Нэгдсэн хуралдаанаар төслийн эцсийн хэлэлцүүлэг явуулах**

22.1. Холбогдох Байнгын хорооноос томилогдсон гишүүн төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн тухай танилцуулгыг нэгдсэн хуралдаанд 10 минутад багтаан танилцуулна.

22.2. Энэ дэгийн 22.1-д заасны дагуу танилцуулга хийсний дараа гишүүд зөвхөн Байнгын хорооны танилцуулгатай холбогдуулан асуулт асууж болно.

22.3. Байнгын хороо энэ дэгийн 21.2-т заасны дагуу санал хураалгах томъёолол оруулсан бол уг саналыг дэмжсэн 3 хүртэл, эсрэг байр суурьтай 3 хүртэл гишүүн тус бүр 5 минутаас илүүгүй хугацаанд үг хэлсний дараа хуралдаан даргалагч санал тус бүрийг уншиж сонсгон санал хураалт явуулна.

22.4. Нэгдсэн хуралдаан энэ дэгийн 22.3-т заасны дагуу санал хураалт явуулж дууссаны дараа хуулийн төслийг бүхэлд нь батлах санал хураалт явуулах бөгөөд хуралдаанд оролцсон гишүүдийн олонхи дэмжсэн бол хууль батлагдсанд тооцно.

22.5. Энэ дэгийн 22.4-т зааснаар төслийг батлах саналыг хуралдаанд оролцсон гишүүдийн олонхи дэмжээгүй бол түүнийг хууль санаачлагчид буцаах тухай тогтоол батална.

22.6. Улсын Их Хурал шаардлагатай гэж үзвэл хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэрийг хэрэгжүүлэх арга хэмжээний тухай тогтоол, уг хуулийг дагаж мөрдөх журмын тухай хууль болон бусад хууль тогтоомжид нэмэлт, өөрчлөлт оруулах төслийг энэ дэгд заасан журмын дагуу хэлэлцэн баталж болно.

### **ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ**

#### **Үндсэн чиглэл, мөнгөний бодлого, төсөв, түүний гүйцэтгэлийг хэлэлцэх журам**

#### **Хорин гурав. Үндсэн чиглэл, мөнгөний бодлого, төсөв хэлэлцэх**

23.1. Засгийн газар, Монголбанк нь улсын эдийн засаг, нийгмийн хөгжлийн үндсэн чиглэл /цаашид "Үндсэн чиглэл" гэх/, төсөв, мөнгөний

бодлогын баримт бичгийг хуульд заасан хугацаанд Улсын Их Хуралд өргөн мэдүүлнэ.

23.2. Үндсэн чиглэл, төсвийг зохиоход хууль тогтоомжид өөрчлөлт оруулж төсвийн орлого, зарлагад зохицуулалт хийх шаардлагатай гэж Засгийн газар үзвэл холбогдох хуулийн төслийг төсвийн хүрээний мэдэгдлийн хамт өргөн мэдүүлж хэлэлцүүлнэ.

23.3. Энэ дэгийн 23.2-т заасныг зөрчиж өргөн мэдүүлсэн төслийг Улсын Их Хурал хүлээн авахаас татгалзана.

23.4. Энэ дэгийн 23.1-д заасан баримт бичгээс эхний ээлжид Үндсэн чиглэл, мөнгөний бодлогын баримт бичгийг Эдийн засгийн байнгын хороо хэлэлцэж санал, дүгнэлт гарган нэгдсэн хуралдаанд оруулна.

23.5. Бусад Байнгын хороо Үндсэн чиглэлийг хэлэлцсэн бол гаргасан санал, дүгнэлтээ Эдийн засгийн байнгын хороонд өгнө.

23.6. Нэгдсэн хуралдаан энэ дэгийн 23.4-т заасан баримт бичиг, Байнгын хороодын гаргасан санал, дүгнэлтийг хэлэлцэн санал хураалт явуулна.

23.7. Энэ дэгийн 23.4-т заасан баримт бичгийг хэлэлцэхдээ хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэрийн төсөл хэлэлцэх ердийн журмыг баримталж 3 үе шаттай хэлэлцүүлэг явуулна.

23.8. Нэгдсэн хуралдаан энэ дэгийн 23.4-т заасан баримт бичгийн анхны хэлэлцүүлэг явуулсны дараа төсвийн төслийг дараахь 4 үе шаттайгаар хэлэлцэнэ:

23.8.1. нэг дэх хэлэлцүүлэгт Ерөнхий сайд төсвийн төслийн талаар нэгдсэн хуралдаанд илтгэл тавина;

23.8.2. хоёр дахь хэлэлцүүлгээр бүх Байнгын хороо, нам, эвслийн бүлэг, Төсвийн зарлагын дэд хороо төсвийн төслийг эрхлэх асуудлынхаа хүрээнд хэлэлцэж гарсан санал, дүгнэлтийг томъёолон Төсвийн байнгын хороонд өгөх ба тус хороо эдгээр болон гишүүдийн гаргасан саналыг нэг бүрчлэн хэлэлцэн санал хураалт явуулж гаргасан санал, дүгнэлтээ нэгдсэн хуралдаанд оруулах бөгөөд нэгдсэн хуралдаан санал тус бүрээр ил санал хураалт явуулна;

23.8.3. гурав дахь хэлэлцүүлгээр Төсвийн байнгын хороо нэгдсэн хуралдааны хоёр дахь хэлэлцүүлгээр олонхийн дэмжлэг авсан саналыг төсвийн төсөлд нэмж тусган төслийн эцсийн хувилбарыг танилцуулгын хамтаар нэгдсэн хуралдаанд оруулна;

23.8.4. дөрөв дэх хэлэлцүүлгээр нэгдсэн хуралдаан даргалагч Монгол Улсын төсвийн тухай хуулийн төслийн зүйл, заалт бүрийг уншин сонгож тус бүрээр нь санал хураалт явуулж батлуулна.

23.9. Нэг дэх хэлэлцүүлэгт Засгийн газрын гишүүд, Улсын Их Хуралд ажлаа шууд хариуцан тайлагнадаг байгууллагын дарга болон Үндсэн хуулийн Цэцийн дарга, Шүүхийн ерөнхий зөвлөлийн дарга, Улсын ерөнхий прокурорыг байлцуулах ба гишүүд тэдгээрээс асуулт асууж, үг хэлсний дараа төслийг хоёр дахь хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Байнгын хороодод шилжүүлнэ.

23.10. Байнгын хороо, нам, эвслийн бүлгийн хуралдаанаар хоёр дахь хэлэлцүүлэг явуулах үед гишүүд хууль санаачлагч болон энэ дэгийн 23.9-д заасан төсвийн ерөнхийлөн захирагч нараас асуулт асууж, гаргасан саналынхаа үндэслэлийг тайлбарлаж үг хэлж болно.

23.11. Байнгын хороод, нам, эвслийн бүлгийн хуралдаанаар хоёр дахь хэлэлцүүлэг явуулах үед гишүүдийн гаргасан санал тус бүрээр санал хураалт явуулж олонхийн дэмжлэг авсан, аваагүйгээр нь бүлэглэн томъёолж Төсвийн байнгын хороонд өгнө.

23.12. Төсвийн байнгын хороо энэ дэгийн 23.11-д заасан болон өөрийнхөө Байнгын хорооны гишүүд, түүнчлэн төсөвтэй холбогдуулан Ерөнхийлөгч, Төрийн аудитын төв байгууллага, Төсвийн зарлагын дэд хорооноос гаргасан санал нэг бүрийг хэлэлцэж ил санал хураалт явуулж олонхийн дэмжлэг авсан, аваагүйгээр нь бүлэглэн томъёолж нэгдсэн хуралдаанд оруулна.

23.13. Нэгдсэн хуралдаанаар хоёр дахь хэлэлцүүлэг явуулах үед Байнгын хороо, нам, эвслийн бүлэг, гишүүд гаргасан саналаа тайлбарлан үг хэлж болно.

23.14. Нэгдсэн хуралдаанаар гурав дахь хэлэлцүүлэг явуулах үед зөвхөн Төсвийн байнгын хорооноос гаргасан танилцуулгын талаар тайлбар хийх, түүнтэй холбогдуулан гишүүд асуулт асууж болох бөгөөд өөр аливаа хэлэлцүүлэг явуулахгүй.

23.15. Улсын төсвийн тухай хуульд тодотгол хийх асуудлыг энэ зүйлд заасан журмын дагуу хэлэлцэн шийдвэрлэнэ.

### Хорин дөрөв. Төсвийн гүйцэтгэл, Засгийн газрын санхүүгийн тайланг хэлэлцэх

24.1. Засгийн газар Улсын төсвийн гүйцэтгэл батлах тухай тогтоолын төсөл, Улсын нэгдсэн төсвийн гүйцэтгэл, Засгийн газрын санхүүгийн тайлан/цаашид "төсвийн гүйцэтгэл" гэх/

-г Төсвийн байгууллагын удирдлага, санхүүжилтийн тухай хуулийн 37.4-т заасан хугацаанд Улсын Их Хуралд өргөн мэдүүлнэ.

24.2. Төсвийн гүйцэтгэлийн талаархи танилцуулгад төсвийн орлого, зарлагыг эдийн засгийн ангиллаар, төсвийн ерөнхийлөн захирагч бүрээр гаргаж, батлагдсан төсвөөс зөрүүтэй бол түүний шалтгааныг тайлбарласан дэлгэрэнгүй мэдээллийг хавсаргасан байна.

24.3. Төсвийн гүйцэтгэлийг хэлэлцэхэд Ерөнхий сайд, Засгийн газрын гишүүд, төсвийн ерөнхийлөн захирагч нар, Монгол Улсын ерөнхий аудитор байлцана.

24.4. Төсвийн гүйцэтгэлийг дараахь 2 үе шаттайгаар хэлэлцэнэ:

24.4.1. нэг дэх хэлэлцүүлэгт улсын нэгдсэн төсвийн гүйцэтгэлийн талаар санхүүгийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний илтгэл, Улсын нэгдсэн төсвийн гүйцэтгэл, Засгийн газрын санхүүгийн тайлангийн талаархи аудитын дүгнэлтийг нэгдсэн хуралдаанаар сонсоно;

24.4.2. хоёр дахь хэлэлцүүлгээр бүх Байнгын хороо, нам, эвслийн бүлэг төсвийн гүйцэтгэлийг хэлэлцэж гарсан санал, дүгнэлтийг томъёолон Төсвийн зарлагын хяналтын дэд хороонд өгөх ба тус дэд хороо эдгээр санал, дүгнэлтийг сонсож нэгтгэн гаргасан санал, дүгнэлтээ нэгдсэн хуралдаанд оруулна.

24.5. Нэгдсэн хуралдаанаар нэг дэх хэлэлцүүлэг явуулах үед гишүүд энэ дэгийн 24.4.1-д заасан илтгэл болон аудитын дүгнэлттэй холбогдуулан, түүнчлэн энэ дэгийн 24.3-т заасан албан тушаалтнаас асуулт асууж, үг хэлж болох бөгөөд үүний дараа төсвийн гүйцэтгэлийг хоёр дахь хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Төсвийн зарлагын хяналтын дэд хороо болон Байнгын хороодод шилжүүлнэ.

24.6. Нэгдсэн хуралдаанаар хоёр дахь хэлэлцүүлэг явуулах үед Төсвийн зарлагын хяналтын дэд хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан гишүүд асуулт асууж хариулт авсны дараа улсын төсвийн орлого, зарлагын нийт дүнг тусгасан Улсын төсвийн гүйцэтгэл батлах тухай тогтоол батална.

24.7. Шаардлагатай гэж үзвэл Төсвийн зарлагын хяналтын дэд хороо Улсын төсвийн гүйцэтгэл батлагдсантай холбогдуулан авах арга хэмжээний тухай Улсын Их Хурлын тогтоолын төсөл боловсруулж нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлж болно.



## ТАВДУГААР БҮЛЭГ

### Бусад асуудал хэлэлцэх журам

#### Хорин тав. Ард нийтийн санал асуулга явуулах саналыг хэлэлцэх

25.1. Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Ард нийтийн санал асуулга явуулах тухай шийдвэрийн төслийг Төрийн байгуулалтын болон Хууль зүйн байнгын хороо урьдчилан хэлэлцэж санал, дүгнэлт гаргана.

25.2. Нэгдсэн хуралдаанаар хууль санаачлагчийн илтгэл, Байнгын хороодын санал, дүгнэлтийг сонгож илээр санал хураалт явуулж нийт гишүүний гуравны хоёроос доошгүй нь дэмжсэн бол Ард нийтийн санал асуулга явуулах тухай тогтоол батална.

25.3. Энэ дэгийн 25.2-т заасан тогтоолын төсөлд шийдвэрлэх асуудлын агуулгыг илэрхийлсэн асуулт, түүнд өгөх эсрэг утга бүхий 2 хармултын томъёоллыг тусгана.

25.4. Ард нийтийн санал асуулга явуулах тухай шийдвэрийн төслийг Байнгын хорооны болон нэгдсэн хуралдаанаар хэлэлцэхэд гишүүд хууль санаачлагчийн илтгэл, Байнгын хороодын санал, дүгнэлттэй холбогдуулан асуулт асууж, үг хэлж болно.

#### Хорин зургаа. Олон улсын гэрээний төслийг Улсын Их Хуралтай урьдчилан зөвшилцөх

26.1. Ерөнхийлөгч, Засгийн газар Улсын Их Хурал соёрхон батлах олон улсын гэрээ байгуулах бол төслийг холбогдох талтай тохиролцсоны дараа үзэгдэхээс өмнө Улсын Их Хуралд зөвшилцөхөөр ирүүлнэ.

26.2. Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороо гэрээний төсөл, холбогдох танилцуулга, бусад баримт бичгийг хэлэлцэхээс 3 хоногийн өмнө гишүүдэд тараана.

26.3. Гэрээ нь зээл тусламжтай холбоотой бол төслийг Төсвийн болон Эдийн засгийн байнгын хороо тус тусдаа урьдчилан хэлэлцэж санал, дүгнэлтээ Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороонд өгнө.

26.4. Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороо гэрээний төсөл, холбогдох бусад баримт бичиг, Төсвийн болон Эдийн засгийн байнгын хорооны санал, дүгнэлтийг нэгтгэн хэлэлцэж ил санал хураалт явуулж гишүүдийн олонхи дэмжсэн бол зөвшөөрсөн, дэмжээгүй бол эс зөвшөөрсөн тухай санал, дүгнэлт гаргаж Ерөнхийлөгч буюу Засгийн газарт хүргүүлнэ.

26.5. Байнгын хороодын хуралдаанд гэрээний төслийг Ерөнхийлөгчийн итгэмжлэгдсэн төлөөлөгч, эсхүл тухайн асуудал хариуцсан Засгийн газрын гишүүн танилцуулна.

26.6. Төсөл, танилцуулгатай холбогдуулан гишүүд асуулт асууж, үг хэлж болно.

26.7. Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороо гэрээний төслийг бүхэлд нь дэмжсэн боловч зарим засвар, нэмэлт, өөрчлөлт оруулах шаардлагатай гэж үзвэл санал, дүгнэлтэд энэ тухай тодорхой заах ба Ерөнхийлөгч, Засгийн газар холбогдох талтай гэрээг эцэслэн тохирохдоо тэдгээрийг тусгах чиглэлээр ажиллаж дүнг танилцуулна.

26.8. Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн олонхи гэрээний төслийг дэмжээгүй бол шалтгааныг тайлбарласан санал, дүгнэлтийг Ерөнхийлөгч буюу Засгийн газарт хүргүүлнэ.

26.9. Ерөнхийлөгч, Засгийн газар нь Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны санал, дүгнэлтийг эс зөвшөөрвөл гэрээг нэгдсэн хуралдаанд шууд хэлэлцүүлэх хүсэлт гаргах, эсхүл санал, дүгнэлтэд дурдсан нөхцөл байдлыг зохистой хэлбэрээр зохицуулж чадвал шинэчилсэн гэрээг зөвшилцөхөөр Улсын Их Хуралд дахин ирүүлж болно.

26.10. Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороо Төсвийн болон Эдийн засгийн байнгын хорооны санал, дүгнэлтийг зөвшөөрөх боломжгүй гэж үзвэл энэ тухай санал, дүгнэлтээ нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлж шийдвэрлүүлнэ.

26.11. Олон улсын олон талт гэрээ /црашид "олон талт гэрээ" гэх/-нд Ерөнхийлөгч, Ерөнхий сайд, Гадаад хэргийн сайд гарын үсэг зурахын өмнө энэ дэгд заасны дагуу Улсын Их Хуралтай зөвшилцөнө.

#### Хорин долоо. Олон улсын олон талт гэрээг соёрхон батлах асуудлыг хэлэлцэх

27.1. Ерөнхийлөгч, Засгийн газраас өргөн мэдүүлсэн олон улсын олон талт гэрээг соёрхон батлах тухай хуулийн төслийг Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороо хуралдаанаараа хэлэлцэж дараахь санал, дүгнэлтийн аль нэгийг гаргаж нэгдсэн хуралдаанд танилцуулна:

27.1.1. гэрээг соёрхон батлах;

27.1.2. гэрээг тайлбар, мэдэгдэлтэйгээр соёрхон батлах;

27.1.3. гэрээг хууль санаачлагчид

нь буцаах.



27.2. Бусад Байнгын хороо, нам зөслийн бүлэг энэ дэгийн 27.1-д заасан гэрээг хэлэлцэж санал, дүгнэлтээ Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороонд ирүүлсэн бол тус хороо тэдгээрийг хэлэлцэж санал, дүгнэлт гаргахдаа харгалзан үзэж болно.

27.3. Нэгдсэн хуралдаан хууль санаачлагчийн илтгэл, Байнгын хорооны санал, дүгнэлтийг сонсож, Байнгын хорооноос оруулсан томъёоллоор ил санал хураалт явуулж гишүүдийн олонхийн саналаар шийдвэр гаргана.

27.4. Байнгын хороо тайлбар, мэдэгдэлтэйгээр гэрээг батлах санал гаргасан бол төслийг нь нэгдсэн хуралдаанд хамтад нь оруулж тусад нь санал хураалгаж батлуулна.

27.5. Нэгдсэн хуралдаанд оролцсон гишүүдийн олонхи гэрээний төслийг дэмжээгүй бол төслийг хууль санаачлагчид буцаах тогтоол батална.

27.6. Байнгын хорооны болон нэгдсэн хуралдаанаар төслийг хэлэлцэх үед гишүүд хууль санаачлагчийн илтгэл, Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан асуулт асууж, үг хэлж болно.

**Хорин найм. Гадаад улсыг хүлээн зөвшөөрөх, түүнтэй дипломат харилцаа тогтоох, цуцлах тухай асуудлыг хэлэлцэх**

28.1. Засгийн газар гадаад улсыг хүлээн зөвшөөрөх тухай тогтоолын төслийг Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн бол Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороо хуралдаанаараа хэлэлцэн санал, дүгнэлт гаргаж, нэгдсэн хуралдаан ил санал хураалт явуулж гишүүдийн олонхийн саналаар асуудлыг шийдвэрлэнэ.

28.2. Засгийн газар гадаад улстай дипломат харилцаа шинээр буюу сэргээн тогтоохоор төлөвлөж байгаа бол энэ тухай саналаа танилцуулгын хамтаар Улсын Их Хуралд ирүүлнэ.

28.3. Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороо энэ дэгийн 28.2-т заасны дагуу Засгийн газраас ирүүлсэн санал, танилцуулгыг хуралдаанаараа хэлэлцэж ил санал хураалт явуулж гишүүдийн олонхи дэмжсэн бол саналыг дэмжиж байгаагаа Засгийн газарт хариу мэдэгдэх ба ингэхдээ уг асуудлыг эцэслэн шийдвэрлэхэд анхаарвал зохих асуудлаар гишүүдийн гаргасан саналыг хавсаргана.

**Хорин ес. Ерөнхийлөгчийн хоригийг хэлэлцэх**

29.1. Хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэрт Ерөнхийлөгч хориг тавьсан бол Улсын Их Хурал түүнийг чуулганы үеэр 14 хоногийн дотор, чуулганы чөлөөт цагт хориг тавьсан бол ээлжит болон ээлжит бус чуулган эхэлснээс хойш 10 хоногийн дотор хэлэлцэн шийдвэрлэж тогтоол батална.

29.2. Хоригийг анх тухайн асуудлыг хэлэлцэж санал, дүгнэлт гаргасан холбогдох Байнгын хороо болон Хууль зүйн байнгын хороо хэлэлцэж санал, дүгнэлт гаргана.

29.3. Нэгдсэн хуралдаанд хоригийг Ерөнхийлөгч, эсхүл түүний итгэмжлэгдсэн төлөөлөгч танилцуулсны дараа энэ дэгийн 29.2-т заасан Байнгын хороодын санал, дүгнэлтийг сонсоно.

29.4. Байнгын хорооны болон нэгдсэн хуралдаан дээр гишүүд Ерөнхийлөгчийн хориг болон Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан асуулт асууж, үг хэлж болно.

29.5. Гишүүд энэ дэгийн 29.4-т заасны дагуу үг хэлсний дараа Ерөнхийлөгчийн хоригийг хүлээн зөвшөөрөх эсэх асуудлаар ил санал хураалт явуулах бөгөөд хэрэв хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэрийн зарим хэсэгт хориг тавьсан бол тухайн зүйл, заалт нэг бүрээр санал хураалт явуулж дүнг танилцуулна.

29.6. Байнгын хорооны болон нэгдсэн хуралдаанд оролцсон гишүүдийн гуравны хоёр буюу 66.6 хувь нь хоригийг хүлээж аваагүй бол хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэр хүчин төгөлдөр үлдэнэ.

29.7. Хоригийн талаар Хууль зүйн болон холбогдох Байнгын хорооны санал, дүгнэлт зөрвөл холбогдох Байнгын хорооны саналаар эхэлж санал хураалт явуулна.

29.8. Ерөнхийлөгчийн хоригийг хүлээн зөвшөөрсөн бол хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэрийг бүхэлд нь буюу зарим хэсгийг нь хүчингүй болгож, шаардлагатай гэж үзвэл зохих нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэрийн төслийг хэлэлцэн баталж болно.

29.9. Ерөнхийлөгчийн хоригийг хүлээж авсантай холбогдуулан хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэрт нэмэлт, өөрчлөлт оруулах бол холбогдох шийдвэрийн төслийг холбогдох Байнгын хороо боловсруулж нэгдсэн хуралдаанд оруулах бөгөөд уг төслийн талаар Засгийн газар, холбогдох бусад байгууллагаас санал авахыг шаардахгүй.



## Гуч. Үндсэн хуулийн цэцийн дүгнэлтийг хэлэлцэх журам

30.1. Үндсэн хуулийн Жаран зургадугаар зүйлийн 2 дахь хэсгийн 1, 2 дахь хэсэгт заасан асуудлаар Үндсэн хуулийн цэц /цаашид "Цэц" гэх/ дүгнэлт гаргасан бол түүнийг өсчилсноос хойш 24 цагийн дотор Улсын Их Хуралд ирүүлэх бөгөөд уг дүгнэлтийг Улсын Их Хурал дараахь журмаар хэлэлцэнэ:

30.1.1. Цэцийн дүгнэлтийг Байнгын хорооны болон нэгдсэн хуралдаанд Цэцийн дарга, түүний түр эзгүйд орлогч нь танилцуулна;

30.1.2. Цэцийн дүгнэлтийг чуулганы үеэр хүлээн авсан бол 7 хоногийн дотор, чуулганы чөлөөт цагт хүлээн авсан бол ээлжит болон ээлжит бус чуулган эхэлснээс хойш 5 хоногийн дотор Хууль зүйн болон холбогдох Байнгын хороо хэлэлцэж санал, дүгнэлт гаргана;

30.1.3. нэгдсэн хуралдаан Цэцийн дүгнэлт, Байнгын хороодын санал, дүгнэлтийг сонссоны дараа ил санал хураалт явуулж хуралдаанд оролцсон гишүүдийн олонхи Цэцийн дүгнэлтийг дэмжсэн бол түүнийг хүлээн зөвшөөрөх тухай, дэмжээгүй бол эс зөвшөөрөх тухай тогтоол батална;

30.1.4. Цэцийн дүгнэлтийг хүлээн зөвшөөрөх эсэх асуудлаар Хууль зүйн болон холбогдох Байнгын хорооны санал, дүгнэлт зөрвөл нэгдсэн хуралдаан дээр Хууль зүйн байнгын хорооны санал, дүгнэлтээр эхэлж санал хураалгах бөгөөд энэ санал эс дэмжигдвэл холбогдох Байнгын хорооны санал дэмжигдсэн гэж үзнэ;

30.1.5. хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэр Үндсэн хуульд нийцээгүй гэсэн Цэцийн дүгнэлтийг Улсын Их Хурал хүлээн зөвшөөрсөн бол тухайн хууль, шийдвэрт зохих нэмэлт, өөрчлөлт оруулна;

30.1.6. Ерөнхийлөгчийн зарлиг, Засгийн газрын тогтоол, Монгол Улсын олон улсын гэрээ, Сонгуулийн ерөнхий хорооны шийдвэр Үндсэн хуульд нийцээгүй гэсэн Цэцийн дүгнэлтийг Улсын Их Хурал хүлээн зөвшөөрсөн бол эдгээр шийдвэр хүчингүй болсонд тооцогдоно;

30.1.7. энэ дэгийн 30.1.5-д заасан хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэрт нэмэлт, өөрчлөлт оруулах тухай төслийг холбогдох Байнгын хороо боловсруулж нэгдсэн хуралдаанд оруулах бөгөөд уг төслийн талаар Засгийн газар, холбогдох бусад байгууллагаас санал авахыг шаардахгүй;

30.1.8. Цэцийн дүгнэлтийг Байнгын хорооны болон нэгдсэн хуралдаанаар хэлэлцэхэд гишүүд Цэцийн дарга, түүний орлогчоос болон

Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан асуулт асууж, үг хэлж болно;

30.1.9. Цэц маргаж байгаа асуудал Үндсэн хуульд нийцсэн гэсэн дүгнэлт гаргасан бол уг дүгнэлтийг Байнгын хороодын хуралдаанаар хэлэлцүүлэхгүйгээр шууд нэгдсэн хуралдаанд танилцуулах бөгөөд гишүүд Цэцийн дүгнэлттэй холбогдуулан асуулт асууж хариулт авах боловч санал хурааж шийдвэр гаргахгүй.

30.2. Ерөнхийлөгч, Улсын Их Хурлын дарга, гишүүн, Ерөнхий сайд, Засгийн газрын гишүүн, Улсын дээд шүүхийн Ерөнхий шүүгч, Улсын ерөнхий прокурор /цаашид "холбогдох албан тушаалтан" гэх/ Үндсэн хууль зөрчсөн гэсэн Цэцийн дүгнэлт гарсан бол түүнийг өсчилсноос хойш энэ дэгийн 30.1-д заасан хугацаанд Улсын Их Хуралд ирүүлэх бөгөөд уг дүгнэлтийг Улсын Их Хурал дараахь журмаар хэлэлцэнэ:

30.2.1. Байнгын хорооны болон нэгдсэн хуралдаанд Цэцийн дүгнэлтийг Цэцийн дарга, түүний түр эзгүйд орлогч нь танилцуулна;

30.2.2. Цэцийн дүгнэлтийг чуулганы үеэр хүлээн авсан бол 7 хоногийн дотор, чуулганы чөлөөт цагт хүлээн авсан бол ээлжит болон ээлжит бус чуулган эхэлснээс хойш 5 хоногийн дотор Хууль зүйн болон Төрийн байгуулалтын Байнгын хороо хэлэлцэж санал, дүгнэлт гаргана;

30.2.3. Улсын Их Хурлын дарга Үндсэн хууль зөрчсөн гэсэн Цэцийн дүгнэлт гарсан бол нэгдсэн хуралдааныг олонхийн бүлгээс сонгогдсон дэд дарга, бусад тохиолдолд Улсын Их Хурлын дарга даргалан хуралдуулна;

30.2.4. нэгдсэн хуралдаан холбогдох албан тушаалтан Үндсэн хууль зөрчсөн гэсэн Цэцийн дүгнэлттэй танилцсаны дараа уг албан тушаалтныг огцруулах, эгүүлэн татах эсэх асуудлыг хэлэлцэх эсэх, эсхүл тухайн зөрчлийг арилгуулах талаар Хууль зүйн болон Төрийн байгуулалтын байнгын хорооны санал, дүгнэлтийг хэлэлцэнэ;

30.2.5. Байнгын хорооны болон нэгдсэн хуралдаан дээр гишүүд Цэцийн дүгнэлт болон Байнгын хороодын санал, дүгнэлттэй холбогдуулан асуулт асууж, үг хэлж болно;

30.2.6. Үндсэн хуулийн зөрчилд холбогдсон албан тушаалтан санал хураахын өмнө Байнгын хорооны хуралдаан дээр 5 минутаас илүүгүй хугацаанд, нэгдсэн хуралдаан дээр 10 минутаас илүүгүй хугацаанд үг хэлж болно;

30.2.7. энэ дэгийн 30.2.4-т заасны дагуу гаргасан Байнгын хорооны саналаар ил санал

хураалт явуулах бөгөөд хуралдаанд оролцсон гишүүдийн олонхи дэмжсэн бол тухайн албан тушаалтныг огцруулах, эгүүлэн татах асуудлыг энэ дэг болон холбогдох хуульд заасны дагуу хэлэлцэн шийдвэрлэнэ;

30.2.8. шаардлагатай гэж үзвэл холбогдох албан тушаалтныг огцруулах, эгүүлэн татах үндэслэл байгаа эсэх талаар Улсын Их Хурал, эсхүл холбогдох албан тушаалтан өөрөө Цэцэд хандаж болно;

30.2.9. Цэц тухайн албан тушаалтныг огцруулах, эгүүлэн татах үндэслэл байна гэсэн дүгнэлт гаргасан бол түүнийг огцруулах, эгүүлэн татах эсэх асуудлыг энэ дэгд заасны дагуу хэлэлцэн шийдвэрлэх бөгөөд харин Ерөнхийлөгчийг огцруулах асуудлыг хуралдаанд оролцсон нийт гишүүний дийлэнхи олонхи дэмжсэн бол энэ тухай хууль батална;

30.2.10. энэ дэгд заасан холбогдох албан тушаалтны талаар Үндсэн хууль зөрчөөгүй гэсэн дүгнэлт гаргасан бол энэ тухай дүгнэлтийг Байнгын хороодын хуралдаанаар хэлэлцүүлэхгүйгээр шууд нэгдсэн хуралдаанд танилцуулах бөгөөд энэ тохиолдолд асуулт хариулт, санал шүүмжлэл, санал хураалт явуулахгүй;

30.2.11. Улсын дээд шүүхийн Ерөнхий шүүгч, Улсын ерөнхий прокурор Үндсэн хууль зөрчсөн тухай дүгнэлт гарсан бол уг дүгнэлтийг шууд нэгдсэн хуралдаанд танилцуулах бөгөөд энэ тухай Улсын Их Хурлын дарга Ерөнхийлөгчид танилцуулна;

30.2.12. энэ дэгийн 30.2.11-д заасан Цэцийн дүгнэлтийг танилцуулах үеэр гишүүд Цэцийн дүгнэлттэй холбогдуулан асуулт асууж, үг хэлж болно.

## **Гучин нэг, Ерөнхийлөгчийн бүрэн эрхийг хүлээн зөвшөөрөх тухай асуудлыг хэлэлцэх журам**

31.1. Ерөнхийлөгчийн анхан шатны сонгуульд аль нэг нэр дэвшигч санал хураалтад оролцсон нийт сонгогчийн олонхийн санал авсан бол түүнийг Ерөнхийлөгчөөр сонгогдсонд тооцох тухай Улсын Их Хурлын тогтоолын төсөл, танилцуулгыг Сонгуулийн ерөнхий хороо санал хураалт дууссан өдрөөс хойш 30 хоногийн дотор Улсын Их Хуралд өргөн мэдүүлнэ.

31.2. Энэ дэгийн 31.1-д заасан тогтоолын төсөл, танилцуулгыг Төрийн байгуулалтын байнгын хороо ажлын 7 өдрийн дотор хэлэлцэж Ерөнхийлөгчийн анхан шатны сонгуулийн санал хураалт хүчин төгөлдөр болсон, нэр дэвшигч

Ерөнхийлөгчөөр сонгогдоход харшлах шалтгаан байхгүй гэсэн асуудлаар санал, дүгнэлт гаргана.

31.3. Байнгын хороо энэ дэгийн 31.2-т заасны дагуу санал, дүгнэлт гаргаснаас хойш нэгдсэн хуралдаан ажлын 5 өдөрт хуралдаж Ерөнхийлөгчийн бүрэн эрхийг хүлээн зөвшөөрөх асуудлыг дараахь журмаар хэлэлцэнэ:

31.3.1. Ерөнхийлөгчийн анхан шатны сонгуулийн дүнгийн тухай Сонгуулийн ерөнхий хорооны даргын илтгэлийг сонсоно;

31.3.2. Цэц Ерөнхийлөгчийн сонгуультай холбогдуулан дүгнэлт гаргасан бол түүнийг сонсоно;

31.3.3. Төрийн байгуулалтын байнгын хорооны санал, дүгнэлтийг сонсоно;

31.3.4. гишүүд Сонгуулийн ерөнхий хорооны илтгэл, Цэцийн дүгнэлт болон Төрийн байгуулалтын байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан асуулт асууж, үг хэлж болно;

31.3.5. анхан шатны сонгуулийн санал хураалт хүчин төгөлдөр болсон, нэр дэвшигч Ерөнхийлөгчөөр сонгогдоход харшлах шалтгаан байхгүй гэсэн томъёолол тус бүрээр ил санал хураалт явуулж дээрхи асуудлаар гишүүдийн олонхи зөвшөөрсөн санал өгснөөр нэр дэвшигчийг Ерөнхийлөгчөөр сонгогдсон гэж үзэж бүрэн эрхийг нь хүлээн зөвшөөрсөн хууль батална.

31.4. Энэ дэгийн 31.3-т заасан санал хураалтад оролцсон гишүүдийн олонхи эсрэг санал өгсөн бол дараахь томъёоллоор санал хураалт явуулна:

31.4.1. сонгогчдын нэрсийн жагсаалтад бүртгэгдсэн нийт сонгогчийн 50 хувь нь анхан шатны сонгуульд оролцоогүйг хүлээн зөвшөөрөх;

31.4.2. дахин санал хураалтаар нэр дэвшигчдийн хэн нь ч нэрсийн жагсаалтад бүртгэгдсэн нийт сонгогчийн олонхийн санал аваагүйг хүлээн зөвшөөрөх;

31.4.3. санал хураалт хуулийн дагуу явагдаагүйг хүлээн зөвшөөрөх.

31.5. Энэ дэгийн 31.4-т заасан томъёолол тус бүрийг гишүүдийн олонхи зөвшөөрөөгүй бол Ерөнхийлөгчийн бүрэн эрхийг хүлээн зөвшөөрсөн тухай хууль батална.

31.6. Энэ дэгийн 31.4-т заасан томъёолол тус бүрийг гишүүдийн олонхи хүлээн зөвшөөрсөн

бол Ерөнхийлөгчийн сонгуулийг хүчингүйд тооцож дахин сонгууль явуулах тухай тогтоол батална.

31.7. Санал хураалтыг гар өргүүлэх замаар, эсхүл цахим тоолуураар ил санал хураалт явуулж шийдвэрлэнэ.

### **Гучин хоёр. Ерөнхийлөгчийг үүрэгт ажлаас нь чөлөөлөх асуудлыг хэлэлцэх журам**

32.1. Ерөнхийлөгч эрүүл мэндийн болон хүндэтгэн үзэх бусад шалтгаанаар бүрэн эрхийн хугацаанаас өмнө чөлөөлөгдөх хүсэлтээ Улсын Их Хуралд гаргасан бол Төрийн байгуулалтын байнгын хороо хэлэлцэн санал, дүгнэлт гаргаж нэгдсэн хуралдаанд танилцуулна.

32.2. Нэгдсэн хуралдаанаар Төрийн байгуулалтын байнгын хорооны санал, дүгнэлтийг хэлэлцэн ил санал хураалт явуулж, чөлөөлөгдөх хүсэлтийг гишүүдийн олонхи дэмжсэн бол Ерөнхийлөгчийг үүрэгт ажлаас нь чөлөөлөх тухай хууль батална.

32.3. Байнгын хорооны болон нэгдсэн хуралдаан дээр Ерөнхийлөгчийг үүрэгт ажлаас нь чөлөөлөх шалтгаан үндэслэлийн талаар гишүүд асуулт асууж, үг хэлж болно.

### **Гучин гурав. Ерөнхийлөгчийг огцруулах асуудлыг хэлэлцэх журам**

33.1. Ерөнхийлөгч гэмт хэрэг үйлдсэн болох нь шүүхийн хүчин төгөлдөр шийтгэх тогтоолоор нотлогдсон, түүнчлэн Цэц Ерөнхийлөгчийг огцруулах үндэслэлтэй гэсэн дүгнэлт гаргасан бол эдгээр шийдвэр гарснаас хойш 7 хоногийн дотор Төрийн байгуулалтын болон Хууль зүйн байнгын хороо Ерөнхийлөгчийг огцруулах асуудлыг хуралдаанаараа хэлэлцэж санал, дүгнэлт гаргана.

33.2. Нэгдсэн хуралдаан шүүхийн тогтоол, Цэцийн дүгнэлт, Төрийн байгуулалтын болон Хууль зүйн байнгын хорооны санал, дүгнэлтийг хэлэлцэн ил санал хураалт явуулж хуралдаанд оролцсон нийт гишүүний дийлэнхи олонхи дэмжсэн бол Ерөнхийлөгчийг огцруулах тухай хууль батална.

33.3. Байнгын хорооны болон нэгдсэн хуралдаан дээр гишүүд шүүхийн тогтоол, Цэцийн дүгнэлт болон Байнгын хороодын санал, дүгнэлттэй холбогдуулан асуулт асууж, үг хэлж болно.

33.4. Байнгын хорооны болон нэгдсэн хуралдаан дээр шүүхийн тогтоолыг Улсын дээд шүүхийн Ерөнхий шүүгч, Цэцийн дүгнэлтийг дарга

нь тус тус танилцуулж гишүүдийн асуултад хариулна.

### **Гучин дөрөв. Ерөнхийлөгч Улсын Их Хуралд ажлаа хариуцах**

34.1. Монгол Улсын Үндсэн хуулийн Гучин тавдугаар зүйлийн 1 дэх хэсэгт зааснаар Ерөнхийлөгч Улсын Их Хуралд ажлаа хариуцна.

34.2. Ерөнхийлөгч ажлын тайлангаа жил бүр Улсын Их Хуралд ирүүлэх бөгөөд уг тайланг нэгдсэн хуралдаанаар нэг сарын дотор сонсоно.

34.3. Ерөнхийлөгчийн тайлантай холбогдуулж гишүүд асуулт асууж болно.

### **ЗУРГАДГААР БҮЛЭГ**

#### **Албан тушаалтныг томилох, чөлөөлөх, эгүүлэн татах асуудлыг хэлэлцэх журам**

##### **Гучин тав. Ерөнхий сайд, Засгийн газрын гишүүдийг томилох асуудлыг хэлэлцэх журам**

35.1. Ерөнхийлөгч Ерөнхий сайдыг томилуулах саналыг Улсын Их Хуралд өргөн мэдүүлснээс хойш Төрийн байгуулалтын байнгын хороо 3 хоногийн дотор хуралдаж санал, дүгнэлт гаргана.

35.2. Нэгдсэн хуралдаан Ерөнхийлөгчийн танилцуулга, Төрийн байгуулалтын байнгын хорооны санал, дүгнэлтийг сонсож ил санал хураалт явуулж нэр дэвшигчийг гишүүдийн олонхи дэмжсэн бол түүнийг Ерөнхий сайдаар томилох тухай тогтоол батална.

35.3. Байнгын хорооны болон нэгдсэн хуралдаан дээр гишүүд Ерөнхийлөгчийн танилцуулга, Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан, түүнчлэн нэр дэвшигчээс асуулт асууж, үг хэлж болно.

35.4. Нэр дэвшигчийг гишүүдийн олонхи дэмжээгүй бол Ерөнхийлөгч 7 хоногийн дотор өөр хүний нэр дэвшүүлнэ.

35.5. Ерөнхий сайд томилогдсоноосоо хойш 14 хоногийн дотор Засгийн газрын гишүүдийг томилуулах саналаа Улсын Их Хуралд өргөн мэдүүлнэ.

35.6. Байнгын хороод өөрийн эрхлэх асуудлын хүрээнд хамаарах нэр дэвшигчийг өргөн мэдүүлснээс хойш 3 хоногийн дотор хэлэлцэж санал, дүгнэлт гаргана.

35.7. Байнгын хороод Засгийн газрын гишүүнд нэр дэвшигчдийн талаар санал, дүгнэлт

гаргасны дараа нэгдсэн хуралдаан хуралдаж хүн бүрээр хэлэлцэн тус тусад нь ил санал хураалт явуулж олонхийн дэмжлэг авсан нэр дэвшигчдийг Засгийн газрын гишүүнээр томилох тухай нэг тогтоол батална.

35.8. Нэр дэвшигч олонхийн дэмжлэг авч чадаагүй бол Ерөнхий сайд 7 хоногийн дотор өөр хүний нэр дэвшүүлнэ.

35.9. Байнгын хорооны болон нэгдсэн хуралдаан дээр гишүүд Ерөнхий сайд болон нэр дэвшигчээс асуулт асууж, үг хэлж болно.

### **Гучин зургаа. Ерөнхий сайд, Засгийн газар, Засгийн газрын гишүүнийг огцруулах асуудлыг хэлэлцэх журам**

36.1. Ерөнхий сайд, Засгийн газар, Засгийн газрын гишүүнийг огцруулах саналыг Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн бол Ерөнхий сайд, Засгийн газрыг огцруулах саналыг Төрийн байгуулалтын байнгын хороо, Засгийн газрын гишүүнийг огцруулах саналыг холбогдох Байнгын хороо 7 хоногийн дотор хуралдаанаараа хэлэлцэж санал, дүгнэлт гаргана.

36.2. Нэгдсэн хуралдаан Байнгын хорооны санал, дүгнэлт гарснаас хойш 7 хоногийн дотор хуралдаж Байнгын хорооны, хэрэв Цэц дүгнэлт гаргасан бол түүний дүгнэлтийг сонсож илээр санал хураалт явуулж гишүүдийн олонхи дэмжсэн бол огцруулах тухай тогтоол батална.

36.3. Байнгын хорооны болон нэгдсэн хуралдаан дээр гишүүд асуулт асууж, үг хэлж болно.

36.4. Ерөнхий сайд, Засгийн газар, Засгийн газрын гишүүнийг огцруулах асуудлаар нам, эвслийн бүлэг санал, дүгнэлт гаргаж нэгдсэн хуралдаанд танилцуулж болно.

36.5. Ерөнхийлөгч, Ерөнхий сайд нэгдсэн хуралдаан дээр үг хэлж болно.

36.6. Засгийн газар өөрт нь итгэл хүлээлгэж байгаа эсэхийг илэрхийлж өгөхийг хүсч холбогдох тогтоолын төслийг Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн бол энэ зүйлд заасан журмаар хэлэлцэн шийдвэрлэнэ.

### **Гучин долоо. Ерөнхий сайд, Засгийн газрын гишүүдийн тэн хагас нь нэгэн зэрэг огцрох тухай саналыг хэлэлцэх журам**

37.1. Ерөнхий сайд, эсхүл Засгийн газрын гишүүдийн тэн хагас нь нэгэн зэрэг огцрох тухайгаа илэрхийлж Улсын Их Хуралд саналаа өргөн мэдүүлсэн бол Төрийн байгуулалтын байнгын хороо

48 цагийн дотор хуралдаж, Засгийн газрыг бүрэн бүрэлдэхүүнээр нь огцруулах тухай тогтоолын төсөл боловсруулж нэгдсэн хуралдаанд оруулна.

37.2. Төрийн байгуулалтын байнгын хорооны санал, дүгнэлт гарснаас хойш 3 хоногийн дотор нэгдсэн хуралдааныг зохион байгуулж, Засгийн газрыг бүрэн бүрэлдэхүүнээр нь огцруулах тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийг ил санал хураалтаар батална.

37.3. Нэгдсэн хуралдаанд огцрохоо илэрхийлсэн Ерөнхий сайд, эсхүл Засгийн газрын аль нэг гишүүн танилцуулга хийнэ.

37.4. Байнгын хорооны болон нэгдсэн хуралдаан дээр гишүүд Ерөнхий сайд, эсхүл Засгийн газрын гишүүдээс асуулт асууж хариулт авч болох бөгөөд үүнээс өөрөөр хэлэлцүүлэг явуулахгүй.

37.5. Улсын Их Хуралд олонхийн суудал авч Засгийн газар байгуулсан эвсэл Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 25.9-25.11-д заасны дагуу тарсантай холбогдуулж Засгийн газрыг огцруулах асуудлыг Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн бол энэ зүйлд заасан журмаар хэлэлцэн шийдвэрлэнэ.

### **Гучин найм. Цэцийн гишүүдийг томилох, эгүүлэн татах асуудлыг хэлэлцэх журам**

38.1. Ерөнхийлөгч, Улсын Их Хурал, Улсын дээд шүүхээс Цэцийн гишүүнээр томилуулахаар санал болгосон нэр дэвшигчийг Хууль зүйн байнгын хороо хэлэлцэж санал, дүгнэлт гаргана.

38.2. Нэгдсэн хуралдаан нэр дэвшүүлсэн байгууллагын танилцуулга, Хууль зүйн байнгын хорооны санал, дүгнэлтийг сонсож нэр дэвшигч тус бүрээр ил санал хураалт явуулж олонхийн санал авсан нэр дэвшигчийг Цэцийн гишүүнээр томилох тухай тогтоол батална.

38.3. Байнгын хорооны болон нэгдсэн хуралдаан дээр гишүүд нэр дэвшүүлсэн байгууллага болон нэр дэвшигчээс асуулт асууж, үг хэлж болно.

38.4. Цэцийн гишүүнийг эгүүлэн татах бол энэ талаар гарсан Цэцийн дүгнэлт, анх нэр дэвшүүлсэн байгууллагын саналыг энэ зүйлд заасан журмаар хэлэлцэн шийдвэрлэнэ.

### **Гучин ес. Улсын дээд шүүхийн шүүгчдийг Улсын Их Хуралд танилцуулах журам**

39.1. Улсын дээд шүүхийн шүүгчийн сонгон шалгаруулалтад тэнцсэн нэр дэвшигчийн танилцуулгыг Шүүхийн ерөнхий зөвлөл Улсын Их Хуралд ирүүлнэ.

39.2. Нэр дэвшигчийг Шүүхийн ерөнхий зөвлөлийн дарга Хууль зүйн байнгын хорооны болон нэгдсэн хуралдаанд танилцуулна.

39.3. Байнгын хорооны болон нэгдсэн хуралдаан дээр гишүүд Шүүхийн ерөнхий зөвлөлийн дарга болон нэр дэвшигчээс асуулт асууж, үг хэлж болно.

39.4. Байнгын хорооны болон нэгдсэн хуралдаан дээр нэр дэвшигчийн талаар санал хураалт явуулахгүй.

39.5. Нэр дэвшигчийг танилцуулсан талаар Улсын Их Хурлын дарга Ерөнхийлөгчид бичгээр мэдээлнэ.

**Дөч. Улсын ерөнхий прокурор, түүний орлогчийг томилох саналыг Улсын Их Хуралтай зөвшилцөх журам**

40.1. Ерөнхийлөгч Улсын ерөнхий прокурор, түүний орлогч нарыг томилохын өмнө зөвшилцөхөөр Улсын Их Хуралд саналаа ирүүлнэ.

40.2. Хууль зүйн байнгын хороо нэр дэвшигчийг хуралдаанаараа хэлэлцэж санал, дүгнэлт гаргана.

40.3. Нэгдсэн хуралдаан Ерөнхийлөгчийн санал, Хууль зүйн байнгын хорооны санал, дүгнэлтийг хэлэлцэн ил санал хураалт явуулж дүнг Улсын Их Хурлын дарга Ерөнхийлөгчид бичгээр мэдэгдэнэ.

40.4. Нэр дэвшигч олонхийн санал авч чадаагүй бол Ерөнхийлөгч өөр хүнийг санал болгоно.

40.5. Байнгын хорооны болон нэгдсэн хуралдаан дээр гишүүд Ерөнхийлөгчийн санал, Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулж, түүнчлэн нэр дэвшигчээс асуулт асууж, үг хэлж болно.

**Дөчин нэг. Гадаад улсад суух элчин сайд, бүрэн эрхт төлөөлөгчийн газрын тэргүүнийг томилох, эгүүлэн татах саналыг Улсын Их Хуралтай зөвшилцөх журам**

41.1. Ерөнхийлөгч гадаад улсад суух элчин сайд, бүрэн эрхт төлөөлөгчийн газрын тэргүүнийг томилох, эгүүлэн татах саналыг Улсын Их Хуралд зөвшилцөхөөр өргөн мэдүүлсэн бол Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороо 7 хоногийн дотор хуралдаанаараа хэлэлцэж санал, дүгнэлт гаргана.

41.2. Нэгдсэн хуралдаан Ерөнхийлөгчийн санал, Байнгын хорооны санал, дүгнэлтийг сонсож,

ил санал хураалт явуулж, дүнг Улсын Их Хурлын дарга Ерөнхийлөгчид бичгээр мэдэгдэнэ.

41.3. Нэр дэвшигч нэгдсэн хуралдаанд оролцсон гишүүдийн олонхийн дэмжлэг авч чадаагүй бол Ерөнхийлөгч өөр хүний нэрийг дэвшүүлнэ.

41.4. Байнгын хорооны болон нэгдсэн хуралдаан дээр гишүүд Ерөнхийлөгчийн санал, Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан, түүнчлэн нэр дэвшигчээс асуулт асууж, үг хэлж болно.

41.5. Гадаад улсад суух бүрэн эрхт төлөөлөгчийн газрын байршил тогтоох тухай асуудлыг энэ зүйлд заасан журмаар хэлэлцэн шийдвэрлэнэ.

**Дөчин хоёр. Зэвсэгт хүчний жанжин штабын даргыг томилох саналыг Улсын Их Хуралтай зөвшилцөх журам**

42.1. Ерөнхийлөгч Зэвсэгт хүчний жанжин штабын даргыг томилох саналыг Улсын Их Хуралтай зөвшилцөхөөр өргөн мэдүүлсэн бол Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороо 7 хоногийн дотор урьдчилан хэлэлцэж санал, дүгнэлт гаргана.

42.2. Нэгдсэн хуралдаан Ерөнхийлөгчийн санал, Байнгын хорооны санал, дүгнэлтийг сонсон ил санал хураалт явуулж, дүнг Улсын Их Хурлын дарга Ерөнхийлөгчид бичгээр мэдэгдэнэ.

42.3. Нэр дэвшигч гишүүдийн олонхийн санал авч чадаагүй бол Ерөнхийлөгч өөр хүнийг нэрийг дэвшүүлнэ.

42.4. Байнгын хорооны болон нэгдсэн хуралдаан дээр гишүүд Ерөнхийлөгчийн санал, Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан, түүнчлэн нэр дэвшигчээс асуулт асууж, үг хэлж болно.

**Дөчин гурав. Улсын Их Хуралд ажлаа шууд хариуцан тайлагнадаг байгууллагын удирдах албан тушаалтныг томилох, чөлөөлөх асуудлыг хэлэлцэх журам**

43.1. Хууль тогтоомжоор эрх олгогдсон албан тушаалтан Улсын Их Хуралд ажлаа шууд хариуцан тайлагнадаг байгууллагын удирдах албан тушаалтныг томилох, чөлөөлөх санал гаргасан бол холбогдох Байнгын хороо 7 хоногийн дотор хэлэлцэж санал, дүгнэлт гаргана.

43.2. Нэгдсэн хуралдаан эрх бүхий албан тушаалтны санал, холбогдох Байнгын хорооны санал, дүгнэлтийг сонсож ил санал хураалт явуулж хуралдаанд оролцсон гишүүдийн олонхи томилох,

чөлөөлөх саналыг дэмжсэн бол энэ тухай тогтоол батална.

43.3. Томилгодох нэр дэвшигч гишүүдийн олонхийн дэмжлэг авч чадаагүй бол эрх бүхий албан тушаалтан өөр хүнийг санал болгох бөгөөд чөлөөлөх саналыг дэмжээгүй бол уг саналыг дахин оруулж болно.

43.4. Байнгын хорооны болон нэгдсэн хуралдаан дээр гишүүд эрх бүхий албан тушаалтны санал, Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан, түүнчлэн нэр дэвшигчээс асуулт асууж, үг хэлж болно.

## ДОЛДУГААР БҮЛЭГ

### Засгийн газар, холбогдох бусад байгууллагын тайлан, мэдээлэл, илтгэл болон асуулга, асуултын хариуг сонсох, хэлэлцэх журам

#### Дочин дөрөв. Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилт, тайланг хэлэлцэх журам

44.1. Засгийн газар үйл ажиллагааныхаа хөтөлбөрийн хэрэгжилт, тайланг жил бүрийн эхний улиралд Улсын Их Хуралд өргөн мэдүүлнэ.

44.2. Байнгын хороод эрхлэх асуудлынхаа хүрээнд үг хөтөлбөр, тайланг хуралдаанаараа хэлэлцэж санал, дүгнэлт гаргана.

44.3. Нэгдсэн хуралдаан Ерөнхий сайдын илтгэл, Байнгын хороодын санал, дүгнэлтийг сонсож, шаардлагатай гэж үзвэл Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтийг эрчимжүүлэх, үйл ажиллагааг нь боловсронгуй болгох чиглэл бүхий тогтоол гаргаж болно.

44.4. Байнгын хорооны болон нэгдсэн хуралдаан дээр гишүүд Ерөнхий сайд, Засгийн газрын гишүүд, Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан асуулт асууж, үг хэлж болно.

#### Дочин тав. Улсын Их Хуралд ажлаа шууд хариуцан тайлагнадаг байгууллагын тайланг хэлэлцэх

45.1. Улсын Их Хуралд ажлаа шууд хариуцан тайлагнадаг байгууллага жилийн ажлынхаа тайланг дараа оны нэгдүгээр улиралд багтаан Улсын Их Хуралд гишүүдийн тоогоор ирүүлнэ.

45.2. Байнгын хороод тайланг дор дурдсан харьяаллаар хэлэлцнэ:

45.2.1. Үндэсний аудитын газрын тайланг Төсвийн болон Эдийн засгийн байнгын хороо;

45.2.2. Монголбанкны тайланг Эдийн засгийн байнгын хороо;

45.2.3. Төрийн албаны зөвлөлийн тайланг Төрийн байгуулалтын байнгын хороо;

45.2.4. Үндэсний статистикийн газрын тайланг Эдийн засгийн байнгын хороо;

45.2.5. Хүний эрхийн Үндэсний Комиссын илтгэлийг Хууль зүйн байнгын хороо;

45.2.6. Санхүүгийн зохицуулах хорооны тайланг Эдийн засгийн байнгын хороо;

45.2.7. Байгаль орчны төлөв байдлын тайланг Байгаль орчин, хүнс, хөдөө, аж ахуйн байнгын хороо;

45.3. Эрүүгийн хууль тогтоомжийн хэрэгжилтийн талаархи Улсын ерөнхий прокурорын мэдээллийг Хууль зүйн байнгын хороо энэ дэгд заасан журмаар хэлэлцэнэ.

45.4. Байнгын хорооны хуралдаанд тайланг тухайн байгууллагын дарга танилцуулна.

45.5. Байнгын хороо шаардлагатай гэж үзвэл тайлан, мэдээллийг нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх санал, дүгнэлт гаргаж болно.

45.6. Байнгын хороо тайланг хэлэлцсэний үндсэн дээр хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах, зөрчил дутагдлыг засах, ажлаа эрчимжүүлэх чиглэлээр тайлагнасан байгууллагад чиглэл өгсөн тогтоол гаргаж болно.

45.7. Нэгдсэн хуралдаан энэ дэгийн 45.5-д заасны дагуу холбогдох байгууллагын тайлан, Байнгын хорооны санал, дүгнэлтийг хэлэлцэж, шаардлагатай гэж үзвэл тогтоол батлах буюу бусад шийдвэр гаргаж болно.

45.8. Байнгын хорооны болон нэгдсэн хуралдаан дээр гишүүд тайлан, Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан асуулт асууж, үг хэлж болно.

#### Дочин зургаа. Ерөнхий сайд нэгдсэн хуралдаанд мэдээлэл хийх журам

46.1. Хууль тогтоомж, Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр, тухайн жилийн төсөв, үндсэн чиглэлийн хэрэгжилт, улс орны эдийн засаг, нийгэм, санхүүгийн төлөв байдал болон олон нийтийн анхаарал татсан тулгамдсан бусад асуудлаар Улсын Их Хурал дахь цөөнхийн гишүүдээс амаар тавьсан асуултад Ерөнхий сайд

сар бүрийн нэг дэх болон гурав дахь долоо хоногийн Баасан гаригийн нэгдсэн хуралдаан дээр мэдээлэл хийж гишүүдийн асуултад хариулна.

46.2. Ерөнхий сайд энэ дэгийн 46.1-д заасан мэдээлэл хийхэд Засгийн газрын бүх гишүүд байлцана.

46.3. Ерөнхий сайдын мэдээллийг Байнгын хороодын хуралдаанаар урьдчилан хэлэлцэхгүй.

46.4. Ерөнхий сайдын мэдээллийг нэгдсэн хуралдаанаар сонсохоос 7 хоногийн өмнө Улсын Их Хурал дахь цөөнхийн гишүүдэд бичгээр ирүүлнэ.

46.5. Нэгдсэн хуралдаан дээр Ерөнхий сайд 25 минутад багтаан мэдээлэл хийж бөгөөд Ерөнхий сайдын мэдээлэлтэй холбогдуулан цөөнхийн төлөөлөл 25 минутад багтаан үг хэлнэ.

46.6. Энэ дэгийн 46.5-д заасны дагуу Ерөнхий сайд мэдээлэл хийж, цөөнхийн төлөөлөл үг хэлсний дараа цөөнхийн төлөөлөл Ерөнхий сайд, Засгийн газрын гишүүдээс дор дурдсан журмаар үг хэлнэ.

46.6.1. Улсын Их Хурал олонхийн бүлэгтэй бол цөөнхийн бүлгийн, эсхүл 8-аас дээш суудалтай намын төлөөлөл;

46.6.2. Улсын Их Хурал олонхийн бүлэггүй бол Засгийн газрын бүрэлдэхүүнд ороогүй цөөнхийн бүлэг, эсхүл 8-аас дээш суудалтай намын төлөөлөл;

46.6.3. Улсын Их Хурал олонхийн бүлэггүй бөгөөд 8-аас дээш суудал авсан бүх нам, эвсэл Засгийн газарт төлөөлөлтэй бол тэдгээр нам, эвслийн бүлгийн төлөөлөл тус тус 5 минутад багтаан ээлжлэн асуулт асууж, үг хэлж болно.

46.7. Энэ дэгийн 46.6-д заасан асуулт хариулт, үг хэлэх үйл ажиллагааг 1 цаг 30 минутад багтаан зохион байгуулна.

46.8. Ерөнхий сайд шаардлагагүй гэж үзвэл мэдээлэл хийхгүй байж болох боловч асуулт хариултыг энэ дэгийн 46.1-д тогтсон хугацаанд байнга явуулна.

#### **Дочин долоо. Гишүүний асуулгын хариуг хэлэлцэх журам**

47.1. Гишүүн асуулга тавих, түүний хариуг хэлэлцэхдээ Улсын Их Хурлын тухай хуулийн 33.1.2, 33.2-33.6-д заасныг үндэслэн дор дурдсан журмыг баримтална:

47.1.1. гишүүн асуулгын хариуг нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх саналаа Улсын Их Хурлын даргад бичгээр ирүүлэх;

47.1.2. Улсын Их Хурлын дарга нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх тов, дарааллыг Зөвлөлийн саналыг харгалзан тогтоох;

47.1.3. асуулгын хариултыг нэгдсэн хуралдаанаар хэлэлцэхэд тухайн асуудлыг хариуцан хэлэлцүүлэх Засгийн газрын гишүүнийг Ерөнхий сайд Улсын Их Хурлын даргад урьдчилан мэдэгдэх;

47.1.4. нэгдсэн хуралдаан дээр асуултад хариулах хугацаа 5 минутаас илүүгүй, гишүүд асуулгын хариулттай холбогдуулж асуулт асуух хугацаа 3 минутаас илүүгүй байх;

47.1.5. асуултад хариулт өгсний дараа асуулга тавьсан гишүүн нэг удаа 5 минутаас илүүгүй хугацаанд үг хэлэх.

47.2. Асуулгын хариуг ээлжит чуулганы үеэр сар бүрийн хоёр дахь, дөрөв дэх долоо хоногийн Баасан гаригийн 15 цагаас нэгдсэн хуралдаанаар хэлэлцэх бөгөөд энэхүү үйл ажиллагааг хэвлэл мэдээллийн хэрэгслээр шууд дамжуулна.

#### **Дочин найм. Гишүүний асуултын хариуг хэлэлцэх журам**

48.1. Гишүүн асуулт тавих, түүний хариуг хэлэлцэхдээ Улсын Их Хурлын тухай хуулийн 33.1.3, 33.7-33.10-т заасныг үндэслэн дор дурдсан журмыг баримтална:

48.1.1. асуултын хариулт нь бичгийн А4 хэмжээний 1 хуудаснаас илүүгүй байх;

48.1.2. гишүүн асуултын хариуг бичгээр авсны дараа түүнийг Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцүүлэх саналаа Байнгын хорооны даргад бичгээр ирүүлэх;

48.1.3. Байнгын хорооны дарга асуултын хариуг Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцэх товгыг гишүүний саналыг харгалзан Зөвлөлд танилцуулж шийдвэрлэх;

48.1.4. Байнгын хорооны хуралдаан дээр асуултын хариуг холбогдох албан тушаалтан 3 минутаас илүүгүй хугацаанд өгөх ба гишүүд 3 минутаас илүүгүй хугацаанд асуулт асуух.



48.1.5. холбогдох албан тушаалтан асуултад хариулсны дараа асуулт тавьсан гишүүн 1 минутас илүүгүй хугацаанд үг хэлэх, тавьсан асуулттайгаа холбоотой өөр асуулт асуух.

48.2. Асуултын хариуг сонсох ажиллагааг олон нийтэд мэдээлнэ.

### **Дочин ес. Байнгын хорооны хуралдаанаар Засгийн газрын гишүүдийн мэдээлэл сонсох**

49.1. Засгийн газрын гишүүд хагас жил тутам хууль тогтоомж, Улсын Их Хурлаас баталсан бодлогын баримт бичгийн болон Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр, тухайн жилийн төсөв, үндсэн чиглэлийн хэрэгжилтийн талаархи тайланг холбогдох Байнгын хороонд ирүүлнэ.

49.2. Байнгын хороод Улсын Их Хурлын тухай хуулийн 20 дугаар зүйлд заасан харьяаллаар Засгийн газрын гишүүдийн тайланг хуралдаанаараа хэлэлцэнэ.

49.3. Тайланг хэлэлцэх үед гишүүд асуулт асууж, үг хэлж болно.

49.4. Байнгын хороо Засгийн газрын гишүүний тайланг хэлэлцэхэд, шаардлагатай гэж үзвэл хууль тогтоомж, Улсын Их Хурлаас баталсан бодлогын баримт бичгийн хэрэгжилтийг хангуулах чиглэлээр тогтоол гаргаж болно.

49.5. Байнгын хороо шаардлагатай гэж үзвэл тайлангийн дүнтэй холбогддуулан зохих журмын дагуу хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэрийн төсөл боловсруулж нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлж болно.

### **Тавь. Монгол Улсын нийгэм, эдийн засгийн болон Засгийн газрын санхүүгийн байдлын талаар Улсын Их Хурал олон нийтэд мэдээлэх**

50.1. Засгийн газар Улсын Их Хурлын сонгуулийг зарлахаас 1 сараас доошгүй хугацааны өмнө Монгол Улсын нийгэм, эдийн засгийн болон Засгийн газрын санхүүгийн байдлын талаархи мэдээллийг Улсын Их Хуралд ирүүлнэ.

50.2. Энэ дэгийн 50.1-д заасан мэдээллийг нэгдсэн хуралдаанд Ерөнхий сайд танилцуулна.

50.3. Мэдээлэлтэй холбогддуулан гишүүд асуулт асууж, үг хэлж болно.

50.4. Улсын Их Хурал мэдээлэлтэй танилцсаны дараа Төсвийн байгууллагын удирдлага, санхүүжилтийн тухай хуулийн 36 дугаар зүйлд заасны дагуу улсын эдийн засгийн гол үзүүлэлтийн талаар олон нийтэд мэдээлэл хийнэ.

## **НАЙМДУГААР БҮЛЭГ**

### **Бусад асуудал**

**Тавин нэг. Хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэрийн эцсийн найруулгыг Улсын Их Хуралд танилцуулах, ёсчлох, хэвлэн нийтлэх, мэдээлэх журам**

51.1. Энэ дэгд заасны дагуу батлагдсан хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэрийн эцсийн найруулга хийх, ёсчлох ажиллагааг дараахь журмаар гүйцэтгэнэ:

51.1.1. холбогдох Байнгын хороо, Улсын Их Хурлын Тамгын газрын эцсийн найруулга хийсэн хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэрийг Тамгын газрын Ерөнхий нарийн бичгийн дарга хянаж Улсын Их Хурлын даргад эцсийн хувилбарыг танилцуулах;

51.1.2. Улсын Их Хурлын дарга энэ дэгийн 51.1.1-д заасны дагуу ирүүлсэн хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэрийн эцсийн найруулгыг хянаж Улсын Их Хуралд танилцуулахыг зөвшөөрөх;

51.1.3. Улсын Их Хурал энэ дэгийн 51.1.2-т заасан хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэрийн эцсийн найруулгатай танилцаж ёсчлохыг зөвшөөрөх.

51.2. Улсын Их Хурлын дарга болон Тамгын газрын Ерөнхий нарийн бичгийн дарга энэ дэгийн 51.1.1, 51.1.2-т заасны дагуу эцсийн найруулгыг хянахдаа түүний агуулга, бодлого, зарчмыг алдагдуулахгүйгээр зөвхөн найрлага, үг хэллэг, дэс дараалал, бүтцийн шинжтэй засвар хийж болно.

51.3. Хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэрийн эцсийн найруулга хийж Улсын Их Хуралд танилцуулах хугацааг түүний хэмжээ, цар хүрээ, холбогдох Байнгын хорооны саналыг харгалзан Улсын Их Хурлын дарга тогтооно.

51.4. Хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэрийн эцсийн найруулгыг энэ дэгийн 51.1.3-т заасны дагуу Улсын Их Хуралд танилцуулснаас хойш Улсын Их Хурлын дарга ажлын 3 өдрийн дотор түүнд гарын үсэг зурж ёсчилно.

51.5. Энэ дэгийн 51.4-т заасны дагуу ёсчилсон хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэрийг Улсын Их Хурлын Тамгын газар 24 цагийн дотор Ерөнхийлөгчийн Тамгын газарт илгээнэ.

51.6. Энэ дэгийн 51.5-д заасны дагуу илгээсэн төслийг Ерөнхийлөгчийн Тамгын газар хүлээж авсан өдрөөс хойш ажлын 5 өдөрт багтаан Ерөнхийлөгч тухайн хууль, Улсын Их Хурлын бусад

шийдвэрийг бүхэлд нь букуу түүний зарим хэсэгт хориг тавих эсэх асуудлыг шийдвэрлэнэ.

51.7. Ерөнхийлөгч энэ дэгийн 51.6-д заасны дагуу хориг тавьсан бол Улсын Их Хурал түүнийг хүлээж авснаас хойш дараалал харгалзахгүйгээр тэргүүн ээлжинд, тэгэхдээ ажлын 14 өдрийн дотор нэгдсэн хуралдаанаар хэлэлцэх бөгөөд түүнд оролцсон нийт гишүүний гуравны хоёр нь хоригийг хүлээн зөвшөөрөөгүй бол тухайн хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэр хүчин төгөлдөр мөрдөгдөнө.

51.8. Ерөнхийлөгч Улсын Их Хурлын ээлжит болон ээлжит бус чуулганы чөлөөт цагт хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэрт хориг тавьсан бол түүнийг ээлжит болон ээлжит бус чуулган эхэлснээс хойш энэ дэгийн 51.7-д заасан хугацаанд хэлэлцэн шийдвэрлэнэ.

51.9. Үндсэн хуульд заасан онцгой нөхцөл байдал үүссэн, эсхүл Улсын Их Хурлын ээлжит чуулганы хугацаа өндөрлөхтэй холбогдуулан Улсын Их Хурал Ерөнхийлөгчийн хориг тавих хугацааг энэ дэгийн 51.6-д зааснаас өөрөөр тогтоож болно.

51.10. Хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэрийг "Төрийн мэдээлэл" эмхтгэлд хэвлэн нийтлэх бөгөөд түүнийг албан ёсны эх гэж үзнэ.

51.11. Хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэрийг олон нийтэд таниулах, сурталчлах ажлыг холбогдох Байнгын хороо Тамгын газартай хамтран зохион байгуулна.

## **Тавин хоёр. Чуулганы хуралдааны тэмдэглэл хотлох, түүнийг хадгалах, ашиглах журам**

52.1. Нэгдсэн болон Байнгын, дэд түр хороо, ажлын хэсэг, нам, эвслийн бүлгийн хуралдааны явцыг бичгээр болон соронзон хальсанд нэгэн зэрэг, шаардлагатай бол дуу, дүрс бичлэгийн хэрэгсэл ашиглан тэмдэглэж /цаашид "хуралдааны тэмдэглэл" гэх/ хадгална.

52.2. Хуралдааны тэмдэглэлд дараахь баримт бичгийг хавсарган хадгална:

52.2.1. тухайн хуралдаанаар хэлэлцэх асуудлын төлөвлөгөө, хуралдаанд урилгаар оролцсон болон байлцсан хүмүүсийн нэр, албан тушаал;

52.2.2. хуралдаанаар хэлэлцсэн хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэрийн төсөл /хувилбарууд/, тэдгээрийн үзэл баримтлал, танилцуулга, хавсаргасан санал, судалгаа бусад баримт бичиг;

52.2.3. хэлэлцэж байгаа асуудлаар гишүүд ажлын хэсэг, бусад Байнгын, дэд түр хороо, нам, эвслийн бүлгээс холбогдох Байнгын хороонд бичгээр ирүүлсэн саналын томъёолол,

тэдгээрийн үндэслэл, тооцоо, судалгааг тайлбарласан баримт бичиг;

52.2.4. ажлын хэсгээс Байнгын, дэд түр хороонд, Байнгын хороо, нам, эвслийн бүлгээс нэгдсэн хуралдаанд оруулсан санал, дүгнэлт, санал хураалгах томъёоллын төсөл;

52.2.5. хэлэлцэж байгаа асуудалтай холбогдуулан Улсын Их Хурал, гишүүдэд иргэд, байгууллагаас ирүүлсэн санал, сонордуулга, мэдэгдэл, цахилгаан утас;

52.2.6. гишүүн хуралдааны тэмдэглэлд тусгайлан тэмдэглүүлэхээр бичгээр гаргасан санал.

52.3. Хуралдааны гар /бичгийн/ тэмдэглэлд дараахь зүйлийг заавал тусгана:

52.3.1. хуралдаан эхэлсэн, завсарласан, дууссан болон асуудлыг хэлэлцэж эхэлсэн, дууссан он, сар, өдөр, цаг, минут.

52.3.2. хэлэлцсэн төсөл буюу асуудал, түүнийг танилцуулсан албан тушаалтан, ажлын хэсгийн бүрэлдэхүүн;

52.3.3. хэлэлцэж байгаа асуудалтай холбогдуулан гишүүдээс тавьсан асуулт, түүний хариулт, түүнчлэн гишүүдээс гаргасан санал, шүүмжлэл, хэлсэн үг;

52.3.4. санал хураалтын дүн /тоо, хувиар/, хэрэв нэрээр санал хураасан бол гишүүн бүрийн нэр, өгсөн санал;

52.3.5. хуралдааны ирц /тоо, хувиар/, хуралдаанд ирээгүй гишүүний нэр, шалтгаан;

52.3.6. хуралдаанд хоцорч ирсэн, чөлөө авсан, өвчтэй байсан, тасалсан гишүүний нэр;

52.3.7. гишүүний тусгайлан тэмдэглүүлэхээр хэлсэн үг.

52.4. Гишүүний хэлсэн үгийг хуралдааны тэмдэглэлд тодорхой тусгах бөгөөд тусгайлан тэмдэглүүлэхээр хэлсэн үгийг тухайн гишүүнээр хянуулж гарын үсэг зуруулна.

52.5. Гишүүн хүсвэл хуралдааны тэмдэглэлтэй аливаа хязгааргүйгээр танилцах эрхтэй бөгөөд төрийн нууцад хамрагдсан хуралдааны тэмдэглэлтэй танилцсан бол нууцлалыг задруулахгүй байх бүх талын арга хэмжээ авна.

52.6. Хууль санаачлагчаас өргөн мэдүүлсэн болон нэгдсэн хуралдааны анхны,

эцсийн хэлэлцүүлгийн дүнг тусгасан төслүүдийг гарсан шийдвэрийн хамтаар дарааллаар нь байршуулан дугаарлаж, хуралдааны гар тэмдэглэлд заавал хавсаргана.

52.7. Нэгдсэн хуралдааны тэмдэглэлтэй Тамгын газрын Ерөнхий нарийн бичгийн дарга, Байнгын, дэд, түр хорооны хуралдааны тэмдэглэлтэй холбогдох хорооны дарга, ажлын хэсгийн хуралдааны тэмдэглэлтэй түүний ахлагч тус тус танилцаж гарын үсэг зурна.

52.8. Хуралдаанаар хэлэлцсэн асуудлыг энэ дэгд заасан журмаар эмхэлж архивын нэг нэгж болгон товъёоглож, архивын тухай хууль тогтоомжид заасан ногдол, журмын дагуу хадгална.

52.9. Хууль тогтоомж, бүлгийн дүрэмд өөрөөр заагаагүй бол Улсын Их Хурал дахь нам, эвслийн бүлгийн хуралдааны тэмдэглэлийг энэ дэгд заасан журмын дагуу хөтлөх бөгөөд түүнийг хадгалах, ашиглах, архивын нэгж болгох, архивт шилжүүлэх журмыг бүлэг өөрөө тогтооно.

### Тавин гурав. Хуралдааны тэмдэглэлийг ашиглах, хадгалах журам

53.1. Хуралдааны бичвэр болон соронзон тэмдэглэлийг чуулганы мэдээлэл бэлтгэж нийтлэх, хэвлэл мэдээллийн байгууллагад мэдээлэл, лавлагаа өгөх, маргаантай асуудлыг шийдвэрлэх зорилгод ашиглана.

53.2. Нэгдсэн хуралдааны тэмдэглэлийг Улсын Их Хурлын номын санд болон Улсын Их

Хурлын үйл ажиллагааг орон нутагт сурталчлах сүлжээнд байршуулж олон нийт танилцах бололцоог хангана.

53.3. Хуралдааны бичвэр, соронзон болон дуу, дүрс бичлэгийн тэмдэглэлтэй гишүүд, Тамгын газрын ажилтнууд шууд, бусад байгууллагын ажилтан, албан тушаалтан Тамгын газрын Ерөнхий нарийн бичгийн даргын зөвшөөрснөөр танилцаж болно.

53.4. Энэ дэгийн 53.3-т заасан тэмдэглэлтэй гишүүд, Тамгын газрын ажилтан 7 хоног хүртэл хугацаагаар танилцаж болох бөгөөд зөвшөөрөлгүйгээр олшруулах, хувилахыг хориглоно.

53.5. Бусад байгууллагын ажилтан энэ дэгийн 53.3-т заасан тэмдэглэлтэй Тамгын газрын архив танилцана.

53.6. Энэ дэгийн 53.3-т заасан тэмдэглэлийг Тамгын газрын архивт хадгалах бөгөөд түүнийг хадгалах, ашиглах нарийвчилсан журмыг Тамгын газрын Ерөнхий нарийн бичгийн дарга, архивын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын дарга хамтран батална.

53.7. Төрийн нууцтай холбоотой асуудал хэлэлцсэн хуралдааны тэмдэглэл, түүнчлэн төрийн нууцад хамрагдсан баримт бичгийг архивын нэгж болгох, тэдгээрийг ашиглах, хадгалах асуудлыг төрийн нууцын хууль тогтоомж, тэдгээрийн дагуу батлагдсан журам, дүрэм, зааврын дагуу зохицуулна.

## МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2006 оны 1 дүгээр сарын 27-ны өдөр

Дугаар 15

Улаанбаатар хот

### Монгол Улсын Их Хурлын Байнгын хорооны бүрэлдэхүүнийг шинэчлэн батлах тухай

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 22.1, 22.2, Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн 12.2 дахь хэсгийг тус тус үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1. Монгол Улсын Их Хурлын Байнгын хороодыг дараахь бүрэлдэхүүнтэйгээр шинэчлэн байгуулсугай.

#### 1/ Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороо:

1. Ренчиннямын Амаржаргал
2. Цогтын Батаа
3. Сүхбаатарын Батболд
4. Лүймэдийн Гансүх

5. Лувсанямын Гантөмөр
6. Раднаасүмбэрэлийн Гончигдорж
7. Жүгдэрдэмидийн Гүррагчаа
8. Долоонжингийн Идэвхтэн
9. Цэндийн Мөнх-Оргил
10. Лувсангийн Одончимэд
11. Сайнбуянгийн Отгонбаяр
12. Кадырын Саираан
13. Дэндэвийн Тэрбишдагва
14. Цэрэнхүүгийн Шаравдорж
15. Миеэгомбын Энхболд

16. Мэндсайханы Энхсайхан
17. Ономоогийн Энхсайхан
18. Равжихийн Эрдэнэбүрэн

**2/ Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хороо:**

1. Горчинсүрэнгийн Адъяа
2. Агыпарын Бакей
3. Батжаргалын Батбаяр
4. Сундуйн Батболд
5. Халтмаагийн Баттулга
6. Гаваагийн Батхүү
7. Рэнцэнгийн Буд
8. Ламжавын Гундалай
9. Цэрэндашийн Дамирэн
10. Гомбожавын Занданшатар
11. Рэгжийбуугийн Нямсүрэн
12. Доржийн Одбаяр
13. Чойжамцын Раднаа
14. Ядамсүрэнгийн Санжмятав
15. Чойнзонгийн Содномцэрэн
16. Цэгмидийн Цэнгэл
17. Батаагийн Цэрэнбалжир
18. Ономоогийн Энхсайхан

**3/ Нийгмийн бодлого, боловсрол, соёл, шинжлэх ухааны байнгын хороо:**

1. Чилхаажавын Авдай
2. Батын Батбаатар
3. Бадмаанямбуугийн Бат-Эрдэнэ
4. Цэвэлмаагийн Баярсайхан
5. Төгсжаргалын Ганди
6. Лүймэдийн Гансүх
7. Даваажавын Ганхуяг
8. Долцонгийн Дондог
9. Самбуугийн Ламбаа
10. Бүдээгийн Мөнхтуяа
11. Рэгжийбуугийн Нямсүрэн
12. Санжаасүрэнгийн Оюун
13. Кадерын Саираан
14. Ядамсүрэнгийн Санжмятав
15. Цэндийн Сүхбаатар

16. Данзандаржаагийн Туяа
17. Аюурзанын Цанжид
18. Баатарын Эрдэнэсүрэн

**4/ Төрийн байгуулалтын байнгын хороо:**

1. Дашжамцын Арвин
2. Рагчаагийн Бадамдамдин
3. Түнжингийн Бадамжунай
4. Нямжавын Батбаяр
5. Эрдэнийн Бат-Үүл
6. Дашдэмбэрэлийн Бат-Эрдэнэ
7. Сангажавын Баярцогт
8. Жүгдэрдэмидийн Гүррагчаа
9. Долцонгийн Дондог
10. Дамдины Дэмбэрэл
11. Мөнхчулууны Зоригт
12. Долоонжингийн Идэвхтэн
13. Самбуугийн Ламбаа
14. Данзангийн Лүндээжанцан
15. Цэндийн Нямдорж
16. Дүрээгийн Одохүү
17. Раднаабазарын Раш
18. Чойнзонгийн Содномцэрэн
19. Данзандаржаагийн Туяа
20. Аюурзанын Цанжид
21. Бадарчийн Эрдэнэбат

**5/ Төсвийн байнгын хороо:**

1. Горчинсүрэнгийн Адъяа
2. Ричиннямын Амаржаргал
3. Рагчаагийн Бадамдамдин
4. Түнжингийн Бадамжунай
5. Агыпарын Бакей
6. Жамъяндоржийн Батхуяг
7. Төгсжаргалын Ганди
8. Дамдины Дэмбэрэл
9. Базарсадын Жаргалсайхан
10. Гомбожавын Занданшатар
11. Аукетайн Мурат
12. Жанлавын Наранцацралт
13. Сайнбуянгийн Отгонбаяр

- |                               |                              |
|-------------------------------|------------------------------|
| 14. Түвдэнгийн Очирхүү        | 1. Чилхаажавын Авдай         |
| 15. Санжаасүрэнгийн Оюун      | 2. Дашжамцын Арвин           |
| 16. Лханаасүрэнгийн Пүрэвдорж | 3. Цогтын Батаа              |
| 17. Чойжамцын Раднаа          | 4. Батжаргалын Батбаяр       |
| 18. Чүлтэмийн Улаан           | 5. Нямжавын Батбаяр          |
| 19. Батаагийн Цэрэнбалжир     | 6. Сүхбаатарын Батболд       |
| 20. Зандаахүүгийн Энхболд     | 7. Гаваагийн Батхүү          |
| 21. Баатарын Эрдэнэсүрэн      | 8. Дашдэмбэрэлийн Бат-Эрдэнэ |

**6/ Хууль зүйн байнгын хороо:**

1. Батын Батбаатар
2. Халтмаагийн Баттулга
3. Эрдэнийн Бат-Үүл
4. Жамъяндоржийн Батхуяг
5. Бадмаанямбуугийн Бат-Эрдэнэ
6. Надмидийн Баяртсайхан
7. Сангажавын Баярцогт
8. Раднаасүмбэрэлийн Гончигдорж
9. Цэрэнгийн Жаргал
10. Данзангийн Лүндээжанцан
11. Цэндийн Мөнх-Оргил
12. Цэндийн Нямдорж
13. Мишигийн Сонөмпил
14. Цэндийн Сүхбаатар
15. Ухнаагийн Хүрэлсүх
16. Цэрэнхүүгийн Шаравдорж
17. Зандаахүүгийн Энхболд
18. Нямаагийн Энхболд
19. Равжихийн Эрдэнэбүрэн

**7/ Эдийн засгийн байнгын хороо:**

10. Рэнцэнгийн Буд
  11. Лувсанямын Гантөмөр
  12. Даваажавын Ганхуяг
  13. Цэрэндашийн Дамирэн
  14. Цэрэнгийн Жаргал
  15. Мөнхчулууны Зоригт
  16. Бүдээгийн Мөнхтуяа
  17. Аукетайн Мурат
  18. Дүрээгийн Одхүү
  19. Түвдэнгийн Очирхүү
  20. Лханаасүрэнгийн Пүрэвдорж
  21. Раднаабазарын Раш
2. Энэ тогтоол гарсантай холбогдуулан "Монгол Улсын Их Хурлын Байнгын хорооны бүрэлдэхүүнийг шинэчлэн батлах тухай" Улсын Их Хурлын 2004 оны 12 дугаар сарын 02-ны өдрийн 25 дугаар тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.
3. Энэ тогтоолыг 2006 оны 01 дүгээр сарын 27-ны өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН**

**ИХ ХУРЛЫН ДАРГА**

**Ц.НЯМДОРЖ**

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ**

2006 оны 2 дугаар сарын 3-ны өдөр

Дугаар 22

Улаанбаатар хот

**Монгол Улсын Их Хурлын дэд хорооны бүрэлдэхүүний тухай**

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 24 дүгээр зүйлийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1. Монгол Улсын Их Хурлын дэд хороодыг дараахь бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай:

**1/ Үс зүйн дэд хороо:**

- 1/ Дашжамцын Арвин
- 2/ Сангажавын Баярцогт
- 3/ Жүгдэрдэмидийн Гүррагчаа
- 4/ Самбуугийн Ламбаа
- 5/ Дүрээгийн Одхүү
- 6/ Данзандаржаагийн Туяа

7/ Чойзонгийн Содномцэрэн

8/ Аюурзанын Цанжид

## 2/ Жижиг, дунд үйлдвэрлэлийн хөгжлийн дэд хороо:

1/ Чилхаажавын Авдай

2/ Батжаргалын Батбаяр

3/ Сүхбаатарын Батболд

4/ Рэнцэнгийн Буд

5/ Цэрэндашийн Дамиран

6/ Мөнхчулууны Зоригт

7/ Бүдээгийн Мөнхтуяа

8/ Дүрээгийн Одхүү

9/ Лханаасүрэнгийн Пүрэвдорж

## 3/ Мянганы хөгжлийн зорилтууд болон ядуурлыг бууруулах асуудлын дэд хороо:

1/ Цэвэлмаагийн Баярсайхан

2/ Бүдээгийн Мөнхтуяа

3/ Рэгжийбуугийн Нямсүрэн

4/ Санжаасүрэнгийн Оюун

5/ Ядамсүрэнгийн Санжмятав

6/ Цэндийн Сүхбаатар

7/ Данзандаржаагийн Туяа

8/ Баатарын Эрдэнэсүрэн

## 4/ Нутгийн удирдлагын дэд хороо:

1/ Дашжамцын Арвин

2/ Түнжингийн Бадамжунай

3/ Эрдэнийн Бат-Үүл

4/ Дагдэмбэрэлийн Бат-Эрдэнэ

5/ Дамдины Дэмбэрэл

6/ Самбуугийн Ламбаа

7/ Дүрээгийн Одхүү

8/ Раднаабазарын Раш

## 5/Төсвийн зарлагын хяналтын дэд хороо:

1/ Рагчаагийн Бадамдамдин

2/ Агьларын Бажей

3/ Жамъяндоржийн Батхуяг

4/ Гомбожавын Занданшатар

5/ Түвдэнгийн Очирхүү

6/ Лханаасүрэнгийн Пүрэвдорж

7/ Чойжамцын Раднаа

8/ Зандаахүүгийн Энхболд

## 6/ Тусгай хяналтын дэд хороо:

1/ Сүхбаатарын Батболд

2/ Лүймэдийн Гансүх

3/ Долоонжингийн Идэвхтэн

## 7/ Улсын Их Хурлын гишүүний халдашгүй байдлын дэд хороо:

1/ Раднаасүмбэрэлийн Гончигдорж

2/ Дамдины Дэмбэрэл

3/ Данзангийн Лүндээжанцан

4/ Түвдэнгийн Очирхүү

## 8/ Хүний эрхийн дэд хороо:

1/ Батын Батбаатар

2/ Эрдэнийн Бат-Үүл

3/ Бадмаанямбуугийн Бат-Эрдэнэ

4/ Цэрэнхүүгийн Шаравдорж

5/ Равжихийн Эрдэнэбүрэн

2. Энэ тогтоолыг 2006 оны 02 дугаар сарын 03-ны өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН**
**ИХ ХУРЛЫН ДАРГА Ц.НЯМДОРЖ**

Монгол Улсын Их Хурлын Тамгын газраас гаргав.  
Хаяг: <<Төрийн мэдээлэл>> эмхтгэлийн зөвлөл.

Улсын Их Хурлын Тамгын газрын  
Хэвлэх хэсэгт хэвлэв.

Улаанбаатар-12  
Төрийн ордон

☎ 265956  
Индекс: 14003

☎ 329487

Хэвлэлийн хуудас 4.5

